



Төгс эзэмших сургаал

Шинэ Гэрээний сургаалын багшийн гарын авлага

Шинэ Гэрээний Төгс эзэмших сургаалыг заах багшийн материал

Санал хүсэлт ба залруулгыг талархан хүлээн авна. Та саналаа дараах хаягаар илгээнэ үү:

Seminaries and Institutes of Religion Curriculum Services

50 E North Temple Street

Salt Lake City, UT 84150-0008 USA

Э-мэйл хаяг: ces-manuals@ldschurch.org

Та овог нэр, хаяг, гадас, тойргоо бичнэ үү. Та санал хүсэлтээ илгээхдээ тухайн гарын авлагын нэрийг бичихээ бүү мартаарай.

© 2016 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Анхны хэвлэл, 3/16

Англи эхийн зөвшөөрөл: 1/16

Орчуулгын зөвшөөрөл: 1/16

Doctrinal Mastery New Testament Teacher Material-ын орчуулга

Mongolian

13231 363

Агуулга

Багш нарт зориулсан удирдамж	v
Сүнслэг мэдлэг олж авах нь	1
Бурхан Тэргүүтэн	12
Авралын төлөвлөгөө	16
Есүс Христийн Цагаатгал	23
Сэргээлт	29
Бошиглогчид ба илчлэлт	34
Санваар ба санваарын түлхүүрүүд	40
Ёслолууд ба гэрээнүүд	46
Гэрлэлт ба гэр бүл	49
Зарлигууд	56

Багш нарт зориулсан удирдамж

Шашны институт, семинар зорилгоо “Бид суралцагчдад сайн мэдээний сургаал, зарчмуудыг бошиглогчдын үгс болон судрууд дээр байгаагаар заадаг” (*Сайн мэдээг заах ба судлах нь: Шашны семинар ба институтын багш, удирдагчдад зориулсан гарын авлага* [2012], х) хэмээн тодорхойлсон байдаг. Семинарт үүнийг үндсэндээ тухайн номнуудын болон судрын номны шүлгүүдийг эхнээс нь дуустал урсгалаар нь дагаж, судруудыг дэс дарааллын дагуу судалснаар гүйцэтгэж болдог. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Энэ бол амийн усыг олж авах хамгийн чухал бөгөөд үндсэн зарчим юм” хэмээн онцолсон байна (“A Reservoir of Living Water” [Залуучуудад зориулсан Сүмийн боловсролын системийн галын дэргэдэх ярилцлага, 2007 оны 2-р сарын 4], 3; lds.org/broadcasts).

Есүс Христийн сургаалыг ойлгож, итгэж, үүний дагуу амьдрахад нь суралцагчдадаа тусалдаг бидний өөр нэгэн арга зам бол төгс эзэмших сургаал юм. Төгс эзэмших сургаал нь Шашны институт, семинарын өмнөх хүчин чармайлтууд болох төгс эзэмших судар болон үндсэн сургаалыг судлах судалгаан дээр суурилж, үүнийг орлож байгаа юм. Төгс эзэмших сургаал нь дараах үр дүнд хүрэхэд суралцагчдад туслах зорилготой. Үүнд:

1. Сүнслэг мэдлэг олж авахад туслах тэнгэрлэг зарчмуудыг мэдэж авч, амьдралдаа хэрэгжүүлэх
2. Есүс Христийн сайн мэдээний сургаал, сургаалыг зааж буй судрын хэсгийг төгс эзэмших зэрэг юм. Бид ялангуяа дараах есөн сэдэвтэй холбоотой сургаал дээр анхаарлаа хандуулна. Үүнд:
 - Бурхан Тэргүүтэн
 - Авралын төлөвлөгөө
 - Есүс Христийн Цагаатгал
 - Сэргээлт
 - Бошиглогчид ба илчлэлт
 - Санваар ба санваарын түлхүүрүүд
 - Ёслолууд ба гэрээнүүд
 - Гэрлэлт ба гэр бүл
 - Зарлигууд

Шашны институт, семинар нь эдгээр үр дүнд хүрэхэд багш, суралцагчдад туслах зорилгоор удирдамж болох материалуудыг бэлтгэсэн. Эдгээр материалд *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*, Төгс эзэмших сургаалыг заах багшийн материал багтана. (*Тэмдэглэл*: Төгс эзэмших сургаалыг заах багшийн материалыг семинарын дөрвөн ангид бүгдэд нь ашиглах боломжтой.

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал нь суралцагчдад зориулагдсан юм. Энэ нь (1) Төгс эзэмших сургаал гэж юу болох, энэ нь тэдэнд хэрхэн тусалж болохыг тайлбарласан оршил хэсэг, (2) сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг тэдэнд заах удирдамж, (3) дээрх сургаалын сэдвүүдийн хэсгээс бүрдэнэ. Сургаалын сэдэв бүрийн дор суралцагчдын амьдралд хамаатай мөн ойлгож, итгэж, хэрэгжүүлэхэд чухал сургаалын мэдэгдлүүдийг оруулсан.

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” мөн “Сургаалын сэдвүүд” хэсгүүд дээрх сургаал, зарчмын зарим хэсгийг төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдээр дэмжсэн байгаа. Судлах анги бүр сургаалын төгс эзэмших 25 судрын хэсэгтэй (Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Сүмийн түүх) ба нийтдээ 100 хэсгээс бүрддэг. Энэ хэсгүүдийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын ард хавсаргасан болно. Суралцагчдаа эдгээр хэсгийг санаж, олоход нь мөн энэ хэсгүүд Аврагчийн сургаалыг хэрхэн заадгийг ойлгоход туслах нь багш хүний хувьд таны ажлын чухал хэсэг юм.

Төгс эзэмших сургаалын 100 судрын хэсэг бүрийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх зөвхөн сургаалын нэг мэдэгдлийг шууд дэмжихэд ашигладаг. Жишээ нь, Иосеф Смит—Түүх 1:15–20-ийг **Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христ Иосеф Смитийн залбирлын хариуд түүнд үзэгдсэн бөгөөд Тэд түүнийг Сэргээлтийн бошиглогчоор дуудсан** хэмээх үнэнийг дэмжихийн тулд сургаалын дөрөв дэх сэдэв болох “Сэргээлт” дээр эш татсан байна. Гэхдээ энэ төгс эзэмших сургаалын хэсэг нь мөн **Бурхан Тэргүүтэн бол Бурхан Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ, Ариун Сүнс гэсэн тусдаа гурван хүн болно** хэмээх сургаалын 1 дэх сэдэв болох “Бурхан Тэргүүтэн” дээрх үнэнийг дэмжихийн тулд ашиглагдаж болно. Тиймээс, төгс эзэмших сургаалын энэ хэсгийг тэр сэдвийн холбогдох эшлэл болгосон байна.

Төгс эзэмших сургаалын хэсэг бүр хаана эш татагдсаныг тэмдэглэж авах нь тухайн хэсэг энэ жил судлах Төгс эзэмших сургаалыг заах багшийн материалын аль суралцах туршлага дээр гарахыг мэдэхэд танд туслах болно. Өмнөх жишээгээр бол Иосеф Смит—Түүх 1:15–20 нь *Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг заах төгс эзэмших сургаалыг заах багшийн материал*-ын “Сэргээлт”-ийн суралцах туршлага дээр гарах болно.

Сайн мэдээний сэдэв болгон жил бүр чухалд тооцогддоггүй. Сургаалын сэдэв болгоныг жил бүр хамруулах боловч тухайн жилийн судлах курстэй холбогдуулан төгс эзэмших сургаалын хэсгүүдээр дэмжигдэж буй сургаалын зөвхөн тодорхой мэдэгдлүүдийг тэр жилийн төгс эзэмших сургаалын хичээлүүд дээр онцолно.

Төгс эзэмших сургаалыг заах багшийн материал

Төгс эзэмших сургаалын гарын авлага нь хичээлийн жилийн турш заагдах 10 суралцах туршлагыг багтаадаг. Суралцах туршлага бүрийг заах заавар бүхий материалыг нэгээс илүү хичээлээр заах шаардлага гарч болох юм.

Хамгийн анхны суралцах туршлага нь суралцагчдад сүнслэг мэдлэг олж авахтай холбоотой зарчмуудыг мэдэж авч, хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Үүнийг тухайн хичээлийн жилийн эхний хоёр долоо хоногт багтааж заана. Энэ нь суралцагчдад төгс эзэмших сургаалын тухай ойлголттой болоход туслах болно. Үүнээс гадна энэ суралцах туршлагаар заагддаг зарчмууд нь хичээлийн жилийн үлдсэн хугацаанд заагдах дараагийн есөн туршлага дээр үндэслэн, давтагдах үндэс сууриар хангах юм.

Дараа дараагийн суралцах туршлага бүр өмнө нь жагсаасан есөн сургаалын сэдвийн нэгэн дээр тулгуурлана. Эдгээр нь Аврагчийн сургаалыг илүү гүн гүнзгий ойлгож, үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх илүү их хүсэлтэй болоход суралцагчдад туслах зорилготой юм. Эдгээр суралцах туршлага бүр “Сургаалыг ойлгох нь,” “Дасгал ажлууд,” “Төгс эзэмших сургаалыг давтах” гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Сургаалыг ойлгох нь. Суралцах туршлага бүрийн энэ хэсэг нь нэг ба түүнээс дээш хичээл дээр заагдаж болох суралцах үйл ажиллагааны цуврал эсвэл хэсгээс бүрдэнэ. Эдгээр үйл ажиллагаа нь суралцагчдад сургаалын сэдэв бүрийг мөн сэдэв бүртэй холбоотой сургаалын тодорхой мэдэгдлүүдийг илүү гүн гүнзгий ойлгоход тусална.

“Сургаалыг ойлгох нь” үйл ажиллагаанууд ихэвчлэн *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх тухайн сургаалын сэдвийг судалснаар эхлэх юм. Үүнээс гадна энэ үйл ажиллагаанууд нь тухайн жилийн судлах ангийн судрын зөвхөн төгс эзэмших судрын хэсгүүдтэй хамаатай тодорхой мэдэгдлүүд дээр төвлөрдөг. Жишээ нь, *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Бурхан Тэргүүтэн”-ий суралцах туршлага дээр багш нараас Еврей 12:9-ийг төгс эзэмшихэд нь суралцагчдадаа туслахыг хүсдэг. Суралцагчид семинарт хамрагдах жилүүддээ Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Сүмийн түүхээс судалснаар *Төгс эзэмших сургаалын үндсэн материал*-ын “Бурхан Тэргүүтэн” сэдэвтэй холбоотой сургаалын бусад мэдэгдлийг дэмждэг төгс эзэмших сургаалын бусад хэсэг дээр төвлөрнө.

“Сургаалыг ойлгох нь” үйл ажиллагаан дээр суралцагчдыг төгс эзэмших сургаалын хэсгүүдийг олж, тэмдэглэж, судлахад урамшуулдаг. Ингэснээр тэд тухайн хэсгүүдийн дэмждэг сургаалын мэдэгдлүүдийг зааж, тайлбарлахдаа тэдгээрийг ашиглаж болно. Та шаардлагатай бол сургаалын мэдэгдэл, тэдгээрийг дэмждэг төгс эзэмших сургаалын хэсгүүдийг төгс эзэмшихэд суралцагчдад туслахын тулд нэмэлт суралцах үйл ажиллагаануудыг төлөвлөж болно.

Дасгал ажлууд. Суралцах туршлага бүр суралцагчдыг дадлага хийх доод тал нь нэг боломжоор хангаж өгдөг. Энэ үйл ажиллагаанууд нь ерөнхийдөө нөхцөлт судалгаа, жүжигчилсэн тоглолт, үйл явдал, жижиг бүлэг эсвэл ангиараа ярилцаж болох асуултуудаас бүрдэж болно. Эдгээр үйл ажиллагаа нь суралцагчдын сурч байгаа сургаалын мэдэгдлүүд орчин үеийн нөхцөл байдалд хэрхэн хамаатай болохыг ойлгоход нь тэдэнд туслах чухал үүрэгтэй юм. Дасгалууд нь суралцагчдын сурсан сургаал тэдэнд сайн мэдээний дагуу амьдарч, үүнийг заахад мөн итгэл үнэмшлээ бусдад тулгаж, гомдоохгүй арга замаар хуваалцахад тэднийг хэрхэн адисалж, тусалж чадахыг онцолдог билээ.

Төгс эзэмших сургаалын тойм. Сургаалын мэдэгдэл болон тэднийг дэмжихэд ашиглагддаг төгс эзэмших сургаалын хэсгүүдийг үе үе давтах нь суралцагчдыг сургаалыг төгс эзэмшихээр хичээж чармайхад туслах болно. Суралцах туршлага бүрд суралцагчдын энэ хичээлийн жилийн турш сурсан сургаалын мэдэгдэл, холбогдох төгс эзэмших сургаалын хэсгийг давтахад тэднийг удирдахад туслах санаануудыг багтаасан нэг хэсэг бий.

Төгс эзэмших сургаалыг хэрэгжүүлэх

Төгс эзэмших сургаал нь өдрийн семинар (өглөөний болон чөлөөт цагийн хөтөлбөртэй), онлайн семинар, гэрээр судлах семинар гэх мэт суралцагчдын бүртгүүлсэн семинарын хөтөлбөрийн төрлөөс шалтгаалан өөр өөрөөр хэрэгждэг.

Өдрийн семинарын төгс эзэмших сургаал

Таныг хичээлийн жилийн турш төгс эзэмших сургаал дээр долоо хоногт дунджаар 30 минут зарцуулна гэж үздэг. 10 суралцах туршлага бүрд зарцуулсан долоо хоногийн тоо нь сургаалын мэдэгдэл, уг сургаалын сэдвээр онцолж судлах төгс эзэмших сургаалын хэсгүүдийн тооноос хамаарч өөр өөр байна. Зарим сэдвийг хоёр долоо хоногт хангалттай багтаадаг байхад заримыг дуусгахад нэмэлт хугацаа хэрэгтэй болдог (Доор байгаа “Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хуваарьт удирдамж”-ийг үзнэ үү).

Төгс эзэмших сургаалыг суралцах туршлага бүрийн “Сургаалыг ойлгох нь” хэсэг ерөнхийдөө 5-10 минутад багтаан хийж болох суралцах үйл ажиллагаануудаас (хэсгүүдээс) бүрдэнэ. Энэ нь Төгс эзэмших сургаалыг заах уян хатан боломжийг олгодог. Жишээ нь, та нэг өдөр хичээлийнхээ турш нэг юм уу хоёр суралцах үйл ажиллагааг багтаахаар төлөвлөж, өөр нэг өдөр нь төгс эзэмших сургаалд цаг үлдээлгүйгээр судрын хэсгүүдийг заахад хичээлийнхээ бүх цагийг зарцуулж болох юм. Зарим суралцах үйл ажиллагаа илүү их цаг хугацаа шаарддаг учраас та тэднийг багшийн чөлөөт өдрөөр хийхээр төлөвлөж болно (Багшийн гарын авлагын хавсралт хэсэгт байгаа “Өдрийн семинарын багш нарт зориулсан хуваарьт удирдамж” ба “Чөлөөт өдрөөр санал болгосон үйл ажиллагаанууд”-ыг үзнэ үү).

Та төгс эзэмших сургаалын хэсгээр судрын гол хэсгүүдийг сэдэвчлэн заахаас гадна судрыг дэс дарааллын дагуу суралцагчидтайгаа хамт судлах үед төгс эзэмших сургаалууд гарч ирвэл тэдгээрийг онцлон хэлэх ёстой. Ингэх нь суралцагчдад судрын хэсэг бүрийн агуулга, хам сэдвийн талаар илүү гүн ойлголттой болж мөн хэсэг бүрийн зааж буй үнэнүүдийн ач холбогдлыг илүү нэмэгдүүлэхэд туслах юм.

Өдрийн семинарт төгс эзэмших сургаал нь төгс эзэмших судрын хөтөлбөр дээр үндэслэж мөн үүнийг орлодог. Өмнө нь төгс эзэмших судрын хэсгүүд гэж тодорхойлогддог байсан төгс эзэмших сургаалын эдгээр хэсгийн хувьд *Шинэ Гэрээний семинарын багшийн гарын авлага* суралцагчидтайгаа хамт судрыг дэс дарааллаар нь судлахад тухайн хэсэгт зохих ач холбогдол өгөхөд танд туслах зөвлөгөө, суралцах үйл ажиллагаануудыг агуулдаг. Төгс эзэмших сургаалын хэсгүүд байхгүй байгаа газруудад багшийн гарын авлага нь ийм хэсгүүдийг

тодорхойлохгүй бөгөөд судрыг дэс дарааллын дагуу судалж байхдаа хэсгүүдийг үр дүнтэй, зохих ёсоор олж тогтоох нь таны хувьд чухал зүйл байх болно.

Тэмдэглэл: Судрын зарим хэсэг *Шинэ Гэрээний семинарын багшийн гарын авлага* дээр төгс эзэмших сургаалын хэсгээр биш, төгс эзэмших судрын хэсгээр тодорхойлогддог. Эдгээр хэсэг нь тухайн гарын авлагад төгс эзэмших судрын удирдамжийн дагуу дахин онцлон тэмдэглэгдэхгүй хэдий ч тэдгээрийг судрын дэс дарааллын дагуу судлах үед дурдах ёстой.

Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хуваарьт удирдамж

Шинэ Гэрээний 10 суралцах туршлага бүрд зарцуулсан долоо хоногуудын тоо нь тухайн сургаалын сэдвээр судлах сургаалын онцлог, судрын хэсгийн тооноос шалтгаалан өөр өөр байдаг. Дараах суралцах үйл ажиллагаануудыг ашиглан төгс эзэмших сургаал дээр долоо хоногт дунджаар 30 минут зарцуул.

- Сургаалын хэсгүүдийг ойлгох нь
- Дасгал ажлууд
- Төгс эзэмших сургаалын тойм үйл ажиллагаанууд

Жишээ нь, доорх хуваарьт удирдамж дээр Бурхан Тэргүүтэнтэй холбоотой төгс эзэмших сургаалын үйл ажиллагаанд хоёр долоо хоногийг оноосон. Та эхний долоо хоногийн даваа гарагт “Сургаалыг ойлгох нь” хэмээх хамгийн эхний хэсгийг хийж болно. Та мягмар гарагт хоёр, гурав дахь хэсгүүдийг хийж мөн лхагва гарагт өөрийн төлөвлөсөн гурваас таван минутын төгс эзэмших үйл ажиллагааг эсвэл *Шинэ Гэрээний семинарын багшийн гарын авлага*-ын хавсралт дээрх материалаас сонгож болно. Пүрэв гарагт та төгс эзэмших сургаалын үйл ажиллагааг хийхгүй байхыг сонгож болно. Учир нь та судрын хэсгийг заахын тулд хичээлийн бүх цагаа зарцуулах хэрэгтэй. Харин та баасан гарагт 4 дэх “Сургаалыг ойлгох нь” хэсгийг зааж болно. Хоёр дахь долоо хоногийн хувьд та багшийн сонгосон нэмэлт төгс эзэмших судрын үйл ажиллагаа, дасгал ажил, “Сургаалыг ойлгох нь” үйл ажиллагаануудыг хийж болно.

Ирэх долоо хоногийнхоо *Шинэ Гэрээний семинарын багшийн гарын авлага* дээрх сургалтын материалыг болон *Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалыг заах багшийн материал* дээрх төгс эзэмших сургаалаас суралцах үйл ажиллагаануудыг харах нь Төгс эзэмших сургаал заах төлөвлөгөө гаргаж, хичээлийн цагаа хуваарилахад тань туслах болно. Та Төгс эзэмших сургаалаас суралцах үйл ажиллагаа, дасгал ажлуудад цаг гаргахын тулд нэгтгэн дүгнэж болох хичээлийн хэсгүүдийг тодорхойлж болох юм.

Дараах хуваарьт удирдамж нь *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээр байдаг дэс дарааллын дагуу сургаалын онцлогуудыг багтаах арга барил дээр үндэслэсэн байдаг. Гэхдээ “Сүнслэг мэдлэг олж авах нь” суралцах туршлага нь эхлээд заагдсан бол бусад сургаалын сэдэв ямар ч дарааллаар заагдаж болно. Дараах хоёр аргыг авч үзээрэй.

- *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх дэс дарааллын дагуу сургаалын сэдвүүдийг заа (“Бурхан Тэргүүтэн”-ээр эхэлж, “Зарлигууд”-аар дуусга).
- Боломжтой бол суралцагчдын судалж байгаа сургаалын сэдвийг ням гаргийн цуглаанууд дээр суралцаж байгаа сэдэвтэй нь уялдуул.

Долоо хоног	Сургаалын сэдвүүд
1	Сүнслэг мэдлэг олж авах нь
2	
3	
4	
5	Бурхан Тэргүүтэн
6	
7	Авралын төлөвлөгөө
8	
9	
10	
11	
12	
13	Цагаатгал
14	
15	
16	
17	Сэргээлт
18	
19	
20	Бошиглогчид ба илчлэлт
21	
22	
23	
24	Санваар ба санваарын түлхүүрүүд
25	
26	Ёслолууд ба гэрээнүүд
27	
28	Гэрлэлт ба гэр бүл
29	
30	Зарлигууд
31	

Долоо хоног	Сургаалын сэдвүүд
32	

Онлайн семинарын төгс эзэмших сургаал

Төгс эзэмших сургаалын суралцах үйл ажиллагаануудыг онлайн семинарын хичээлүүдтэй холбож болно. Хэрэв та онлайн семинарын ангийн хичээл заадаг бол онлайн семинарын орчинд дасан зохицож, хэрэгжиж болох чухал зарчим, арга барилыг ойлгоход тань туслах “Өдрийн семинарын төгс эзэмших сургаал” дээрх өмнөх хэсгүүдийг харах нь тустай байх болно.

Гэрээр судлах семинарын төгс эзэмших сургаал

Одоогоор гэрээр судалдаг багш, суралцагчдын ашигладаг материалууд төгс эзэмших сургаалын агуулгыг багтааж шинэчлэгдээгүй байна. Тиймээс багш, суралцагчид одоогийн гэрээр судлах материал болон агуулгад орсон төгс эзэмших судрын үйл ажиллагаануудыг үргэлжлүүлэн ашиглах хэрэгтэй. Гэрээр судлах материалыг шинэчлэх хүртэл *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ыг суралцагчдадаа хувиран өгч, үүнийг болон төгс эзэмших судрын хэсгүүдийг бие даан судлахад тэднийг дэмжээсэй хэмээн бид багш нарыг урамшуулж байна.

Сүнслэг мэдлэг олж авах нь

1-р хэсэг (40 минут зарцуул)

Тэмдэглэл: 1, 2-р хэсгийг 40 минут үргэлжлэх хоёр хичээлээр эсвэл 80 минут үргэлжлэх нэг хичээлээр холбож зааж болно.

Мөнхийн үнэний эрэлд

Самбарт Үнэн гэдэг үгийг бичиж, суралцагчдаас асуу.

- Үнэнийг нээн илрүүлэх юм уу олж мэдэх нь яагаад хэцүү байдаг вэ?

Цөөн суралцагчийг хариулсны дараа *Би үнэнийг хэрхэн олж мэдэж чадах вэ?* гэсэн асуултыг самбарт бич.

Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Сохор эрс ба заан” хэмээх эртний сургаалт үлгэрийг хуваалцан, үнэнийг мэдэж авах нь хэцүү хэмээн хэлсэн гэдгийг тайлбарла.

Та ерөнхийлөгч Угдорфын хэлсэн дараах үгийг үзүүлж эсвэл суралцагч бүрд хувилж өгч болно. Нэг суралцагчаас хэлсэн үгийг чанга уншихыг хүс. Ангийнхныг дагуулж уншаад, үнэнийг эрэлхийлэх үед бидэнд тулгардаг зарим бэрхшээлийг энэ сургаалт үлгэр хэрхэн харуулж байгааг олж мэдэхэд урь.



“100 гаруй жилийн өмнө Америкийн нэгэн зохиолч эртний сургаалт үлгэрийг шүлэглэсэн байдаг. Шүлгийн эхний мөрөнд ийн өгүүлсэн байдаг.

*Ихэд ухаантай
Индостаны зургаан эр
(Хэдийгээр бүгд сохор байсан ч)
Өөрсдийн төсөөлөлд
Зааныг олж
харахыг хүсжээ.*

“Шүлэгт тэдгээр зургаан эр бүгд зааны өөр өөр хэсгээс барьж үзэн, бусдадаа юу мэдэрснээ хэлжээ.

Тэдний нэг нь зааны хөлийг барьж үзээд, түүнийг мод шиг дугуй хатуу гэж дүрсэлжээ. Харин нөгөөдөх нь зааны соёог барьж үзээд, зааныг хурц үзүүртэй жадтай адилтгажээ. Өөр нэг нь сүүлийг нь тэмтэрч үзээд, зааныг олстой зүйрлэсэн байна. Дөрөв дэх эр зааны хошууг барьж үзээд, заан бол аварга том могой шиг гэжээ.

Бүгд л үнэнийг хэлж байсан.

Тэд өөрсдийн туршлагаар үнэнийг олж мэдсэн болохоор олж мэдсэн зүйлээ зөв хэмээн зүтгэж байлаа.

Шүлэг ийн төгсжээ.

*Индостаны энэ эрс
Удаан хугацаанд маргалджээ.
Бүгд л өөр өөрийн санаа бодолд*

Бат зогсож байлаа.

Хэдийгээр зарим талаар тэдний зөв байсан ч

Бүгд бурууджээ!

[Жон Годфри Сакс, The Poems of John Godfrey Saxe (1873), 135–136, books.google.com]."

("Үнэн гэж юу вэ?" (Сүмийн Боловсролын Системийн онцгой цугларалт, 2013 оны 1-р сарын 13, lds.org/broadcasts.)

- Энэ сургаалт үлгэр үнэнийг нээн илрүүлэхэд тохиолддог зарим бэрхшээлийг хэрхэн харуулж байна вэ?
- Үнэнийг нээн илрүүлэхээр эрэлхийлэх үед өөр ямар сорилтууд тулгардаг вэ?
- Сохор эрсэд заан гэж юу болох талаар илүү нарийн зүйлийг ойлгоход юу тусалж болох байсан бэ? (Жишээ нь, зааныг бүхэлд нь харж чадах хэн нэгнээс тусламж авах.)

Бурхан мөнхийн үнэний эх сурвалж мөн

Суралцагчид семинарт хамрагдсанаар мөнхийн үнэний талаарх ойлголтоо өсгөн нэмэгдүүлэх олон боломжоор хангагдах болно гэдгийг тайлбарла. Суралцагчдад үүнийг үр дүнтэй хийхэд туслахын тулд Төгс эзэмших сургаал хөтөлбөрийг танилцуулж байна. Энэ хөтөлбөр нь сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг мэдэж авч, хэрэгжүүлэхээр эрэлхийлэх мөн Есүс Христийн сайн мэдээний үндсэн сургаалын тухай ойлголтоо илүү гүнзгийрүүлэх үйл явцыг багтаадаг.

Суралцагчдад *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ыг хувилж өгч, "Сүнслэг мэдлэг олж авах нь" хэсгийг гаргахыг хүс. Тэднийг эхний догол мөрийг дотроо уншаад, мөнхийн үнэний эх сурвалжийг олж мэдэхэд урь.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Та тэдэнд **Бурхан бүхнийг мэддэг бөгөөд бүх үнэний эх сурвалж мөн** гэсэн сургаалыг тэмдэглэхийг санал болгож болно.

Суралцагчдад энэ сургаалыг илүү сайн ойлгоход туслахын тулд нэг суралцагчийг Мозая 4:9-ийг чанга уншихад урь. Ангийнхныг дагуулж уншаад, энэ шүлэг бидэнд бүх үнэний эх сурвалж болох Бурханд найдаж болох шалтгааныг ойлгоход хэрхэн тусалж байгааг олж мэдэхийг хүс.

- Яагаад Бурхан үнэний цорын ганц найдвартай эх сурвалж болохыг энэ шүлэг дээрх ямар үг, хэллэг дүрсэлж байна вэ?
- Яагаад бүх үнэний эх сурвалж болох Бурханд найдах нь чухал гэж та бодож байна вэ? (Үнэнийг олж мэдэхийн тулд хаана хандахаа мэддэг байх нь үүнийг олж авах анхны алхмуудын нэг гэдгийг ойлгоход суралцагчдад тусал.)

Сүнслэг мэдлэг хэрхэн олж авах тухай

Нэг суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын "Сүнслэг мэдлэг олж авах нь" хэсгийн эхний догол мөрний сүүлийн өгүүлбэрийг болон

хоёр дахь догол мөрийг бүтнээр нь уншихад урь. Суралцагчдыг дагуулж уншаад, Бурханыг сүнслэг үнэнийг илчлэхэд урихын тулд бид юу хийж болох талаар олж мэдэхийг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Суралцагчдад сүнслэг мэдлэг олж авахын тулд юу хийх ёстойгоо илүү сайн ойлгоход нь туслахын тулд ангийг дөрвөн бүлэг болгон хуваагаад, бүлэг бүрд дараах төгс эзэмших сургаалын хэсэг эсвэл багц хэсгүүдээс нэгийг оноо.

- Моронай 10:4–5
- Иохан 7:17
- Иаков 1:5–6; 2 Нифай 32:8–9
- 2 Тимот 3:15–16; 2 Нифай 32:3

Оногдсон шүлгүүдээ бүлгээрээ хамтдаа уншиж мөн дараах асуултуудыг ашиглан уншсан зүйлсээ ярилцах таван минут тэдэнд байгааг тайлбарла. (Та эдгээр асуултыг самбар дээр үзүүлж эсвэл тараах материал болгон өгч болно.)

1. Сүнслэг үнэнийг эрэлхийлэх ямар зарчмыг энэ шүлгүүд дээр зааж байна вэ?
2. Сүнслэг үнэнийг хэрхэн эрэлхийлэхээ илүү сайн ойлгоход тань эдгээр шүлэг хэрхэн тусалж байна вэ?
3. Та сүнслэг үнэнийг олж авах загварын энэ хэсгээс ямар туршлагатай болсон бэ?

Бүлгүүдэд хангалттай цаг гаргаж өгсний дараа, ярилцсан зүйлээ ангийнхантай хуваалцахад бүлгийн нэг гишүүнийг урь. Бүлэг бүр олж мэдсэн зүйлсээ хуваалцах үедээ тэдний шүлгүүд сүнслэг мэдлэг олж авах үйл явцын аль хэсгийг зааж байгааг хуваалцаж байгаа эсэхийг анхаар.

Бүлэг бүрийг хуваалцсаны дараа та сүнслэг үнэнийг олж авахтай холбоотой нэмэлт ойлголт, туршлагуудыг ангийнхнаасаа асууж болно. Дараах асуултыг тавих талаар бодож үз.

- Сүнслэг мэдлэг олж авахад бидэнд туслах үнэнийг эрэлхийлэх эдгээр арга зам бүр нэг нэгэнтэйгээ хэрхэн уялдаж байна вэ?

Нэг суралцагчийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скоттын хэлсэн дараах үгийг чанга уншихад урь. Ангийнхнаас ахлагч Скоттын заасан ямар зарчим сүнслэг мэдлэг олж авахад шаардлагатай болохыг олж сонсохыг хүс.



“Агуу үнэ цэнтэй мэдлэг олж авахын тулд хувийн зүгээс ер бусын хичээл чармайлт гаргах шаардлагатай. Энэ нь ялангуяа биднийг сүнслэг мэдлэг олж авахыг хүсэх үед үнэн байдаг” (“Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 87).

- Яагаад Их Эзэн биднээс сүнслэг мэдлэг олж авахаасаа өмнө өөрсдийн зүгээс хичээж чармайхыг шаарддаг гэж та бодож байна вэ?
- Таны туршлагаар, бидний Тэнгэрлэг Эцэг; Түүний Хүү Есүс Христийн болон Тэдний сургаалын үнэн байдлын талаар гэрчлэх сүнслэг мэдлэгийг олж авахад таны гаргасан хүчин чармайлт яагаад ийм үнэ цэнтэй байдаг вэ?

Сүнслэг мэдлэг олж авахад бид өөрсдийн зүгээс хамгийн сайнаараа хичээж чармайх хэрэгтэй байдгийг гэрчил. Тэнгэрлэг Эцэг бидэнд заахад бэлэн байдаг ч бид хийвэл зохих зүйлээ хийхэд бэлэн байх ёстой.

Асуулт тавьж, хариулт эрэлхийлэх нь үнэнийг мэдэж авахад гаргах бидний хүчин чармайлтын амин чухал хэсэг юм

Нэг суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн гурав дахь догол мөрийг чанга уншихад урь. Суралцагчдыг дагуулж уншаад, сүнслэг мэдлэг олж авахын тулд бидний асуулт тавих хүчин чармайлтын ач холбогдлын талаар энэ догол мөр юу зааж байгааг олж мэдэхийг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүсээд, **Асуулт тавьж, хариултаа тууштай эрэлхийлэх нь үнэнийг мэдэж авахад гаргах бидний хүчин чармайлтын амин чухал хэсэг юм** гэсэн үнэний тухай товч дүгнэлтийг самбарт бич.

- Үнэнийг мэдэж авахаар хичээх үед гарч ирсэн асуултуудын хариултыг хичээнгүйлэн эрэлхийлэх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

Сүнслэг мэдлэг олж авах энэ талын ач холбогдлыг ойлгоход суралцагчдадаа туслахын тулд нэг суралцагчийг ерөнхийлөгч Томас С.Монсоны дараах хэлсэн үгийг чанга уншихад урь. Ерөнхийлөгч Угдорфын зөв асуулт тавих талаар заасан зүйлсийг олж сонсохыг ангийнхнаас хүс. (Та энэ хэлсэн үгийн хувийг суралцагчдад өгч болно.)



“Бид сүнслэг үнэний хувьд өөрсдийгөө зөв зам дээр байгааг хэрхэн мэдэх вэ?

Үүнийг хийх нэг арга зам нь бидэнд өөрсдийн өсөлт хөгжлийг тунгаан бодож, аливаа зүйлс бидэнд хэр ашиг тусаа өгч байгааг үнэлж дүгнэхэд туслах зөв асуултуудыг өөрсдөдөө тавих явдал юм. Тухайлбал:

“Миний амьдрал утга учиртай байна уу?”

‘Та Бурханд итгэдэг үү?’

‘Тэрээр намайг мэддэг, хайрладаг гэдэгт би итгэдэг үү?’

‘Тэрээр залбирлыг минь сонсож, хариулдаг гэдэгт би итгэдэг үү?’

‘Би үнэхээр аз жаргалтай байна уу?’

‘Миний хичээл зүтгэл намайг амьдралын минь хамгийн том зорилго, утга учир руу хөтөлж байна уу?’

Эдгээр гүн гүнзгий утга учиртай асуултууд нь дэлхий даяарх олон хувь хүн, гэр бүлийг үнэнийг хайхад хөтөлсөн. Ихэнхдээ энэхүү эрэл хайгуул нь тэднийг Есүс Христийн Хожмын

Үеийн Гэгээнтнүүдийн Сүм рүү болон сэргээгдсэн сайн мэдээ рүү хөтөлсөн байдаг" ("Сайн мэдээ ашиг тусаа өгдөг!" *Ensign*, 2015 оны 11-р сар, 20-21 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 3-4).

- Ерөнхийлөгч Угдорфын хэлсэн энэ мэдэгдэл зөв асуулт тавихын ач холбогдлыг илүү сайн ойлгоход бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Суралцагчдадаа зөв асуулт тавьж, хариултуудыг хичээнгүйлэн эрэлхийлэх нь хувь хүмүүсийг сүнслэг мэдлэг олж авахад хэрхэн хөтөлснийг харуулсан судрын жишээнүүдийг бодож олж чадах эсэхийг тэднээс асуу. (Дараах жишээнүүд байж болно. Үүнд: Иосеф Смит—Түүх 1:10–20; Инос 1:1–8; Сургаал ба Гэрээ 138:1–11).

“Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн гурав дахь догол мөрний төгсгөлд байгаа: **Асуулт тавьж, хариулт эрэлхийлэхдээ харуулж буй хандлага, зорилго нь Ариун Сүнсээр дамжуулан суралцах бидний чадварт ихээхэн нөлөөлнө** гэсэн зарчмыг онцол. Та суралцагчдад *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ынхаа хуулбар дээр энэ зарчмыг тэмдэглэхийг санал болгож болно.

Чин сэтгэлээсээ асуух эсвэл хэн нэгний зан байдлыг зөвтгөх эсвэл шүүмжлэх, хэн нэгнийг мэхлэхийн тулд асуулт тавихын ялгааг харуулахын тулд суралцагчдыг хоёр хоёроороо Зиезромын эхний тавьсан асуултуудыг Алма, Амюлек хоёрын гэрчлэлийг сонссоныхоо дараа тавьсан асуултуудтай харьцуулахад урь. Нэг суралцагчийг Алма 10:31–32; 11:21-ийг, нөгөө суралцагчийг Алма 12:8-ыг бие даан судлахад урь. Суралцагчдыг чин үнэнч байдлын талаар болон Зиезромын асуултын цаад санааны тухай мэдэж авсан зүйлсээ хамтрагчдаа тайлбарлаж өгөхийг хүс. Суралцагчдыг оногдсон шүлгүүдээ хамтрагчтайгаа ярилцсаных нь дараа ангийнханд дараах асуултуудыг тавь.

- Зиезромын тавьсан эхний асуултууд болон Алма, Амюлек хоёрын гэрчлэлийг сонссоны дараа тавьсан асуултууд хоёрын хооронд учир шалтгаан, хандлагын ямар ялгаа гарсан бэ?
- Алма 12:8-д цэдэглэснээр Алма, Амюлек хоёрын гэрчлэлийг сонссоныхоо дараа Зиезром ямар төрлийн үнэнийг эрэлхийлж байсан бэ? (Зиезромд Алма, Амюлек хоёрыг сонссоны дараа асуулт байсаар байсан ч асуултуудынх нь мөн чанар өөрчлөгдсөн байсан гэдгийг онцлон хэл. Зиезром “Бурханы хаант улсын талаар илүүг мэдэж болохын тулд тэрээр тэднээс шаргуугаар лавлаж эхлэв.”)

Алма 12–13 дээр заасан гайхалтай сургаалын ихэнх хэсэг нь асуусны үр дүнд ирсэн гэдгийг тайлбарла. Эдгээр асуулт, хариулт нь эцэстээ Зиезромд Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөхөд тусалсан (Алма 14:6; 15:3–12-ыг үзнэ үү).

Та чин сэтгэлээсээ асуух болон хариултуудаа шаргуу эрэлхийлэхийн ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалцаж болно. Их Эзэн бидний чин сэтгэлийн асуултуудад хариулна гэдгийг хэрхэн мэдэж авснаа хуваалцах талаар бодож үз.

2-р хэсэг (40 минут зарцуул)

Сургаалын эсвэл түүхэн асуултуудад хариулах нь

Нэг суралцагчийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэрын хэлсэн дараах үгийг чанга уншихад урь.



“Залуу хүмүүс яагаад зарим зүйлийг хийх, зарим зүйлийг хийхгүй байх зарлигууд байдаг талаар гайхдаг.” (“The Great Plan of Happiness” [Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1993 оны 8-р сарын 10], si.lds.org).

Суралцагчдаас яагаад зарим зүйлийг хийх, зарим зүйлийг хийхгүй байх зарлигууд байдаг талаар гайхаж байсан эсэхээ бодож үзэхийг хүс. Жишээ нь, зарим нь Бурхан яагаад бидэнд Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихыг зарлигласныг эсвэл яагаад бэлгийн харьцаа нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр, нөхрийн хооронд байх ёстой гэж зарлигласныг гайхаж болох юм. Сүнслэг мэдлэг олж авах тухай хичээлийн энэ хэсэг нь суралцагчдад асуух зүйл гарсан үед эсвэл бусад хүн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн сургаал, зан үйл, түүхтэй холбоотой асуулт тавьсан үед удирдан чиглүүлэх зарчмуудыг мэдэж авахад тэдэнд туслах зорилготой гэдгийг онцлон хэл.

Суралцагчдад үнэний эх сурвалжийн талаар мэдэж авсан сургаалын тухай болон сүнслэг мэдлэг хэрхэн олж авах тухай сануул. Бурхан бүхнийг мэддэг бөгөөд бүх үнэний эх сурвалж мөн. Энэ үнэнийг санах нь ойлгоход бэрх Сүмийн тухай асуултуудтай тулгарах үед тус болдог.

Дараах зарчмыг дэлгэн харуул эсвэл самбар дээр бич.

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үз.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл.*

Биднийг мөнхийн үнэнийг олж мэдэн, ойлгож, асуулт эсвэл асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлэх үед энэ зарчмууд биднийг удирдан чиглүүлэх болно гэдгийг тайлбарла.

Итгэлээр үйлд

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн “Итгэлээр үйлд” хэмээх 1-р зарчмыг дотроо уншихад урь. Сүмийн талаар өөрсдөд нь болон бусад хүнд байгаа асуултуудад хариулахад тэдэнд туслах зарчмуудыг олж, тэмдэглэхийг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Хэрэв тэд хэлэхгүй бол, **Бид ойлголтоо хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлж байхдаа Есүс Христ, Түүний сайн мэдээний сэргээлт, томилсон бошиглогчдын нь сургаал зэргийн талаар аль хэдийн бий болсон гэрчлэл дээрээ тулгуурлах нь зүйтэй** гэсэн зарчмыг онцлон хэл.

- Бид хэцүү асуулт, асуудлуудаа ойлгохыг мөн тэдгээрт хариулт авахыг чин сэтгэлээсээ эрэлхийлбэл эдгээр зарчим бидэнд хэрхэн тусалж чадна гэж та бодож байна вэ?

Суралцагчдыг асуудал, санаа зовоосон зүйлс, асуулт зэрэгтэй тулгарах үед эдгээр зарчмын аль нэг нь тэдэнд тусалж байсан жишээнээс хуваалцахад урь.

Нэг суралцагчийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэны хэлсэн дараах үгийг уншихад урь. Нэгэн залуу эмэгтэй хэцүү нөхцөл байдалтай тулгарсан үедээ хэрхэн итгэлээр үйлдсэнийг олж сонсохыг ангийнхнаас хүс.



“Би Нэгдсэн Улсад амьдардаг, Лоорэлын насны нэг охинтой саяхан ярилцсан юм. Би түүний э-мэйлээс эш татан уншъя.

‘Өнгөрсөн жил манай зарим найз фэйсбүк дээр гэрлэлтийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн юм. Олонх нь ижил хүйстний гэрлэлтийг дэмжиж, хэд хэдэн ХҮГ өсвөр үеийнхэн үүн дээр “Like” дарсан байв. Би ямар нэгэн сэтгэгдэл үлдээгээгүй.

Би сайтар бодсоны эцэст уламжлалт гэрлэлтийн талаарх өөрийн итгэл үнэмшлийн талаар хуваалцахаар шийдлээ.

Би “Би эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтэд итгэдэг” гэж өөрийн профайл зурган дээр гарчиг нэмэв. Тэгтэл тэр даруй би мессеж хүлээн авч эхэлсэн юм. “Чи бол хувиа бодогч.” “Чи бол шүүмжлэгч.” Нэг нь намайг боолчлогчтой адилтгаж байв. Сүмийн сайн гишүүн, дотны найз маань хүртэл “Чи цаг үетэйгээ хөл нийлүүлэх хэрэгтэй. Юм бүхэн өөрчлөгдөж байна. Чи ч гэсэн өөрчлөгдөх хэрэгтэй” гэж бичсэн байв.

Би тэдэнтэй дахин тэмцэлдээгүй ч бичсэн үгсээ арилгаагүй’ гэж тэр хэлсэн юм.

Тэрээр ерөнхийлөгч Монсоны хэлснээр заримдаа ‘та нар ганцаар зогсох ёстой’ хэмээн төгсгөсөн байв. Өсвөр үеийнхний хувьд бид Бурханы болон Түүний амьд бошиглогчдын сургаалуудад үнэнч байж, хамтдаа зогсоно гэдэгт найдаж байна” (“Сүнслэг шуурганууд,” *Ensign*, 2014 оны 4-р сар, 19–20 эсвэл *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 33–34).

- Энэ залуу эмэгтэй хэцүү нөхцөл байдалтай тулгарсан үедээ ямар арга замаар итгэлтэй үйлдсэн бэ?
- Та итгэдэг зүйлээ хамгаалснаас болж ийм шүүмжлэлтэй тулгарч байсан уу? Тэр үед та юу хийсэн бэ?

Ангийнхныг мэддэг зүйлээсээ тууштай зууран барьж, сорилт бэрхшээлтэй тулгарсан үедээ баттай зогсох нь тэдний амьдралыг адисалж мөн гэрчлэл нь есөхөд хэрхэн нөлөөлсөн талаар хуваалцахад урь (Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *Ensign*, 2013 оны 5-р сар, 94 эсвэл *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс*, 108-ыг үзнэ үү). Есүс Христийн болон Түүний бошиглогчдын талаарх гэрчлэлдээ үргэлж үнэнч хэвээр байх шийдвэр гаргахад

суралцагчдыг урамшуулан дэмж (Иосеф Смитийн Орчуулга, Лук 14:28-ыг үзнэ үү [Лук 14:27, зүүлт тайлбар б-д байгаа]).

Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үз

Төлөөлөгч Паулын цаг үед амьдарч байсан хүмүүс бидэнд өнөө үед тохиолдож болох асуулт, санаа зовоосон асуудлуудтай мөн адил тулгарч байсан гэдгийг тайлбарла. Суралцагчдыг 1 Коринт 2:5, 9–11-ийг дотроо уншаад, сүнслэг үнэнийг ойлгоход Паулын заасан юу нь чухал байсныг олж мэдэхэд урь. Та бошиглогч Иосеф Смитийн 11-р шүлэгт оруулсан сүнсээр өдөөгдсөн өөрчлөлтийг онцлон хэлж болно (Иосеф Смитийн Орчуулга, 1 Коринт 2:11 [1 Коринт 2:11, зүүлт тайлбар с-д байгаа]).

Сүнслэг үнэнийг хэрхэн ойлгож чадах талаар эдгээр шүлэг юу хэлж байгааг дүгнэн хэлэхийг суралцагчдаас хүс. Бидний зөвхөн илчлэлтээр ойлгож чадах үнэнийг буюу “Бурханы гүн юмсыг” (1 Коринт 2:10) мэдэж авах нь зөвхөн Бурханы Сүнсээр боломжтой гэдгийг ойлгоход тэдэнд тусал.

Нэг суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн “Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үз” хэмээх 2-р зарчмыг уншихад урь. Ангийнхныг дагуулж уншаад, Сүнсний тусламжийг эрэлхийлж, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь хэрхэн авч үзэхийг олж мэдэхэд урь.

Суралцагчдад өөрсдөд нь ирж буй асуултуудыг хэрхэн хамгийн сайн шинжлэн судлах ёстойг ойлгоход туслах 2 дахь зарчмын доор жагсаасан үнэнүүдийг олж тогтооход урь. Тэдний хариултыг самбар дээр бич. (Суралцагчдын хариулт дараах зарчмуудыг багтааж болно. Үүнд: **Мөнхийн талаас харах нь асуулт боловсруулж, үзэл санааг авч үзэхдээ дэлхийн таамаглалаас илүү Их Эзэний үнэний жишигт тулгуурлах боломжийг олгодог. Бид Тэнгэрлэг Эцэг, Түүний авралын төлөвлөгөөнд итгэх итгэлд найдаж, тулгуурласан хэвээр байж чадвал асуудлыг илүү тодорхой харах боломжтой.**)

Биднийг өөрсдийн болон бусдын асуултыг авч үзэх үед эдгээр зарчим хэрхэн тусалж чадахыг илүү сайн ойлгоход суралцагчдад туслахын тулд нэг суралцагчийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн хэлсэн дараах үгийг чанга уншихад урь. Ангийнхнаас асуултуудын тулгуурласан таамаглал эсвэл итгэл үнэмшлийг авч үзэх нь яагаад чухал болохыг олж сонсохыг хүс. (Та энэ хэлсэн үгийн хувийг суралцагч бүрд өгч болно.)



“Бид Бурханы илчилсэн авралын төлөвлөгөө, бусад үнэний талаарх мэдлэгээсээ шалтгаалан өөрсөдтэйгөө адилхан мэдлэггүй хүмүүсийнхээ өөр таамаглал [эсвэл итгэл үнэмшлийг] дэвшүүлж эхэлдэг. Үүний үр дүнд бид бусад хүний зөвхөн мөнх бус амьдралын талаарх өөрсдийн үзэл бодлоор шүүн үздэг олон чухал сэдвийн тухайд өөр өөр дүгнэлт гаргадаг. ...

... [Бид] тулгарч буй дэлхийн үзэл бодол, таамаглалыг танин мэдсэнийхээ дараа хожмын үеийн гэгээнтнүүдийн үзэл бодлыг чиглүүлэгч өөр ойлголт, арга замуудыг танин мэдвэл илүү дээр байх юм. Энэ нь бидэнтэй итгэл нэг бус хүмүүсийг ягтаж, хүлээн

зөвшөөрүүлэхгүй ч зөрчилдөөний эх үүсвэрийг олж мэдэх гэсэн маргаанаас ярилцлагыг холдуулах болно ("As He Thinketh in His Heart" [Ахлагч Даллин Х.Өүкстэй хамт нэгэн үдэш, 2013 оны 2-р сарын 8], broadcasts.lds.org).

- Бидний итгэл үнэмшил эсвэл таамаглалууд асуух асуулт, хүрэх дүгнэлтэд маань хэрхэн нөлөөлж болох вэ? (Суралцагчдад дэлхийн таамаглалд тулгуурладаг хүн дэлхийн дүгнэлтэд хүрдэг гэдгийг ойлгоход тусал. Гэхдээ бид мөнхийн үнэнүүдийг ойлгохыг хүсдэг учраас Бурхан болон Түүний авралын төлөвлөгөөний тухай аль хэдийн мэддэг зүйлсийнхээ талаарх асуултуудыг агуулгын хувьд авч үзэх нь чухал юм.)

Бурханы болон Түүний авралын төлөвлөгөөний тухай мэдлэг нь Түүний бидэнд өгсөн зарлигуудын зорилгыг ойлгоход тусалдаг. Харин Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөнөөс өөр мэдлэгтэй хүмүүс нь зарлигуудыг бидний хардгаас өөрөөр харах хандлагатай байдаг.

Хүний дэвшүүлж болох таамаглал, асуулт, дүгнэлтийн хоорондын уялдаа холбоог харуулахын тулд *Хайраар дүүрэн Бурхан бидэнд өөрсдийгөө аз жаргалтай байлгах юуг ч хамаагүй хийлгэх эрх чөлөөг олгохын оронд яагаад зарлигуудыг өгч биднийг хориглож эсвэл эрхийг маань хасдаг вэ?* гэсэн асуултыг самбарт бич.

- Энэ асуултыг тавих үед хэн нэгэн хүн ямар таамаг дэвшүүлж болох вэ?
- Бид Түүний ойлголтоор энэ асуултыг харахад бидэнд туслах Тэнгэрлэг Эцэг, Түүний төлөвлөгөөний тухай ямар үнэнийг мэддэг вэ?
- Энэ мөнхийн ойлголт уг асуудлын талаарх бидний ойлголтыг хэрхэн өөрчилдөг вэ?

Суралцагчдыг мөнхийн талаас нь авч үзэх шаардлагатай бусад асуулт эсвэл асуудлуудыг дурдахад урь. Тэдний хариултуудыг самбар дээр бич. Дараа нь суралцагчдыг утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэх зарчим нь тэдний олж тогтоосон асуулт эсвэл асуудлуудыг илүү тодорхой ойлгон, Их Эзэний үнэний жишгийн дагуу тэдгээрийг үнэлж дүгнэхэд бидэнд хэрхэн тусалж чадахыг тайлбарлахыг хүс. Ярилцлагынхаа үеэр дараах шалгах асуултуудыг тавих талаар бодож үз.

- Ариун Сүнсний хүчээр дамжуулан Сэргээлт, бошиглогч Иосеф Смитийн тэнгэрлэг дуудлага, Мормоны Номын тухай сүнслэг гэрчлэлтэй байх зэрэг нь Сүмтэй холбоотой асуулттай тулгарах үед танд хэрхэн тусалдаг вэ?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Түүний төлөвлөгөөний төвд байдгийг мэдэх нь нийгмийн үзэл санаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийн тодорхойлолтоос татгалзах үед таны үзэл бодолд хэрхэн нөлөөлдөг вэ?

Суралцагчдыг өөрсдөө юм уу тэдний мэддэг хэн нэгэн үүнийг мөнхийн талаас нь авч үзсэнээр үзэл санаа, сургаал, асуултыг хэрхэн илүү сайн ойлгох боломжтой байсныг хуваалцахад урь. Та мөн өөрийнхөө туршлагаас хуваалцаж болно.

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл

Суралцагчдад энэхүү “Сүнслэг мэдлэг олж авах нь” заах материалын 1-р хэсэг дэх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн үгэн дээр гарсан “Сохор эрс ба заан” гэсэн эртний сургаалт үлгэр дээр үндэслэсэн шүлгийг сануул. Энэ шүлэг үнэнийг нээн илрүүлж, ойлгох нь хэцүү байдгийг хэрхэн харуулж байгааг тайлбарлахыг суралцагчдаас хүс.

Нэг суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн “Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл” хэмээх 3 дахь зарчмыг чанга уншихад урь. Ангийнхныг дагуулж уншаад, үнэнийг нээн илрүүлж, ойлгоход бидэнд туслахын тулд Бурхан бидэнд юу өгснийг олж мэдэхийг хүс. Та суралцагчдад олж мэдсэн зүйлээ тэмдэглэхийг санал болгож болно.

- Бурхан бидэнд үнэнийг нээн илрүүлж, ойлгоход туслахын тулд юу өгсөн бэ?
- Бид Их Эзэний үнэний тэнгэрээс томилогдсон эх сурвалжид хандсанаар ямар ямар адислал хүлээн авч чадах вэ? (Ярилцлагынхаа үеэр та суралцагчдадаа **Бид хариулт, удирдамж авахын тулд Их Эзэний тэнгэрээс томилогдсон эх сурвалжид хандсанаар үнэн, худал хоёрыг ялган танихаар адислагдаж чадна** гэсэн зарчмыг тэмдэглэхийг санал болгож болно.)
- Сохор эрс болон зааны тухай энэ шүлэг хариулт, удирдамж авахын тулд тэнгэрээс томилогдсон эх сурвалж руу хандах хэрэгтэйг хэрхэн тайлбарладаг вэ?

“Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийл” гэсэн 3 дахь зарчмын доорх “Түүнээс гадна бид үнэнийг бусад найдвартай эх сурвалжаас судлах боломжтой” хэмээх хоёр дахь догол мөрний эхний өгүүлбэрийг онцол.

- Бид бусад мэдээллийн найдвартай эх сурвалжид байгаа үнэнийг хэрхэн таньж чадах вэ?
- Яагаад мэдээллийн найдваргүй эх сурвалжаас болгоомжлох нь чухал байдаг вэ?

Суралцагчдыг асуулт эсвэл асуудалтай тулгарах үедээ хариулт эрэлхийлж, тэнгэрийн эх сурвалжид хандсанаар хэрхэн адислагдаж байсан жишээгээ хуваалцахад урь. Та өөрийн жишээг хуваалцахаар бэлдэхийг хүсэж болно.

Суралцагчдадаа Сүмийн албан ёсны mormonnewsroom.org вэбсайтын (боломжтой бол үзүүлж болно) талаар хэл. Энэ нь Сүмтэй холбоотой олон нийтийн сонирхсон олон төрлийн асуудлын талаарх мэдээллийг тодруулж мөн хэвлэл мэдээллээр олон нийтэд хүрсэн буруу, ташаа мэдээллийг залруулдаг. Мөн topics.lds.org вэбсайт дээрх Church’s Gospel Topics буюу Сүмийн сайн мэдээний сэдвүүдийн хуудсыг үзүүлэх талаар бодож үз. Gospel Topics буюу Сайн мэдээний сэдвүүд нийтлэл нь олон хүнд түүх, сургаалын асуудлаар үнэ цэнтэй, шулуун шударга мэдээлэл агуулсан байдаг.

Тэд энэ хичээлийн жилийн турш Шинэ Гэрээний сургаалуудаас судлахаас гадна *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-аас есөн сургаалын

сэдвийг болон сэдэв бүртэй холбоотой Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгүүдийг судлах болно гэдгийг тайлбарла. Тэд сэдэв бүрийг судлахдаа, хувийн амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд бодит асуулт, асуудал, боломжуудыг авч үзэхэд энэ хичээл дээр ярилцсан сүнслэг мэдлэг олж авах зарчмуудаа ашиглах болно.

Хэцүү ойлголт эсвэл асуултуудтай тулгарах үедээ эдгээр зарчмыг хэрэгжүүлэхийн ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалц. Суралцагчдад Их Эзэн Сүнсээрээ дамжуулан тэдэнд заахыг хүсдэг гэдгийг батлан хэл. Бид Түүнд итгэлтэй хандах үед Тэр бидэнд хариултыг өгч, бидний амьдралыг удирдамжаар хангах болно.

Төгс эзэмших сургаалын тойм

Энэхүү сүнслэг мэдлэгийг олж авах нь суралцах туршлагын 1, 2-р хэсэгт дурдагдсан Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгүүдийг давтахад суралцагчдад туслахын тулд тусдаа зохиогдох хичээлийн үеэр дараах үйл ажиллагааг ашиглах тухай бодож үз.

Хичээл эхлэхээс өмнө дараах төгс эзэмших сургаалын хэсгүүдийг самбарт бич. *Иохан 7:17; 1 Коринт 2:5, 9–11; 2 Тимот 3:15–17; Иаков 1:5–6.*

Суралцагчдыг хоёр юм уу гурван бүлэг болгон хуваарил. Бүлэг бүрд самбар дээр бичсэн төгс эзэмших сургаалын хэсгүүдийн нэгийг даалга. Оногдсон шүлгээ бүлэг бүлгээрээ хамтдаа уншиж, зааж буй сургаалыг нь олж тодорхойлохыг тэднээс хүс.

Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. (Эдгээр судартай холбоотой үнэнийг хэрхэн дурдаж болох жишээнүүдийг үзье гэвэл энэ суралцах туршлагаар эсвэл *Шинэ Гэрээний семинарын багшийн гарын авлага* дээр өмнө нь гарсан материалыг үзэх талаар бодож үз.)

Дараа нь суралцагчдаас бүлгээр ажиллаж, заагдсан сургаалыг хамгийн сайнаар төлөөлөхийн тулд ашиглаж болох хэсгүүдээс хэдэн үг сонго. Жишээ нь, *Иаков 1:5–6*-ийн хувьд суралцагчид *дутах, мэргэн ухаан, гуй* мөн *Бурхан* гэх мэт үгсийг сонгож болох юм.

Иохан 7:17-г оноож өгсөн бүлгээс эхлүүлэн, бүлгийн нэг суралцагчийг гарч ирж, самбар дээр бичсэн эшлэлийн доор сонгосон үгээ бичээд, яагаад эдгээр үгийг сонгосноо тайлбарлахыг хүс. (Хэрэв нэгээс олон бүлэгт ижил эшлэл оногдсон бол бүлэг бүрээс гарч ирсэн суралцагчаар самбар дээр үгнүүдийг нь бичүүл. Хэрэв үгнүүд өөр өөр байвал хэрэглэх үгэн дээрээ санал нэгдэхэд ангийнханд тусал. Ангиараа самбар дээр байгаа судрын эшлэл болон үгсийг давт. Үлдсэн гурван судрын хэсэг дээр үүнийг давтан хий.

Дараагийн хэдэн хичээлийг эхлэхдээ эдгээр төгс эзэмших сургаалын хэсгүүдийг болон суралцагч бүрийн сонгосон үгсийг давтах талаар бодож үз.

Бурхан Тэргүүтэн

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (35 минут зарцуул)

1-р хэсэг (10 минут зарцуул)

Бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнсний үүргийн тухай тодорхой ойлголт авахаар адислагдсан билээ.

Ангийнхныг гурав, дөрвөөр нь бүлэг болгон хуваарил. Бүлэг бүрд дараах зааварчилгааг хувиан өгч, удирдамжийн дагуу үйл ажиллагааг хийхийг тэднээс хүс.

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал-ын сургаалын 1 дэх сэдэв болох “Бурхан Тэргүүтэн”-ийг гарга. Энэ сэдвийн доорх догол мөрүүдийг ээлжлэн чанга уншиж, Бурхан Тэргүүтний талаарх ойлголтыг хай.

Та уншиж дуусаад, дараах асуултуудад хариулах боломжийг бүлгийн гишүүн бүрд олго.

- Та Бурхан Тэргүүтний тухай эсвэл гишүүдийн нэгнийх нь тухай ямар шинэ ойлголттой болсон бэ?
- Бурхан Тэргүүтэн эсвэл гишүүдийн нэгнийх нь тухай ямар сургаалыг ойлгох нь илүү чухал вэ? Яагаад?

Бүлгүүдэд хангалттай цаг гаргаж өгсний дараа хэдэн суралцагчийг ярилцсан зүйлээ ангийнхантай хуваалцахад урь.

2-р хэсэг (5 минут зарцуул)

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх сургаалын 1 дэх сэдэв болох “Бурхан Тэргүүтэн”-ийг гаргахыг хүс. Дараа нь асуу.

- Бурхан бол бидний сүнсний эцэг хэмээх сургаалыг заахын тулд ямар шүлэг ашигласан байна вэ? (Еврей 12:9.)

Суралцагчдыг Еврей 12:9-ийг нээхэд урь. Энэ шүлэг төлөөлөгч Паулын өөрийн өдрүүдэд иудейчүүд болох Сүмийн гишүүдэд заасан заавруудыг агуулдаг гэдгийг тайлбарла. Паул Бурханы зэмлэл, сануулга, зааварчилгаанд хэрхэн хариулахаа ойлгоход Сүмийн гишүүдэд туслахыг хичээсэн (Еврей 12:7, зүүлт тайлбар б-г үзнэ үү).

Нэг суралцагчийг Еврей 12:9-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагуулж уншаад, Паулын Бурханыг дурдахдаа ашигласан нэрийг олж мэдэхийг хүс.

- Паул Бурханыг дурдахдаа ямар нэр ашигласан бэ?

Суралцагчдыг судар дээрээ Еврей 12:9-ийн хажууд **Бурхан бидний сүнсний Эцэг** гэсэн үгнэгийг бичихэд урь. Энэ нь төгс эзэмших сургаалын хэсэг учраас

та суралцагчдыг Еврей 12:9-ийг амархан олж болох өөр тэмдэглэгээгээр тэмдэглэхийг зөвлөж болно.

3-р хэсэг (10 минут зарцуул)

Еврей 12:9-ийг ангиараа хамтдаа чанга унш. Энэ шүлгээс Бурханы тухай мэдэж авсан сургаалаа хэлэхийг суралцагчдаас хүс.

Суралцагчдад Бурхан бол бидний сүнсний эцэг хэмээх сургаалыг илүү сайн ойлгоход нь туслахын тулд хэдэн суралцагчийг LDS.org вэбсайт дээрх Сайн мэдээний сэдвүүд хэсгээс дараах мэдэгдлийн догол мөрүүдийг ээлжлэн чанга уншихад урь. (Боломжтой бол та суралцагчдад өөрсдөө энэ мэдэгдлийг олоход туслахын тулд Gospel Topics буюу Сайн мэдээний сэдвүүдийг хэрхэн олохыг тэдэнд үзүүлж болно.)

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэнгэрлэг эцэг эх болох Тэнгэрлэг Эцэг, Эхийн сүнсэн хайрт хүүхдүүд хэмээн заадаг. ...

Хожмын үеийн гэгээнтнүүд Тэнгэрлэг Эцэгт Христийн нэрээр залбирдаг бөгөөд Тэнгэрлэг Эхэд залбирдаггүй. Ингэснээр тэд “Та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой” [3 Нифай 18:19–21] хэмээн шавь нартаа заасан Есүс Христийн тогтоосон загварыг дагадаг. Хожмын үеийн гэгээнтнүүдэд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахыг заадаг ч ерөнхийлөгч Гордон Б.Хинкли “Бид Тэнгэр дэх Эхдээ хандан залбирдаггүй нь түүнийг дорд үзэж эсвэл гоочилж байгаа хэрэг биш юм” хэмээн хэлсэн [“Daughters of God,” *Ensign*, 1991 оны 11-р сар, 100].

“Сайн мэдээний тухай бусад олон үнэний адилаар Тэнгэр дэх Эхийн тухай бидний одоогийн мэдлэг хязгаарлагдмал байдаг. Гэхдээ бидэнд энэ сургаалын ариун нандин байдалд талархаж мөн тэнгэрлэг эцэг эхийн хүүхдүүдийн хувьд бидэнд зориулагдсан тэнгэрлэг загварыг ойлгох хангалттай мэдлэг өгөгдсөн юм” (Gospel Topics, “Mother in Heaven,” [lds.org/topics](https://www.lds.org/topics)).

- Бидэнд Тэнгэр дэх Эцэг, Эх хоёулаа байгааг ойлгох нь яагаад тустай байдаг вэ?

4-р хэсэг (10 минут зарцуул)

Еврей 12:9-ийг болон Бурхан бол бидний сүнсний Эцэг хэмээх сургаалыг давтахын тулд суралцагч бүрд дараах зааврыг хувиалан өгч, уг үйл ажиллагааг гүйцээхийг хүс.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэрын хэлсэн дараах үгийг уншиж, тунгаан бод.

“Та бол Бурханы хүүхэд. Тэр таны сүнсний Эцэг. Та сүнслэг байдлын хувьд язгууртан гаралтай бөгөөд Тэнгэрийн Хааны үр удам юм. Энэ үнэнийг оюун ухаандаа хадгалж яв. Гэхдээ таны мөнх бус өвөг дээдэс хэдэн үе байлаа ч мөн та ямар ч үндэстэн эсвэл хүмүүсийг төлөөлж байлаа ч гэсэн таны сүнсний угийн бичиг нэг л шугам дээр бичигдэнэ. Та бол Бурханы хүүхэд!” (“To Young Women and Men,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 54).

Судрын тэмдэглэл эсвэл хичээлийн дэвтэр дээрээ дараах асуултуудад хариул.

- Та Бурханы хүүхэд гэдгээ хэрхэн мэддэг вэ?
- Бурхан бол таны сүнсэн Эцэг гэдгийг мэдэх нь өөрийн тань талаарх бодол болон хийдэг сонголтуудад тань хэрхэн нөлөөлдөг вэ?
- Бурхан бол бидний сүнсний Эцэг гэх мэдлэг бусдыг харах болон бусдад хандах хандлагад тань хэрхэн нөлөөлж байна вэ?

Хангалттай хугацаа гаргаж өгсний дараа бичсэн зүйлсээ хуваалцах нэг, хоёр суралцагчийг урь.

Та дараагийн хичээлүүдийн эхний хэдэн минутыг, магадгүй ангийн сүнслэг үйл ажиллагааны нэг хэсгийг ашиглан бусад суралцагчаар энэ үйл ажиллагаан дээр бичсэн зүйлсийг нь хуваалцуулах талаар бодож болох юм. Хэрэв та үүнийг хийх бол Еврей 12:9-ийг чанга уншиж, хуваалцаж буй эхний суралцагчийг Бурхан бол бидний сүнсний Эцэг хэмээх энэ сургаалыг давтан хэлэхэд урь. Энэ хэсгийг болон сургаалыг дахин давтах нь суралцагчдад энэ үнэнийг санахад тусалж чадна.

Дасгал ажил (12–15 минут зарцуул)

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ынхаа “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийг нээхийг хүс. Итгэлээр үйлдэх, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэх, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх гэсэн гурван зарчмын утгыг хар.

Суралцагчдыг хоёр, гурван гишүүнтэй бүлэг болгон хуваарил. Бүлэг бүрд дараах зааврыг хувилж өгөөд, энэ үйл ажиллагааг гүйцээхийг тэднээс хүс.

1. Дараах зохиолыг чанга уншиж, энэ залуу эмэгтэйд тохиолдож байсантай адил мэдрэмж танд төрж байсан эсэхийг бодож үз. Тухайлбал:

Лиэ гэр бүлдээ болон зарим найзтайгаа харилцааны асуудалтай байгаа. Тэр нэг орой залбирахаар өвдөг сөгдсөн боловч залбирлаа эхэлсэнгүй. Тэр уурандаа “Бурхан намайг яагаад анхаарахгүй байгаа юм бол?” гэж өөртөө хэлэв. Тэр орон дээрээ суугаад, өөрт нь саяхан тохиолдсон хэцүү зүйлсээ бодов. Хэцүү зүйлс бүрээ Бурхан түүнд анхаарал хандуулаагүй гэдгийн нотолгоо гэж үзэж байв.

Хэдэн өдрийн дараа өсвөр үеийнхний үйл ажиллагаан дээр Залуу эмэгтэйчүүдийн удирдагч Лиэг хэр байгааг асуув. Лиэ “Сайнгүй ээ. Амьдрал одоогоор хэцүү л байна” гэж хариулав. Лиэгийн удирдагч асуулт тавьсаар байсан ба сүүлдээ Бурхан өөрийг нь анхаарахгүй байгаа гэж бодож байгаагаа хуваалцсан байна.

2. Бүлгээрээ дараах асуултыг ярилц.
 - Хэрэв та Лиэгийн удирдагч байсан бол Лиэд итгэлээр үйлдэж, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэн, тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү ихийг ойлгож авахаар эрэлхийлэхэд нь туслахын тулд юу хийх байсан бэ?

3. Зохиолыг үргэлжлүүлэн чанга унш.

Лиэгийн удирдагч харамсаж байгаагаа чин сэтгэлээсээ илэрхийлээд, “Бурхан чамд анхаарал тавьдаг гэдгийг мэдэж авсан үе чамд байдаг уу?” гэж асуужээ.

Лиэ хэсэг хугацаанд бодоод, Бурхан түүний залбиралд хариулж байсан хэдэн үйл явдлыг сана. Тэр удирдагчдаа энэ туршлагаа хэлсэн байна. Удирдагч нь “Эдгээр туршлагаа надтай хуваалцсанд баярлалаа” гэв. Бурхан бидний Эцэг бөгөөд Тэр бидэнд хайртай гэдгийг би мэднэ. Мөн Тэр чамд хайртай бөгөөд чамд анхаарал тавьдгийг би мэднэ. Гэхдээ заримдаа хэрэв бид Түүнтэй ойр байхаар хичээхгүй л бол Түүний хайрыг мэдрэх хэцүү байдаг. Чи Тэнгэрлэг Эцэгт ойр байхын тулд хамгийн сүүлд юу хийсэн бэ?

“Би ихэнхдээ шөнө залбирдаг. Гэхдээ би үнэндээ асуудлуудынхаа талаар Тэнгэрлэг Эцэгтээ залбираагүй байгаа” гэж Лиэ хариулав.

“Чи Тэнгэрлэг Эцэгийн охин учраас Тэр чиний залбирлыг сонсохыг хүсдэг. Чи залбирч, асуудал болон асуултуудаа Түүнтэй хуваалцах уу?” гэж Лиэгийн удирдагч асуужээ.

“Залбирна аа” гэж Лиэ хэлэв. Тэр цааш нь “Баярлалаа. Надад энэ сануулга хэрэгтэй байсан юм” гэв.

4. Бүлгээрээ дараах асуултуудыг ярилц.

- Лиэгийн итгэлээр үйлдэх шийдвэр түүнд хэрхэн тусална гэж та бодож байна вэ?
- Та Түүнээс холдсоноо мэдэрч эсвэл Түүнийг таны туулж байгаа зүйлсэд анхаарал хандуулдаг эсэхэд эргэлзэж байгаа хүнд хэцүү үедээ танд тусалж чадах Бурханы тухай юу мэддэг вэ?

Тэдэнд хангалттай хугацаа гаргаж өгсний дараа хэдэн суралцагчаас бүлгээрээ ярилцсан зүйлсээ хуваалцахад урь.

Та Бурхан бол бидний сүнсний Эцэг бөгөөд бид Түүний хүүхдүүд учраас Тэр бидний хүн нэг бүрийг хайрлаж мөн анхаардаг гэдгийг гэрчилснээр хичээлээ дуусгаж болно. Суралцагчдыг Бурханы хүүхдүүд гэдгээ үргэлж санахад урь.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдын энэ курсээр мэдэж авсан Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсэг бүрийг самбарт жагсаан бич. Суралцагч бүрд өөр өөр төгс эзэмших сургаалын хэсгийг оноож өг. Суралцагчдад оноож өгсөн төгс эзэмших сургаалын хэсэгт агуулагдаж буй зарчим, үнэнүүдийг хэрэгжүүлж болох нэг тохиолдол эсвэл нөхцөл байдлыг цаасан дээр бичих даалгавар өг.

Суралцагчдыг дууссаны дараа тэдний бичсэн зохиолуудыг хурааж ав. Зохиолыг чанга уншиж, суралцагчдыг тэр тохиолдсон үйл явдалд хариулахад тус болсон нэг төгс эзэмших сургаалын хэсгийг олж тогтооход урь. Тэдний олж тогтоосон төгс эзэмших сургаалын хэсэг нь уг тохиолдолд хэрхэн хэрэгжиж болохыг тайлбарлахад тэднийг урьж, шалга. Бусад зохиолыг чанга уншиж, үйл ажиллагааг давтан хий. Та ирэх долоо хоногт хичээлийн эхэнд юм уу төгсгөлд тохиолдлуудын заримыг танилцуулж болно.

Авралын төлөвлөгөө

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг юм уу хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (60–70 минут)

1-р хэсэг (10 минут)

Дэлхий даяар олон хүнд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний талаар үнэн зөв, бүрэн дүүрэн ойлголт байдаггүй гэдгийг онцлон хэл. Харин бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг ойлгоход маань туслах судрын мэдлэг, бошиглогчдын сургаалаар адислагдсан.

Суралцагчдыг мөнх бус байдлын өмнөх, мөнх бус амьдрал, үхлийн дараах амьдралыг багтаасан авралын төлөвлөгөөний зургийг зурахад урь. Суралцагчдаас зурж дууссаны дараа хос болгон хувааж, *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Авралын төлөвлөгөө” гэх сургаалын 2 дахь сэдвийг уншаад, зураг дээрээ нэмж болох нэмэлт хэсгүүдийг олж мэдэхийг хүс. Тэднээс олсон хэсгүүдээ мөн тэдгээр нь Бурханы төлөвлөгөөг илүү сайн ойлгоход хэрхэн тусалдаг болохыг хамтрагчдадаа тайлбарлахыг хүс.

2-р хэсэг (10 минут)

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Авралын төлөвлөгөө” гэх сургаалын 2 дахь сэдвийг уншаад, Шинэ Гэрээний судрын эшлэлүүдийн дэмжин баталдаг сургаалын тухай мэдэгдлүүдийг тэмдэглэхэд урь. Эдгээр мэдэгдэлд дараах зүйл орно. Үүнд:

- **Бид энэ төлөвлөгөөг биелүүлэн, Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болохын тулд Түүнийг болон Түүний Хүү Есүс Христийг таньж мэдэн, Тэдний зан байдал, шинж чанарын талаар зөв ойлгосон байх ёстой** (Иохан 17:3-ыг үзнэ үү).
- **Бидний бие махбод ариун бөгөөд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ өгсөн энэ бэлэгт хүндэтгэлтэй хандах ёстой** (1 Коринт 6:19–20-ийг үзнэ үү).
- **Эцсийн эцэст хүн бүрд сайн мэдээний зарчмуудаас суралцан, ёслол ба гэрээнүүдийг хүлээн авах боломж олдох болно. Олон итгэлтэй хүн сүнсний шоронд байгаа хүмүүст сайн мэдээг номлоно. Сайн мэдээг хүлээн авч, наманчлан, ариун сүмд тэдний өмнөөс хийсэн авралын ёслолуудыг хүлээн авсан хүмүүс амилуулагдах хүртлээ диваажинд амьдрах юм** (1 Петр 4:6-г үзнэ үү).
- **Есүс Христ биеийн үхлийг ялан дийлсэн учраас дэлхий дээр төрсөн хүн бүр амилуулагдана** (1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү).
- **Амилуулалтын дараа Эцсийн шүүлт болно. Есүс Христ хүмүүсийн хүлээн авах мөнхийн алдар сууг тодорхойлохын тулд тэднийг шүүнэ. Энэхүү шүүлт нь хүн бүрийн хүсэл, Бурханы зарлигуудад дуулгавартай байсан эсэх дээр үндэслэх болно** (Илчлэлт 20:12-ыг үзнэ үү).

- **Алдар суугийн селестиел, террестриел, телестиел хаант улс гэсэн гурван хаант улс байдаг** (1 Коринт 15:40–42-ыг үзнэ үү).

3-р хэсэг (20–25 минут)

Дараах үйл ажиллагаан дээр ашиглахын тулд дээрх сургаалын тухай мэдэгдэл болон төгс эзэмших сургаалын хэсгүүдээс заримыг эсвэл бүгдийг сонго. Та энэ мэдэгдлүүдийн зөвхөн цөөн хэдийг заахаар сонгосон бол дараагийн өдрүүдэд үлдсэн сургаалын тухай мэдэгдэл, төгс эзэмших сургаалын хэсгүүдийг заахын тулд энэ үйл ажиллагааг давтан хийнэ үү.

Суралцагчдаас найзынхаа тавьсан авралын төлөвлөгөөний тухай асуултад хариулах гэж байна гэж төсөөлөн бодохыг хүс. Суралцагчдыг хос болгон эсвэл жижиг бүлгүүдэд хуваагаад, таны сонгосон төгс эзэмших сургаалын хэсгүүдийг судлах даалгавар өг. Хэсэг бүрийг судлах үедээ тэдний авч хэлэлцэх дараах асуултыг самбарт бич.

- *Та Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал дээрх сургаалын тухай мэдэгдлийг тайлбарлахдаа төгс эзэмших сургаалын хэсгийг хэрхэн ашиглаж болох вэ?*
- *Судар, сургаал нь Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний талаар мэдэхгүй хүнд ямар арга замаар тусалж болох вэ?*
- *Төгс эзэмших сургаалын хэсэг дэх номлол, сургаалууд нь өнөөдөр хэрхэн амьдрах сонголтод тань ямар байдлаар нөлөөлж болох вэ?*

Хангалттай цаг гаргаж өгсний дараа цөөн суралцагчийг хариултаа ангийнхантайгаа хуваалцахад урь. Илүү сайн хэлэлцүүлэг, ойлголтыг хөхиүлэн дэмжихийн тулд та дараахтай адил нэмэлт асуултуудыг тавьж болно.

Тухайлбал:

- Яагаад эдгээр сургаалыг бид төдийгүй дэлхий дээрх бусад хүн ойлгож байх нь чухал вэ?
- Эдгээр сургаал Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөөний талаар ямар асуултад хариулдаг вэ?

4-р хэсэг (20–25 минут)

Дараах асуултуудыг индекс карт эсвэл цаасан дээр тусад нь бичээд, картыг ангийнхаа ширээн дээр доош харуулж тавь.

- *Хэрэв хүн аврагдахын тулд Есүс Христийн сайн мэдээг хүлээн авах ёстой юм бол сайн мэдээний талаар мэдэж чадалгүй нас барсан хүмүүст юу тохиолдох вэ?*
- *Ямар хүн амилуулагдах вэ?*
- *Бие махбод маань асуудалтай байж болох ч би яагаад үүний төлөө талархах ёстой вэ?*
- *Би бүх хүн эцэстээ тэнгэрт эсвэл тамд очно гэж сонссон. Энэ үнэн үү?*

- Би хамгийн чухал ямар мэдлэгийг олж авч чадах вэ?
- Энэ амьдралдаа хийх сонголт маань нас барсны дараа надад тохиолдох зүйлсэд хэрхэн нөлөөлөх вэ?

Шаардлагатай бол “Авралын төлөвлөгөө” гэх сургаалын 2 дахь сэдэвтэй холбоотой Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгүүдийг дахин авч үз. Та эдгээр хэсгийн эшлэлүүдийг самбарт бичиж болно. Үүнд: *Иохан 17:3; 1 Коринт 6:19–20; 1 Коринт 15:20–22; 1 Коринт 15:40–42; 1 Петр 4:6; Илчлэлт 20:12.*

Суралцагчдыг хос хосоороо ажиллахаар хуваарил. Нэг хосыг самбарын өмнө гарч ирэхэд урь. Ангийн үлдсэн гишүүд Сүмийн сургаалын талаар асуулт байгаа найзыг төлөөлж байгаа гэдгийг тайлбарла. Ширээн дээрх карт эдгээр найзынх нь авралын төлөвлөгөөний талаарх асуултыг төлөөлж байгаа болно. Гарч ирсэн хосыг авралын төлөвлөгөөний талаар мэдэж авсан зүйлээ төгс эзэмших сургаалын хэсэг, сургаалын тухай мэдэгдлүүдийг ашиглан эдгээр асуултад хэрхэн хариулах талаар бодож үзэхэд урь. Уг хосоор картыг сонгуулж, ангийн өөр нэг суралцагчаар асуултыг уншуулаад, дараа нь хосод төгс эзэмших сургаалын хэсгүүдийг ашиглан тухайн асуултад хариулах боломж олго. Асуултад хариулах өөр хос суралцагчтай үйл ажиллагааг давтан хий. *(Тэмдэглэл: Энэ үйл ажиллагааны хугацааг богиносгон хуваахын тулд нэг үйл ажиллагаан дээр бүгдийг хариулахын оронд өөр өөр өдөр нэг ба түүнээс олон асуултад хариулах талаар бодож үз.)*

Үйл ажиллагааны үеэр суралцагчдын ойлголт, гэрчлэл хэрхэн хүчирхэгжсэн талаар асууж энэ хэсгийг дуусга.

Дасгал ажил (30–40 минут)

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал дээрх “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийг ашиглан суралцагчдад итгэлээр үйлдэх, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголтыг эрэлхийлэх гэсэн гурван зарчмыг ашиглан дадлага хийж, тэдгээрийг авралын төлөвлөгөөний талаар мэдэж авсан сургаалын тухай мэдэгдэлдээ хэрэгжүүлэхэд нь тусал. Дараах үйл ажиллагаанууд үүнийг хийхэд танд тусална. Эдгээр үйл ажиллагааг та хуваарь дээрээ болон суралцагчдынхаа хэрэгцээ шаардлага дээр тулгуурлан нэг эсвэл өөр өөр өдөр зааж болно.

1-р дасгал (20–25 минут)

Дараах мэдэгдлийг чанга уншаад, суралцагчдыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр энэ мэдээлэл тавигдсан байгаа гэж төсөөлөхөд урь.

“Би мормончуудыг ойлгодоггүй. Тэд яагаад шивээс хийлгэхгүй, согтууруулах ундаа хэрэглэхгүй, гэрлэхээсээ өмнө бэлгийн харьцаанд орохгүй, зөвхөн даруухан хувцас өмсөх гээд ийм олон хязгаарлалттай амьдардаг юм бол? Энэ бол чиний л бие мөн чиний л амьдрал гэж би хэлмээр байна. Хэрэв чи хэн нэгнийг гэмтээгээгүй л бол хүссэнээ хий. Мормончууд чөлөөтэй байх хэрэгтэй.”

Суралцагчдыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр тавигдсан энэ мэдээлэлд хариу бичихэд урь. Тэднийг хариундаа 1 Коринт 6:19–20 болон Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн гурван зарчмыг ашиглахад урь. Зарчмуудыг самбарт бич. Үүнд:

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүнзгий ойлголт олж авахыг эрэлхийл.*

Суралцагчдад тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүнзгий ойлголт олж авахыг эрэлхийлэх талаар дадлага хийхэд нь туслахын тулд Судруудын удирдамж дээрх судрын нэмэлт хэсгийг хайж олоход тэднийг урих тухай бодож үз. Түүнчлэн тэд бидний бие махбодын ариун нандин байдлыг тайлбарласан Сүмийн удирдагчдын хэлсэн үгийг хайж олж болно. Боломжтой бол тэд ийм мэдэгдлүүдийг цахим хэрэгсэл ашиглан LDS.org вэбсайтаас эсвэл Сүмийн сэтгүүлээс хайж болно. Та Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлсэн дараах үгийг жишээ болгон чанга уншиж болно.



“Бидний бие махбод эволюцийн аз тохиолын үр дүнгээс үүдэн гарсан зүйлээс өөр юу ч биш гэдэгт итгэдэг хүмүүс өөрсдийн бие махбодод хэрхэн хандаж, юу хийснийхээ төлөө Бурханы эсвэл өөр хэн нэгний өмнө ямар ч хариуцлага хүлээдэггүй хэмээн боддог. Бид өмнөх болон энэ амьдралын талаар мөн энэ амьдралын дараах мөнх байдлын талаар илүү өргөн бодит гэрчлэлтэйн хувьд Бурханы хамгийн дээд зэргийн бүтээлийн төлөө Түүний өмнө хариуцлага хүлээх ёстой гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Паулын үгс:

“Та нарын бие бол Бурхан та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу?”

Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун’ (1 Коринт 6:19–20).

Бид эдгээр үнэнийг ... хүлээн зөвшөөрснөөр өөрсдийн бие махбодыг шивээс хийлгэн үзэмжгүй болгох эсвэл хар тамхи гэх мэтийг хэрэглэн муутган доройтуулах, аль эсвэл садар самуун явдал, даруу бус хувцаслах зэргээр бузарлахгүй байх хэрэгтэй. Бие махбод маань бидний сүнсний зэмсэг учраас чадлынхаа хэрээр үүнд анхаарал хандуулдаг байх нь амин чухал юм. Бид бие махбодынхоо хүчийг Христийн ажлыг үргэлжлүүлэн, үүнд үйлчлэхэд өргөл болгох ёстой” (“Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” *Ensign*, 2010 оны 11-р сар, 17 эсвэл *2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 19).

Суралцагчдыг бичиж дуусахад нь хариултуудаа ангийнхаа өөр нэг гишүүнд уншиж өгөөд, тавьсан асуултад хариулахдаа энэ гурван зарчмыг хэрхэн ашигласнаа ярилцахад урь. Зарим хариултаа ангийнхантайгаа хуваалцаж мөн эдгээр хариулт Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн зарчмуудыг хэрхэн жишээ татан харуулж байгааг ярилцахад урь.

Суралцагчдыг өнөөдөр үзсэн сургаалын дагуу хэрхэн илүү сайн амьдарч болох талаар бодож үзэхэд урин, энэ хэсгийг дуусга.

Дасгал 2 (10–15 минут)

Суралцагчидтай хамт авралын төлөвлөгөөний сургаалыг тайлбарлахад тусалдаг Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгийг товч авч үз. Дараа нь нэг суралцагчийг дараах үйл явдлыг ангийнханд чанга уншиж өгөхөд урь. Авралын төлөвлөгөөний сургаал хэрхэн Хосегийн сонголтод туслах талаар бодож үзэхийг ангийнхнаас хүс.

“Хурдал” гэж дасгалжуулагч оноо авах боломжоо алдсан Хосе руу хашхирлаа. Хосегийн найз Силвия түүнийг сэтгэлээр унасан байдалтай сандал руугаа буцаж очиж байхыг анзаарав. Хосе сайн тоглохыг хэчнээн их хүсэж байсныг тэр мэдэж байлаа. Тэр хөл бөмбөгийн багт орохын тулд шаргуу хөдөлмөрлөсөн байв. Тэр багийнхаа хамгийн хурдан нь эсвэл хүчтэй нь байгаагүй ч дасгалжуулагчдад гүн сэтгэгдэл төрүүлсэн онцгой чадвартай нэгэн байлаа.

Хэдэн жилийн өмнө Хосе Силвиягийн тойрогт шилжиж ирснээс хойш тэд найзалж эхэлжээ. Түүнд Хосегийн сайхан сэтгэлээс гадна санваарын үүргээ хүндэтгэдэг нь таалагддаг байлаа. Тэр итгэл үнэмшлээ хуваалцдаг найзтай байгаадаа талархдаг байв.

Хосег цүнхнийхээ ёроолоос савтай ус болон нэгэн ногоон эм гаргаж ирэхийг Силвия харлаа. Тэр түүнийг эмээ гаргаж ирээд, усаар даруулж ууж байгааг хараад, царай нь барайв. Хэдэн өдрийн өмнө багийнх нь зарим найз нөхөд түүнд хүч чадал нэмэгдүүлдэг хууль бус эм өгсөн байлаа. Хосе тэр эмийг ууж эхэлснээсээ хойш илүү сайн тоглож байгаа юм шиг санагдсан гэж хэлсэн байв.

Силвия түүнийг өглөө энэ эмнээс дахин нэгийг ууж байхыг харсан ба одоо түүнтэй ярилцах нь зүйтэй гэж шийджээ. “Энэ эмийг уух нь буруу гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ. Хэрэв дасгалжуулагч чинь үүнийг мэдвэл чи багаасаа хөөгдөх нь гарцаагүй” гэж тэр хэлэв.

Хосе “Энэ чинь сүйдтэй том асуудал биш ээ. Энэ бол миний бие. Би бусад хөвгүүнтэй адил хүч, хурдтай болмогцоо хэрэглэхээ больчихно. Хоёулаа өөр зүйл ярья” гэв.

- Та энэ үйл явдлаас ямар асуудал олж харж байна вэ?
- Хосегийн бодол, бие авч яваа байдлын юу нь буруу вэ?
- Силвия энэ нөхцөл байдлыг юу гэж харж байна гэж та нар бодож байна вэ?

Суралцагчдыг эдгээр асуултад хариулсны дараа Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн итгэлээр үйлдэх, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэх, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх гэсэн гурван зарчмыг тэдэнд сануул.

Хоёр суралцагчийн нэгийг Силвия, нөгөөг Хосе болгон үйл явдлыг үргэлжлүүлэн жүжигчлэн тоглуулах талаар бодож үз. Силвиягийн дүрд тоглож байгаа суралцагчийг Хосед сонголтынхоо талаар дахин бодож үзэхэд нь туслахын тулд Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн гурван зарчмын нэг эсвэл түүнээс олон зарчмыг хэрхэн ашиглаж болохыг харуулахад урь. Хосегийн дүрд тоглож байгаа суралцагчийг ухаалаг, чин сэтгэлээсээ хариу өгөхөд урь.

Жүжигчлэн тоглосныхоо дараа үлдсэн суралцагчийг үзүүлсэн зарчмуудыг олж тогтооход урь. Та мөн энэ жүжигчилсэн тоглолт дээр зарчмуудыг цаашид хэрхэн үргэлжлүүлэн ашиглаж болох талаарх ангийнхны саналыг асууж болно.

Энэ үйл ажиллагаагаар заасан сургаал, зарчмуудын тухай гэрчлэлээ хуваалцахад суралцагчдыг урамшуулан дэмж.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдад төгс эзэмших сургаалын хэсгүүдийг санаж, ашиглахад нь туслахын тулд тэдгээрийг дараагийн өдрүүдэд дахин авч үзэх хэрэгтэй. Хичээлийн жилийн турш эдгээр судрын хэсгийг дахин авч үзэх боломжийг эрэлхийл.

Дараах үйл ажиллагаа нь суралцагчдад *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Авралын төлөвлөгөө” гэх сургаалын 2 дахь сэдэвт орсон Шинэ Гэрээний зургаан төгс эзэмших сургаалын хэсгийг санахад туслах зорилготой юм. Гэхдээ та суралцагчдын энэ хичээлийн жилд сурч мэдсэн бусад төгс эзэмших сургаалын хэсгийг оруулахын тулд энэ үйл ажиллагааг өөрчлөн зохицуулж болно.



Суралцагч бүрд авралын төлөвлөгөөний сургаалыг ойлгоход тусалдаг Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгийн дараах шалгалтыг хувийг тарааж өг. Суралцагчдад уг материал дээрх эшлэл, гол үг хэллэгүүдийг сайн мэддэг болоход нь туслахын тулд та энэ үйл ажиллагааг хийхээсээ өмнө эдгээр судрын хэсгийг байнга авч үзэж байх хэрэгтэй байж болно. Суралцагчдад шалгалт өгөхөөс хэдэн минутын өмнө судрууд, *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Авралын төлөвлөгөө” гэх сургаалын 2 дахь сэдвийг хамтрагчтайгаа хамт ашиглах боломжийг олго. Дараа нь шалгалтын материалыг тарааж өгөөд, эшлэлийн хажууд байх хоосон зайд зөв судрын дугаарыг бичихэд суралцагчдыг урь.

Та хэсгүүдийн талаарх асуултад хариулан, тэдгээрийг дэлгэрэнгүй тайлбарлахын тулд шалгалтын материалыг ангиараа зас.

1. _____ “Та нарын бие бол Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу?”
2. _____ “Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв.”
3. _____ “Нарны алдар өөр, сарны алдар өөр, одны алдар өөр байдаг. ... Үхэгсдийн амилалт нь тийм байна.”
4. _____ “Учир нь энэ зорилгын үүднээс сайн мэдээ үхэгсдэд ч хүртэл тунхаглагдсан.”
5. _____ “Адам дотор бүгд үхдэгчлэн, Христ дотор бүгд амьдруулагдах болно.”
6. _____ “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.”

Суралцагчдыг эдгээр эшлэл, гол үг хэллэгийг чээжлэхэд урамшуулан дэмж. Та суралцагчдаас дараагийн хэдэн долоо хоногийн турш өөр арга замаар эдгээр хэсгээр шалгалт авч болно.

Шалгалтын хариулт: (1) 1 Коринт 6:19–20; (2) Илчлэлт 20:12; (3) 1 Коринт 15:40–42; (4) 1 Петр 4:6; (5) 1 Коринт 15:20–22; (6) Иохан 17:3.

Есүс Христийн Цагаатгал

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (65 минут)

1-р хэсэг (10 минут)

Есүс Христ Өөрийн Цагаатгалын ачаар гэм нүглийг маань өршөөхөөс хавьгүй их зүйлийг бидний төлөө хийж чадна гэсэн мэдэгдлийг самбарт бич.

Аврагчийн Цагаатгалын ачаар гэм нүглээсээ өршөөгдөхөөс гадна хүлээн авч чадах өөр бусад адислалыг нэрлэхэд суралцагчдыг урь. Суралцагчдын хариултыг самбарт жагсаан бич.

Суралцагчдаас *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Бурхан Тэргүүтэн” гэх сургаалын 3 дахь сэдвийг гаргахыг хүс. Цөөн суралцагчийг эхний таван догол мөрийг ээлжлэн чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж хараад, Есүс Христийн Цагаатгалын ачаар бидний хүлээн авах адислалыг олж мэдэхийг хүс.

Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцаж, самбар дээрх жагсаалтад өмнө нь дурдагдаагүй өөр адислалыг нэмж оруулахад урь.

Суралцагчдын анхаарлыг дөрөв дэх догол мөрөнд хандуулж, **Бид Аврагчид итгэлтэй ирвэл Тэр биднийг ачаагаа үүрэхэд мөн өөрсдийн хүчээр хийж чадахгүй зүйлсээ хийхэд маань хүчирхэгжүүлэх болно** гэсэн үгнэнийг тодруулж зурахад урь.

- Мөнх бус амьдралд гэм нүглээс маань шалтгаалахгүй ямар ачаа, сорилт бэрхшээл бидэнд тулгарч болох вэ?

Суралцагчдыг тулгарч байгаа сорилт бэрхшээлийнхээ талаар тунгаан бодоход урь. Есүс Христийн Цагаатгалын талаар үргэлжлүүлэн судалж байхдаа сорилт бэрхшээлүүдэд туслах хүч чадлыг Аврагчаас хэрхэн хүлээн авах талаар бодож үзэхэд тэднийг урамшуулан дэмж.

2-р хэсэг (5 минут)

Суралцагчдыг хос болгон хуваагаад, төгс эзэмших сургаалын хэсэг болох Матай 11:28–30-ийг хамт уншиж, тэмдэглэхэд урь. Дараах асуултуудыг ярилцахыг тэднээс хүс.

- Энэ хэсэг нь Аврагчид итгэлтэй ирвэл Тэр биднийг ачаагаа үүрч, өөрсдийн хүчээр хийж чадахгүй зүйлсээ хийхэд хүчирхэгжүүлэх болно хэмээх бидний өмнө нь олж тодорхойлсон сургаалын мэдэгдлийг хэрхэн харуулж байна вэ?
- Энэ хэсэг нь бидний үүрэг хариуцлагын талаар юу зааж байна вэ?
- Энэ нь Аврагч дээр ирвэл Тэр бидний төлөө юу хийх талаар юу зааж байна вэ?

3-р хэсэг (5 минут)

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, Даллин Х.Өүкс нарын хэлсэн дараах үгийг үзүүл эсвэл хувийг тарааж өг. Эдгээр төлөөлөгчийн хэлсэн үг хоёулаа Есүс Христийн Цагаатгалын талаарх төгс эзэмших сургаалын сэдвийг, ялангуяа Аврагчид итгэлтэй ирвэл Тэр биднийг ачаагаа үүрч, өөрсдийн хүчээр хийж чадахгүй зүйлсээ хийхэд хүчирхэгжүүлэх болно хэмээх сургаалыг илүү сайн ойлгоход бидэнд тусална гэдгийг тайлбарла. Хоёр суралцагчаас хэлсэн үгийг ээлжлэн чанга уншихыг хүс. Ангийнхныг дагаж уншаад, Аврагч ачаагаа үүрэхэд маань биднийг хэрхэн хүчирхэгжүүлж болох талаарх ойлголтуудыг олж мэдэхийг хүс.



“Эхлээд Аврагчийн биеэр амсаагүй тийм их бие махбодын өвчин, сүнслэг байдлын шарх, сэтгэл санааны зовлон, сул дорой байдал энэ мөнх бус амьдралд та бидэнд хэзээ ч тохиолдохгүй. Бид сул дорой байдлаасаа болж, ‘Ийм хүнд ачааг хэн ч мэдэхгүй, хэн ч ойлгохгүй шүү дээ’ хэмээн дуу алдан хашгирч мэднэ. Харин Бурханы Хүү төгс мэддэг, төгс ойлгодог, учир нь Тэр бидний хүн нэг бүрийн ачааг мэдэрч, үүрсэн юм. Тэр Өөрийн хязгааргүй хийгээд мөнхийн золиослолын улмаас (Алма 34:14-ийг үзнэ үү) сэтгэл санааны зовлонг төгс ойлгодог бөгөөд бидэнд нигүүлслийн мутраа сунгаж чадна. Тэр бидэнд туслахыг санал болгон, бидэнд нөлөөлж, дэмжлэг үзүүлэн, биднийг эдгээн хүчирхэгжүүлж чадна. Тэрээр бидэнд өөрсдийнхөө хүчинд тулгуурлан яагаад ч хүрч чадахгааргүй түвшинд хүрэхэд мөн өөрсдийнхөө хүчээр хийж чадахгүй зүйлсийг хийхэд тусалж чадна” (Дэвид А.Бэднар, “Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд,” *Ensign*, 2014 оны 5-р сар, 90 эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 108).



“Цагаатгал бидэнд ‘бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих’ хүчийг өгөх болно, учир нь бидний Аврагч бас ‘өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авсан’ (Алма 7:11). Ах эгч нар аа, хэрэв та нарын итгэл, залбирал, санваарын хүч зовлон зүдгүүрээс тань эдгээхгүй байвал Цагаатгалын хүч ачаагаа үүрэх хүч чадлыг танд өгөх нь зайлшгүй юм” (Даллин Х.Өүкс, “He Heals the Heavy Laden,” *Ensign* эсвэл *Liahona*, 2006 оны 11-р сар, 9).

Цөөн суралцагчийг анхаарлыг нь татсан хэллэг эсвэл ойлголтоо хуваалцахад мөн энэ нь хэрхэн Есүс Христийн Цагаатгалаар дамжин бидэнд боломжтой болсон адислалын тухай ойлголтыг нь нэмэгдүүлсэн талаар хуваалцахад урь.

- Та эсвэл таны мэддэг хэн нэгэн Аврагчаас ирдэг ийм төрлийн тусламж, хүчээр хэрхэн адислагдаж байсан бэ?

Та Аврагчид итгэлтэй ирвэл Түүний биднийг хүчирхэгжүүлэх хүчний талаар гэрчлэлээ хуваалцаж, энэ хэсгийг дуусгаж болно.

4-р хэсэг (5 минут)

Өнөөдөр дэлхий дээрх олон хүн, бүр Христийн шашинтнууд хүртэл Есүс Христ амилсан мах, ясан биетэй гэдгийг ойлгодоггүй болохыг эхлээд тайлбарла. Суралцагчдыг Есүс Христ үхэшгүй биетэйгээр амилсан эсэх нь яагаад чухал болохыг бодож үзэхэд урь.

Нэг суралцагчийг Лук 24:36–39-ийг чанга уншихад урь. Ангийнхныг дагаж уншаад, энэ нь Есүс Христийн амилсан биеийн талаар юу зааж байгааг олж мэдэхийг хүс. Тэдэнд Лук 24:36–39 нь төгс эзэмших сургаалын хэсэг гэдгийг хэлээд, үүнийг олоход хялбар байлгах үүднээс онцгойлон тэмдэглэхэд урамшуулан дэмж.

- Энэ шүлэгт цэдэглэснээр Аврагч шавь нартаа үхэгсдээс өргөмжлөгдсөн махбодтой боссон гэдгээ гэрчлэхийн тулд юу хийсэн бэ?

Суралцагчдыг судар дээрээ Лук 24:36–39-ийн хажууд **Есүс Христ өргөмжлөгдсөн, үхэшгүй мах, ясан биетэйгээр булшнаас боссон** хэмээх сургаалыг бичих тухай бодож үзэхэд урь.

5-р хэсэг (5 минут)

Дараах сургаалын мэдэгдэл болон асуултуудыг самбарт бич.

Есүс Христ өргөмжлөгдсөн, үхэшгүй мах, ясан биетэйгээр булшнаас боссон.

1. Яагаад Есүс Христ эхэлж амилах боломжтой байсан бэ?
2. Есүс Христ өргөмжлөгдсөн, үхэшгүй мах, ясан биетэй амилсан нь хэрхэн бүх хүн төрөлхтөнд хамаатай вэ?

Суралцагчдаас *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Бурхан Тэргүүтэн” гэх сургаалын 3 дахь сэдвийг гаргахыг хүс. Ангийг хоёр хэсэг болгон хувааж, нэг хэсэгт нь хоёр дахь догол мөрийг дотроо уншаад, самбар дээрх эхний асуултын хариултыг олж мэдэх даалгавар өг. Нөгөө хэсэгт гурав дахь догол мөрийг уншаад, самбар дээрх хоёр дахь асуултын хариултыг олж мэдэх даалгавар өг.

Хангалттай цаг гаргаж өгсний дараа эхний асуултыг судалсан суралцагчдыг бодлоо хуваалцахад урь. Дараа нь хоёр дахь асуултыг судалсан суралцагчдыг мэдэж авсан зүйлээсээ хуваалцахад урь.

6-р хэсэг (5 минут)

Есүс Христ булшнаас өргөмжлөгдсөн, үхэшгүй мах, ясан биетэй боссон хэмээх сургаалын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэхэд нь суралцагчдад туслахын тулд Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн дараах үгийг үзүүл эсвэл хуулбарыг тарааж өг. Нэг суралцагчийг үүнийг чанга уншихад урь. Ангийнхныг дагаж уншаад, эртний төлөөлөгчид амилсан Есүс Христийг нүдээрээ харсан нь тэдэнд хэрхэн нөлөөлсөн талаар ерөнхийлөгч Угдорф юу гэж хэлснийг олж мэдэхийг хүс.



“Түүний цовдлогдсоноос хойших хэсэг хугацаанд тэд юу болоод өнгөрснийг ойлгох чадваргүй, цөхрөл, уй гашууд автсан байдалтай байв. Гэвч нэгэн үйл явдал энэ бүгдийг өөрчилсөн юм. Их Эзэн тэдэнд үзэгдэж, ‘Миний гар, Миний хөлийг хараач. Энэ чинь би Өөрөө байна’ [Лук 24:39] хэмээн тунхаглажээ.

Төлөөлөгчид амилсан Христийг таньж, хайрт Аврагчаа гайхамшигтайгаар амилсныг харсны дараа өөр эрчүүд болцгоосон юм. Үүрэг даалгавраа биелүүлэхэд нь юу ч тэдэнд саад болж чадаагүй. ... Тэд эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралыг өөрчилсөн. Тэд дэлхийг өөрчилсөн билээ” (Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь,” *Ensign*, 2014 оны 5-р сар, 76 эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 92).

- Амилсан Есүс Христийн тухай гэрчлэл төлөөлөгчдөд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Есүс Христ өргөмжлөгдсөн, үхэшгүй мах, ясан биетэй амилсан хэмээх гэрчлэл тань хэрхэн таны амьдралд үүний адил арга замаар нөлөөлж чадах вэ?

7-р хэсэг (10 минут)

Есүс Христ бидний нүглийн төлөөсийг төлсөн нь хувийн үүрэг хариуцлагаас маань чөлөөлсөн гэсэн үг биш юм гэсэн үнэнийг самбарт бич. Энэ нь юу гэсэн утгатай болохыг өөрсдийн үгээр тайлбарлахыг суралцагчдаас хүс.

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Есүс Христийн Цагаатгал” гэх сургаалын 3 дахь сэдвийг гаргаад, самбарт байгаа өгүүлбэрээр эхэлсэн тав дахь догол мөрийг дотроо уншихад урь. Суралцагчдыг Есүс Христийн Цагаатгалын хүчийг олж авахын тулд бид юу хийх ёстой талаарх чухал ойлголтыг олж мэдэхэд урамшуулан дэмж.

- Бид Аврагчийн Цагаатгалын адислалыг бүрэн дүүрэн хүлээн авах ямар хувийн үүрэг хариуцлага үүрдэг вэ? (Бид Түүнд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчлан, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл итгэлтэй тэвчих ёстой.)

“Есүс Христийн Цагаатгал” гэх сургаалын 3 дахь сэдвийн “Есүс Христэд итгэх итгэл” болон “Наманчлал” хэсгүүд нь Есүс Христийн Цагаатгалын ачаар боломжтой болсон адислалыг хүлээн авахын тулд бид юу хийх ёстойг илүү сайн ойлгоход тусалдаг. Нэг суралцагчийг “Есүс Христэд итгэх итгэл” хэсгийг, хоёр дахь суралцагчийг “Наманчлал” хэсгийг чанга уншихад урь. Ангийнхныг дагаж уншаад, Аврагчийн золиослолыг хүлээн авахын тулд бидний хийх ёстой зүйлсийн талаар өгүүлсэн мөн өөрсдөд нь чухал санагдсан ойлголтуудаа тэмдэглэхийг хүс. *Тэмдэглэл:* Та баптисмын ёслолууд, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах, гэрээнүүдээ дээдлэн хүндлэх зэргийг “Ёслолууд болон гэрээнүүд” гэх сургаалын 7 дахь сэдвээр авч үзнэ гэдгийг тайлбарлаж болох юм.

Есүс Христэд итгэх итгэл, наманчлалын талаарх хэсгүүдийг уншсаны дараа суралцагчдыг өөрсдөд нь чухал санагдсан сургаалын мэдэгдэл, ойлголтоос хуваалцахад урь.

8-р хэсэг (5 минут)

Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь ... рүү удирдах болно гэсэн бүрэн бус мэдэгдлийг самбарт бич.

Нэг суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Есүс Христэд итгэх итгэл” гэсэн сургаалын 3 дахь сэдвийн “Есүс Христийн Цагаатгал” хэсгийг чанга уншихад урь. Суралцагчдыг дагаж уншаад, самбар дээрх мэдэгдлийг хэрхэн гүйцээж бичих талаар олж мэдэхийг хүс.

- Та самбар дээрх мэдэгдлийг хэрхэн гүйцээж бичих вэ? (Суралцагчдыг хариулсны дараа **Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь үйлдэл рүү хөтөлж, амьдралын маань хэв маягаар илэрдэг** гэсэн сургаалыг илэрхийлэх мэдэгдлийг самбарт гүйцээж бич.)
- Яагаад жинхэнэ итгэл нь Их Эзэн Есүс Христэд төвлөрсөн байх ёстой вэ?
- Хэрхэн Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь хэн нэгнийг зөв шударга үйлдэл рүү хөтөлсөн талаар ямар жишээ судрууд дээр байдаг вэ?

9-р хэсэг (5 минут)

Самбарт *Иаков 2:17–18* гэж бич. Энэ нь төгс эзэмших сургаалын хэсэг гэдгийг тайлбарлаад, суралцагчдыг үүнийг судар дээрээсээ олж, дотроо уншаад, онцгойлон тэмдэглэхэд урь. Та бас суралцагчдыг судар дээрээ, энэ шүлгийн хажууд *Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь үйлдэл рүү хөтөлж, амьдралын маань хэв маягаар илэрдэг* гэсэн сургаалын мэдэгдлийг бичихэд урьж болно.

10-р хэсэг (10 минут)

Суралцагчдыг 3–4 гишүүнтэй бүлэг болгон хуваа. Бүлэг бүрийг Иаков 2:17–18-ыг хамт чанга уншаад, дараах асуултуудын хариултыг ангийнхантайгаа хуваалцахаар бэлтгэхэд урь. (Та асуултуудыг харуулах юм уу суралцагч бүрд тараах материал бэлдэж өгч болно.) Суралцагчдыг уншиж эхлэхээс өмнө эдгээр шүлэгт буй *үйлс* гэсэн үг нь зөв шударга үйлдлийг төлөөлж байгаа гэдгийг ангийнханд тайлбарлах нь тустай байж болох юм.

- Яагаад үйлсгүй (эсвэл зөв шударга үйлдэлгүй) итгэл нь “үхмэл” гэж та нар бодож байна вэ?
- Есүс Христэд итгэх жинхэнэ итгэлийг ямар үйлдэл дагалдаж байх ёстой вэ?
- Та итгэл, зөв шударга үйлдэл хоёрын хоорондын энэ харилцааг Хүүхдийн хэсгийн таван настай хүүхдэд хэрхэн ойлгомжтой зааж болох вэ?

Хангалттай цаг гаргаж өгсний дараа нэг юм уу хоёр бүлгээс эхний асуултын хариултаа хуваалцахыг мөн нэг юм уу хоёр бүлгээс хоёр дахь асуултын талаар хэрхэн ойлгож байгаагаа хуваалцахыг хүс. Дараа нь доод тал нь нэг бүлгийг итгэл, үйлдэл хоёрын хоорондын харилцааг бага насны хүүхдэд заах гэж байгаа мэтээр заахад урь.

Ангийн хэлэлцүүлгийн дараа та зөв шударга үйлдлээрээ дамжуулан Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлснээр ирдэг хүч чадлын талаарх гэрчлэлээ хуваалцаж болно.

Дасгал ажил (20 минут)

Суралцагчдад дараах нөхцөл байдлыг уншиж өг.

Нэгэн хожмын үеийн гэгээнтэн залуу эмэгтэй ариун явдлын хуулинд болон Сүмийн зарим нэг жишигт нийцэхгүй сонголт, үйлдлүүдийг хийж эхэлсэн байна. Тэр өөрийн үйлдлийг хэн ч төгс биш гэж мөн би Сүм болон семинартаа явж, Есүс Христэд итгэдэг хэвээр байгаа хэмээн зөвтгөдөг аж.



Дараах асуултуудыг самбарт бич эсвэл тараах материалыг өгөөд, суралцагчдыг эдгээр асуултыг жижиг бүлгүүдэд хуваагдан ярилцахад урь.

Итгэлээр үйлд.

- Хэрэв энэ залуу эмэгтэй таны найз байсан бол Есүс Христэд болон Түүний сайн мэдээнд итгэх итгэлээ хөгжүүлэхийн тулд та юу хийх нь зүйтэй хэмээн түүнийг урамшуулах байсан бэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

- Авралын төлөвлөгөө болон Есүс Христэд итгэх итгэлтэй холбоотой ямар үнэн энэ залуу эмэгтэйд сонголт болон үйлдлүүдээ илүү сайн дүгнэлт хийхэд туслах вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголтыг олж авахыг эрэлхийл.

- Та энэ залуу эмэгтэйд Есүс Христэд итгэх итгэлээ үйлдлээрээ харуулах гэдэг нь юу гэсэн утгатай болохыг ойлгоход туслахын тулд ямар судар, бошиглогчдын сургаалыг хуваалцаж болох вэ?

Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь үйлдэхэд урьдаг бөгөөд амьдралын маань хэв маягаар илэрдэг хэмээх сургаалын талаар гэрчил.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчид судрын хэсгийн тухай өөрсдийн сэжүүрийг гаргаснаар тухайн төгс эзэмших сургаалын хэсгийн талаарх ойлголт нь нэмэгдэнэ. Эдгээр сэжүүрт асуулт, түлхүүр үг, үйл явдал эсвэл амьдралдаа хэрэгжүүлэх арга замууд зэрэг орж болно. Суралцагчдыг төгс эзэмших сургаалын аль нэг хэсгийг зааж буй сэжүүрийг бичихээр ангиараа эсвэл жижиг бүлгүүд болон хамт ажиллахад урь. (Та суралцагчдад зориулан суралцах, авч хэлэлцэх судрын хэсгүүдийг урьдчилан сонгож болно.) Дараа нь суралцагчдыг танд болон ангийнхандаа сэжүүрээ ээлжлэн уншиж өгөхийг урь. Төгс эзэмших сургаалын хэсгийг зөв таасан талд нэг оноо өгнө. Тэр нь та болон ангийнхны хэн нь ч байж болно.

Сэргээлт

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (40 минут)

1-р хэсэг (6 минут)

Яагаад сайн мэдээг сэргээх хэрэгтэй байсан бэ? гэсэн асуултыг самбарт бич. Суралцагчдыг энэ асуултыг ярилцахад урьж, дараа нь *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Сэргээлт” гэх сургаалын 4 дэх сэдвийг гаргахыг хүс. Нэг суралцагчийг “Урвалт” хэсгийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, Есүс Христ цовдлогдож, төлөөлөгчдийг нь үхсэний дараа юу болсныг олж мэдэхийг хүс.

- Есүс Христ цовдлогдож, төлөөлөгчдийг нь үхсэний дараа юу болсон бэ? (Суралцагчдад **Их урвалт хүмүүсийг сайн мэдээний үнэнүүдээс татгалзахад тохиосон бөгөөд Их Эзэн дэлхийгээс санваарын эрх мэдэл ба түлхүүрээ татаж авсан** гэсэн сургаалын үнэнийг олж тодорхойлоход нь тусал.)
- Бидний дөнгөж сая уншсан энэ хэсэгт Их урвалтын хэсэг байсан ямар асуудлуудыг дүрсэлсэн байна вэ?

2-р хэсэг (8 минут)

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал дээрх “Бурхан Тэргүүтэн” гэх сургаалын 4 дэх сэдвийг гаргахыг суралцагчдаас хүс. Тэднээс “Урвалт” гэсэн хэсгийг гүйлгэн уншихыг хүсэж, Их урвалтын талаар өмнө нь тодорхойлсон зүйлсийг дахин сануул. Тэднээс ямар төгс эзэмших сургаалын хэсэг энэ сургаалыг баталж байгааг олж мэдэхийг хүс.

Суралцагчдыг 2 Тесалоник 2:1-ийг нээхэд урь. Тэднээс энэ хэсгийг хялбар олохын тулд тусгайлан тэмдэглэхийг хүс.

Төлөөлөгч Паул энэ хэсгийг Хоёр дахь ирэлт аль хэдийн тохиосон эсвэл тохиох гэж байгаа гэдэгт санаа зовж байсан Сүмийн гишүүдийг тайвшруулахын тулд бичсэн гэдгийг тайлбарла. Нэг суралцагчийг энэ хэсгийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, Паул Есүс Христийн Хоёр дахь ирэлт тохиохоос өмнө юу болно гэж хэлснийг олж мэдэхийг хүс.

- Паул Хоёр дахь ирэлтийн өмнө юу болно гэж хэлсэн бэ?
- Паул “салах” (2 Тесалоник 2:3) гэдэг үгийг ямар утгаар хэлсэн гэж та нар бодож байна вэ?

Шаардлагатай бол “салах” гэдэг нь Есүс Христийн төлөөлөгчдийг үхсэний дараа тохиох Их урвалт байсан гэдгийг тайлбарла.

- Энэ тайлбар нь Паулын үед байсан Сүмийн гишүүдэд хэрхэн тусалсан байж болох вэ?
- Яагаад төлөөлөгч Паулын зөгнөн хэлсэн “салах” үйл явц аль хэдийн болж өнгөрсөн гэдгийг ойлгох нь өнөөгийн бидэнд чухал вэ?

3-р хэсэг (6 минут)

Суралцагчдад хүмүүс сайн мэдээний үнэнээс татгалзаж, Их Эзэн дэлхийгээс санваарын эрх мэдэл болон түлхүүрийг татан авах үед Их урвалт тохиосон гэсэн үнэнийг илүү сайн ойлгоход нь туслахын тулд нэг суралцагчаас Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлсэн дараах үгийг чанга уншихыг хүс.



“Сүмийн маань жинхэнэ нэр бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм юм. Есүс Христийн анхны Сүмийг сэргээн байгуулсан нь энэ билээ. Мөнх бус амьдралынхаа явцад Тэрээр өөрийн Сүмийг зохион байгуулсан. Тэрээр төлөөлөгчид, Далын гишүүд мөн бусад удирдагчийг дуудан, Өөрийнх нь нэрээр үйлдэх санваарын эрх мэдлийг өгсөн юм [Матай 10:1; Лук 6:13; 10:1; Ефес 4:11–12-ыг үзнэ үү]. Христ болон Түүний төлөөлөгчид нас барсны дараа хүмүүс сургаал, ёслолуудыг өөрчилсөн байдаг. Анхны Сүм болон санваар тэр үед авагдаж үгүй болсон билээ. Үнэнийг үл ойшоон, мухар сүсэг дэлгэрсэн тэрхүү цаг үеийн дараа Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор Есүс Христ Өөрийн Сүмийг буцаан авчирсан юм. Одоо тэр сүм дахин оршиж, сэргээгдсэн бөгөөд Түүний тэнгэрлэг удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулж байна [С ба Г 1:30]” (“Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!” *Ensign*, 2012 оны 11-р сар, 18 эсвэл *2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 22).

- Ерөнхийлөгч Нэлсоний хэлснээр яагаад Сэргээлт хийгдэх шаардлагатай байсан бэ?
- Их урвалтын тухай мэдлэгтэй байх нь хэрхэн бидэнд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ач холбогдлыг ойлгоход тусалдаг вэ?

4-р хэсэг (8 минут)

Цөөн суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Сэргээлт” гэх сургаалын 4 дэх сэдвийн эхний гурван догол мөрийг ээлжлэн чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, хожмын өдрүүдэд сайн мэдээний Сэргээлтийг авчирсан үйл явдлуудыг олж мэдэхийг хүс. Олж мэдсэн зарим чухал үйл явдлаасаа онцолж хэлэхийг суралцагчдаас хүс.

Эхний догол мөрөнд буй **Эртний бошиглогчид хожмын үед тохиох сайн мэдээний Сэргээлтийг зөгнөн хэлсэн байдаг** гэсэн сургаалыг онцлон тэмдэглэ. Суралцагчдыг энэ үнэнийг судар дээрээ, баталж байгаа төгс эзэмших сургаалын хэсэг болох Үйлс 3:19–21-ийн хажууд бичихэд урь.

- Яагаад Их Эзэн эртний бошиглогчдодоо хожмын үед Сэргээлт хийгдэнэ гэдгийг илчилж, үүний талаар бошиглохыг зарлигласан гэж та нар бодож байна вэ?

5-р хэсэг (12 минут)

Суралцагчдыг Үйлс 3:19–21-ийг төгс эзэмших сургаалын хэсэг гэдгээр нь онцгойлон тэмдэглэхэд урь. Төлөөлөгч Петр, Иохан хоёр Иерусалимын ариун сүмийн ойролцоо доголон, алхаж чадахгүй байсан нэгэн хүнийг эдгээсэн гэдгийг тайлбарла. Гайхамшгийн талаарх мэдээ хурдан тархаж, олон хүн

цугларсан бөгөөд тэдний дунд Есүс Христээс өмнө нь татгалзсан хүмүүс байсан байна. Нэг суралцагчийг энэ хэсгийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, төлөөлөгч Петр тэнд цугласан хүмүүст юу хийхийг зөвлөсөн болохыг олж мэдэхийг хүс.

- Петр хүмүүст ямар захиас өгсөн бэ?

19–20-р шүлэг дээрх “Сэргээх цаг Их Эзэний оршихуйгаас ирэх бөгөөд та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг тэр илгээх болно” гэсэн хэллэг нь “дэлхий шинэчлэгдэж мөн диваажингийн алдар суугаа хүлээн авах” (Итгэлийн тунхаг 1:10) Христийн Хоёр дахь ирэлт тохиох цаг үеийг хэлж байгаа гэдгийг онцлон хэлэх нь тустай байж болох юм.

Үйлс 3:21-д цэдэглэснээр Петр Есүс Христ “бүхнийг сэргээх үеийг хүртэл” тэнгэрт үлдэх болно гэдгийг бошиггосон болохыг тайлбарла. “Бүхнийг сэргээх үе” гэх хэллэг нь хожмын үед болох сайн мэдээний Сэргээлтийг хэлж байгаа юм.

- 21-р шүлэгт цэдэглэснээр Петрээс өөр хэн хожмын үед сайн мэдээний Сэргээлт тохиох болно хэмээн бошиггосон бэ?
- Петрийн бошиглол хэзээ биелж эхэлсэн бэ? (Бурхан Эцэг, Есүс Христ хоёр Ариун төгөлд Иосеф Смитэд үзэгдэх үед.)

Олон эрин үеийн Их Эзэний бошиглогчид бидний амьдарч байгаа энэ цаг үеийн талаар бошиггосон бөгөөд сайн мэдээний Сэргээлт, Их Эзэний Хоёр дахь ирэлтийг тэсэн ядан хүлээдэг байсан талаар гэрчлэлээ хуваалц.

Дасгал ажил (25 минут)

Суралцагчдад Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн итгэлээр үйлдэх, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэх, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх гэсэн гурван зарчмыг Сэргээлтийн сэдэвтэй холбон хэрэгжүүлж, дадлага хийхэд тусал.

Та дараах үйл ажиллагааг өөрийн хуваарь болон суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагад тулгуурлан нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.



Ангийнхныг хос болгон хуваагаад, хос бүрд дараах зааврын хувийг тарааж өг. (Суралцагчдад тэнгэрээс томилогдсон эх сурвалжийн талаарх асуултын хариултыг бэлдэхэд нь туслахын тулд Судруудын удирдамж дээрх урвалт, сэргээлттэй холбоотой судрууд, бусад мэдээллийг хэрхэн олж болохыг үзүүлэх тухай бодож үз. Та бас тэдэнд энэ сэдвээр өгсөн Сүмийн удирдагчдын үгийг LDS.org вэбсайтаас хэрхэн үзэж болохыг үзүүлж болно.)

Дараах үйл явдлыг хамтдаа уншаад, дараа нь зарчим бүртэй холбоотой асуултыг ярилц. Дээрх үйл явдалд дурдсан найздаа хэрхэн итгэлээр үйлдэж, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь авч үзэх мөн тэнгэрээс томилогдсон эх сурвалжаас илүү гүн ойлголтыг эрэлхийлэх гэсэн зарчмуудыг ойлгоход нь туслахад бэлэн бай. (Дараа нь танд өөр нэгэн хос суралцагчтай энэ үйл явдлыг жүжигчлэн тоглох боломж олдоно.)

Зарим найз тань Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд биш. Өөр урсгалын Христийн шашинд үнэнчээр итгэдэг нэг найз тань “Христийн шашин дэлхий дээр аль

хэдийн оршин тогтнож, олон хүн Библид итгэдэг байхад яагаад Бурхан Иосеф Смитэд үзэгдэх хэрэгтэй байсан юм бол?” гэж асуухад та Иосеф Смит, сайн мэдээний Сэргээлтийн тухай тайлбарлаж өгч байна.

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаас илүү гүн ойлголт олж авахыг эрэлхийл.

- Та найздаа энэ асуултын талаар илүү гүн ойлгоход нь туслахын тулд бидний судалж байгаа сургаал, төгс эзэмших сургаалын хэсгүүдээ хэрхэн ашиглаж болох вэ?
- Та илүү гүн ойлгож авахын тулд судраас гадна тэнгэрээс томилогдсон өөр ямар эх сурвалжийг ашиглахыг найздаа санал болгож болох вэ?

Асуултыг мөнхийн талаас нь авч үз.

- Та найзынхаа Бурханд болон Есүс Христэд итгэх итгэлийг авч үзээд, Бурханы хүүхдүүд өнгөрсөн цаг үед үнэнээс хэрхэн татгалзаж байсан талаарх мэддэг зүйл дээр нь тулгуурлан, энэ асуултыг шинжлэн судлахад түүнд хэрхэн тусалж чадах вэ? (Жишээ нь та хүмүүс Ноа, Мосе гэх мэт бошиглогчдын сургаалаас хэрхэн татгалзаж байсныг дурдаж болно.)
- Та найзыгаа асуултыг шинжлэн судалж байхдаа Бурханы талаар мөн хүүхдүүддээ заах гэсэн хүслийнх нь талаар мэддэг, итгэдэг зүйлээ бодож үзэхэд хэрхэн урамшуулж болох вэ?

Итгэлээр үйлд. Тухайлбал:

- Үнэнийг мэдэж авахын тулд найз тань ямар арга замаар Бурханд итгэх итгэлээ хөгжүүлж болох вэ?
- Та итгэлийг нь хүчирхэгжүүлэх ямар зүйлийг хийхэд найзыгаа урьж эсвэл урамшуулж болох вэ?

Хангалттай цаг гаргаж өгсний дараа ангийнхныг хос бүр өөр хостой ажиллаж болохоор зохион байгуул. Нэг хосыг асуулттай байгаа найзын дүрд тоглоход, нөгөө хосыг ярилцсан зүйлээ гурван зарчим ашиглан хариулахад урь. Нэг хосод хариулах боломж олгосны дараа хосуудад дүрээ солих боломж олго.

Цөөн суралцагчийг олж мэдсэн эсвэл ярилцлага, жүжигчилсэн тоглолтоос мэдэрсэн зүйлээсээ хуваалцахад урих тухай бодож үз. Цөөн суралцагчид бошиглогч Иосеф Смитээр дамжин хожмын үед тохиосон сайн мэдээний Сэргээлтийн талаар гэрчлэлээ хуваалцах боломж олгож, энэ хэсгийг дуусга.

Төгс эзэмших сургаалын тойм

Дараа дараагийн хичээлээр суралцагчдад төгс эзэмших сургаалыг чээжилж, тэдгээрийг ашиглах боломж олгохын тулд тэдгээрийг давтана уу. Хичээлийн жилийн турш эдгээр судрыг давтах боломжийг эрэлхийл. Та дараахтай адил үйл ажиллагааг ашиглаж болно. Үүнд:

Суралцагчдад хоосон карт эсвэл жижиг цаас тарааж өг. Суралцагчдыг энэ жил судалсан зарим төгс эзэмших сургаалын хэсгийг сонгож, карт болгон дээр холбогдох тайлбарыг бичихэд урь. Суралцагчдыг картын нөгөө талд тухайн эшлэлийг тодорхойлоход туслах түлхүүр хэллэг эсвэл өөр бусад сэжүүрийг бичихэд урь. (Төгс эзэмших сургаалын хэсгийн түлхүүр хэллэгүүд төгс эзэмших сургаалын номын хавчуурга дээр байгаа.)

Суралцагчдыг хоёроос гурван гишүүнтэй бүлэгт хуваа. Суралцагчдыг хийсэн картаа өөр нэг суралцагчаас юм уу суралцагчдаас шалгалт авахдаа ашиглахад урь. Суралцагчид картын тайлбартай талыг харуулаад, бусад суралцагчаас уг

хэсгийг тодорхойлохыг хүс эсвэл тэд гол хэллэгийг үзүүлж болно. Бусад суралцагчаас тухайн төгс эзэмших сургаалын хэсгийг олж болох ном, бүлгийг, магадгүй төгс эзэмших сургаалын хэсгийг олж тодорхойлохыг хүсэж болох юм.

Та үйл ажиллагааны төгсгөлд суралцагчдаас судрын эшлэлүүдийг түлхүүр хэллэг орсон төгс эзэмших сургаалын хэсэгтэй тааруулах шалгалтыг амаар эсвэл бичгээр авч болно.

Бошиглогчид ба илчлэлт

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (35 минут)

1-р хэсэг (10 минут)

Ямар шинж чанар нь манай Сүмийг бусдаас онцгой болгодог вэ? гэсэн асуултыг самбарт бич. Суралцагчдыг хариулахад урь. Тэднийг хариулж байх явцад хариултыг нь самбарт бич. Манай Сүмийг бусдаас өөр болгодог нэг шинж чанар бол бид амьд бошиглогчид болон үргэлжлэн ирсээр байгаа илчлэлтэд итгэдэг явдал юм.

Шинэ Гэрээ нь бидэнд бошиглогчийг болон илчлэлтийн сэдвийг илүү сайн ойлгоход тусалдаг гурван төгс эзэмших сургаалын хэсгийг агуулдаг гэдгийг онцлон хэл. *Иохан 15:16; Ефес 2:19–20; Ефес 4:11–14* гэсэн эшлэлүүдийг самбарт бичээд, суралцагчдад уншиж, хэсэг бүрийг төгс эзэмших сургаалын хувьд ялган, тэмдэглэх хугацаа өг.

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Бошиглогчид ба илчлэлт” гэх сургаалын 5 дахь сэдвийг гаргахад урь. Цөөн суралцагчаас ээлжлэн чанга уншихыг хүс. Ангийнхнаас дагаж уншаад, самбар дээрх гурван төгс эзэмших сургаалын хэсгийг баталж буй сургаалын мэдэгдлийг хайж олохыг хүс.

Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Та тэднийг сургаалын дараах мэдэгдлүүдийг тэмдэглэхэд эсвэл доогуур нь зурахад урьж болно.

- **Бошиглогч бол Бурханаар дуудагдаж, Түүний өмнөөс ярьдаг хүн болой.**
- **Бошиглогчид Есүс Христийн тухай гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүсэл, мөн чанарыг мэдүүлдэг. Тэд нүглийг илчилж, үүний үр дагавруудаас сэрэмжилж, хууран мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд тусалдаг.**
- **Их Эзэн мөнх бус тохинууллынхаа үеэр мөн өнөө үед бошиглогч, төлөөлөгч дээр үндэслэн Өөрийн Сүмийг дахин зохион байгуулсан.**

2-р хэсэг (5 минут)

Бошиглогч бол Бурханаар дуудагдаж, Түүний өмнөөс ярьдаг хүн болой гэсэн сургаалыг самбарт бич. Суралцагчдаас *Иохан 15:16*-г дотроо уншаад, энэ сургаалын талаар зааж буй үг, хэллэгийг хайж олохыг хүс.

Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Та тэдэнд “Та нар намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон” хэмээх хэллэгийг тэмдэглэхийг санал болгож болно.

- Хүн хэрхэн бошиглогч болдог талаар энэ хэсэг бидэнд юу зааж байна вэ?
- Яагаад бошиглогчид хүнээр биш Бурханаар сонгогдож, дуудагддаг гэдгийг ойлгох нь чухал гэж та нар бодож байна вэ?

Томилох гэдэг үг нь гар тавилтаар дамжуулан Бурханы албан ёсны санваарын эрх мэдлийг олгох гэсэн утгатай гэдгийг тайлбарла.

- Яагаад хэн нэгэн Бурхантай ярихын тулд зохих ёсоор томилогдсон байх нь чухал гэж та нар бодож байна вэ?

3-р хэсэг (10 минут)

Бошиглогчид Есүс Христийн тухай гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг гэсэн сургаалын мэдэгдлийг самбарт бич. Тэд Бурханы хүсэл, мөн чанарыг мэдүүлдэг. Тэд нүглийг илчилж, үүний үр дагавруудаас сэрэмжилж, хууран мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд тусалдаг.

Нэг суралцагчийг Ефес 4:11–14-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, самбарт бичсэн сургаалын мэдэгдлийг батлах үг, хэллэгийг хайж олохыг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс.

12-р шүлэгт Бурханы бошиглогчдыг дууддаг гурван чухал шалтгааныг заадаг гэдгийг онцлон хэл. Та суралцагчдаас эдгээр гурван шалтгааныг тэмдэглэхийг хүсэж болно.

Ангийг гурван бүлэг болгон хувааж, бүлэг бүрд дотроо ярилцах дараах асуултуудын нэгийг оноож өг. (Суралцагчдыг самбарт бичсэн Ефес 4:11–14-ийн сургаалын мэдэгдлүүдийг анхаарахад урамшуул. Бид Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг бошиглогчид хэмээн дэмжин баталдаг болохыг тэдэнд сануул.

1. Бошиглогчид ямар арга замаар гэгээнтнүүдийг төгөлдөржихөд тусалдаг вэ?
2. Бошиглогчдын хийж гүйцэтгэдэг “үйлчлэлийн ажлын” (12-р шүлэг) ямар жишээ байдаг вэ?
3. Бошиглогчид Сүмийг хэрхэн зохион байгуулж, хүчирхэгжүүлдэг вэ?

Суралцагчдыг Ефес 4:13–14-ийг уншаад, Сүмд амьд бошиглогчидтой байснаар ирдэг зарим адислалыг хайж олохыг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс.

- Бошиглогчид Сүмийн гишүүдийн хувьд бидэнд “итгэлийн эв нэгдэлд” (13-р шүлэг) хүрэхэд хэрхэн тусалдаг вэ? Энэ нь яагаад чухал вэ?
- Бошиглогчид бидэнд “давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа [худал хуурмаг] номлолын салхинд тууг[дахаас]” (14-р шүлэг) зайлсхийхэд хэрхэн тусалдаг вэ?
- Манай бошиглогчид худал хуурмаг сургаалаас биднийг хамгаалсан ямар жишээ байдаг вэ?

Суралцагчдыг судрын тэмдэглэл эсвэл хичээлийн дэвтэртээ дараах асуултуудад хариулахад урих талаар бодож үз.

- Бошиглогчийн сүүлд хэлсэн үг, сургаал эсвэл гэрчлэл хэрхэн танд Есүс Христийн тухай болон Түүний сайн мэдээний мэдлэгт өсөж хөгжихөд эсвэл худал хуурмагаас зайлсхийхэд тусалсан бэ?

Хангалттай цаг гаргаж өгсний дараа бичсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцах хүсэлтэй суралцагчийг хуваалцахад урь.

4-р хэсэг (10 минут)

Самбарт Ефес 2:19–20-д заасан *Их Эзэн мөнх бус тохинууллынхаа үеэр мөн өнөө үед бошиглогч, төлөөлөгч дээр үндэслэн Өөрийн Сүмийг дахин зохион байгуулсан* гэсэн сургаалын мэдэгдлийг бич.

Төлөөлөгч Паул итгэл нь гуйвж байсан Сүмийн зарим гишүүнийг сүнслэг байдлаар нь хүчирхэгжүүлэн, хамгаалж, нэгтгэх хүсэл тээн, ефесчүүдэд хандсан захидлаа бичсэн гэдгийг тайлбарла.

Нэг суралцагчийг Ефес 2:19–20-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, самбарт бичсэн мэдэгдлийг батлах үг, хэллэгийг хайж олохыг хүс.

Суралцагчдаас олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс.

- Христ Өөрийн Сүмийг бошиглогч, төлөөлөгчдийн суурин дээр зохион байгуулсан гэдгийг мэдэх нь Ефест байсан гэгээнтнүүдийг хэрхэн хүчирхэгжүүлэх байсан гэж та нар бодож байна вэ?
- Яагаад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь мөн бошиглогч, төлөөлөгчдийн суурин дээр зохион байгуулагдсан гэдгийг мэдэх нь чухал гэж та нар бодож байна вэ?

Суралцагчдыг хос болгон эсвэл жижиг бүлгүүд болгон хувааж, дараах асуултуудыг ярилцахыг хүс.

- Зохион байгуулагдсан шашин шаардлагагүй ба энэ нь хүний бүтээл юм гэдэгт олон хүн итгэдэг. Та Ефес 2:19–20-д заасан үнэнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагдаж, оролцохын ач холбогдлыг ойлгоход нь хэн нэгэнд туслахад хэрхэн ашиглаж болох вэ?

Хангалттай цаг гаргаж өгсний дараа суралцагчдыг ярилцсан зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад урь.

Нэг суралцагчийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлсэн дараах үгийг чанга уншихад урь. Ахлагч Кристоффэрсон Сүмийн зорилгын талаар юу гэж хэлснийг сонсохыг ангийнхнаас хүс. (Та энэ мэдэгдлийн хувийг суралцагч бүрд өгч болно.)



“Өөрсдийгөө сүсэг бишрэлтэй эсвэл сүнслэг гэж боддог ч Сүмийн үйл ажиллагаанд оролцох юм уу тэр бүү хэл ийм байгууллагын хэрэгцээг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс байдгийг би олж мэдсэн юм. Тэдний хувьд шашны үйл нь цэвэр хувь хүний асуудал байдаг. Гэхдээ Сүм бидний сүнслэг байдлын цөм болох Есүс Христийн бүтээл билээ. ...

Дараа нь цаг хугацааны голчид, Есүс сайн мэдээг нэгэн зэрэг олон үндэстэнд болон янз бүрийн хүмүүст хүргэх арга замаар ажлаа зохион байгуулсан байна. Есүс Христийн Сүм болох энэ байгууллага нь “элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож, Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болон” байгуулагджээ [Ефес 2:20]. Үүнд дал, ахлагч, бишоп, санваартан, багш нар, диконууд гэх мэт нэмэлт албан тушаал орсон байна. ...

Их Эзэний дэлхий дээр байхдаа зохион байгуулсан Сүм урвалтад өртөж, задран үгүй болсноос хойш Тэрээр бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмийг дахин зохион байгуулжээ. Есүс Христийн сайн мэдээг номлох, авралын ёслолуудыг гүйцэтгэх зорилго, өөрөөр хэлбэл хүмүүсийг Христэд авчрах гэсэн эртний зорилго нь хэвээр үлдсэн юм” (“Why the Church,” *Ensign*, 2015 оны 11-р сар, 108 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 101).

- Ахлагч Кристоффферсоны хэлснээр эртний болон өнөөгийн Сүмийн зорилго юу вэ?

Дасгал ажил (30–40 минут)

Суралцагчдыг “Бошиглогчид ба илчлэлт” гэсэн сургаалын сэдвээр Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн итгэлээр үйлдэх, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх гэсэн гурван зарчмыг ашиглан дадлага хийхэд тусал.

Энэ хэсгийн дасгалыг хуваарь дээрээ болон суралцагчдынхаа хэрэгцээ шаардлага дээр тулгуурлан нэг эсвэл хэд хэдэн ангид хийж болно.

1-р дасгал (20–25 минут)

Дараах гурван зарчмыг самбарт бич.

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголттой болохыг эрэлхийл.*

Суралцагч бүрд *Залуучуудын бат бөх байдлын төлөө* [товхимол, 2011] товхимлын хувийг тараан өгч, тэднээс энэ товхимлыг уншаад, амьд бошиглогчдын зайлсхийхийг бидэнд зөвлөсөн янз бүрийн үйлдлийг олж тогтоохыг хүс.

Суралцагчдаас олсон зүйлээ хуваалцахыг хүсээд, тэдний хэд хэдэн хариултыг самбарт бич.

Суралцагчдыг өөр шашин шүтлэгтэй найз нь “Надад мормончуудын ... -дэггүй нь их сонин санагддаг” гэж асууж байна гэж төсөөлөхөд урь. Суралцагчдыг самбар дээрх жагсаалтын аль нэгэн зүйлээр дээрх өгүүлбэрийг гүйцээж хэлэхэд урь.



Суралцагчдаас найзынхаа асуултад итгэлтэй хариулахын тулд самбарт бичсэн гурван зарчмыг хэрхэн ашиглаж болох талаар бодож үзэхийг хүс. Тэдэнд үүнийг жүжигчлэн тоглох боломж олгоно гэдгийг тайлбарла. Суралцагчдад бодол санаагаа цэгцлэхэд нь туслахын тулд дараах асуултуудыг

ашиглах талаар бодож үз. (Та эдгээр асуултыг суралцагчдад тарааж өгөх материал хэлбэрээр өгч болох юм.)

Итгэлээр үйлд. Үүнд:

- Бошиглогчдын сургаалд үнэнч дуулгавартай байгаа байдал тань найзынхаа асуултад хариулахад хэрхэн тусалж чадна гэж та бодож байна вэ?
- Та найзынхаа асуултад хариулахдаа түүнийг итгэлээр үйлдэхэд хэрхэн урьж болох вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

- Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөн дэх бошиглогчдын үүргийн тухай та нар юу мэдэх вэ?
- Найзад тань бошиглогчдын талаар ямар буруу ойлголт эсвэл худал таамаглал байж болох вэ?
- Бошиглогчид таныг хүчирхэгжүүлж, Есүс Христ, Тэнгэрлэг Эцэгийн тухай илүү ихийг олж мэдэж авахад тань хэрхэн тусалсан бэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголттой болохыг эрэлхийл.

- Яагаад бошиглогчид найзын тань асуусан зан чанараас зайлсхийхийг бидэнд зөвлөдөг талаар илүү сайн ойлголттой болохын тулд та ямар эх сурвалжийг ашиглаж болох вэ? (Суралцагчдад бошиглогчдын зөвлөгөө, сургаалыг илүү сайн ойлгож, тайлбарлахад нь туслах хожмын үеийн бошиглогчдын сургаал [*Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дээрхийн адил*], хэлсэн үг, гэрчлэлийг хайж олох цаг гаргаж өгөх талаар бодож үз.

Хангалттай цаг гаргаж өгсний дараа суралцагчдыг хос хосоор нь хувааж, дээрх нөхцөлд байгаа найздаа хэрхэн хариулах байснаа нэг нэгэндээ ээлжлэн хуваалцах даалгавар өг. Бүгдэд нь хуваалцах боломж олгосны дараа цөөн суралцагчийг хожмын үеийн бошиглогчдын талаар гэрчлэлээ хуваалцахад урьж, энэ үйл ажиллагааг дуусгах тухай бодож үз.

Дасгал 2 (10–15 минут)

Дараах гурван асуултыг самбарт бич. Үүнд:

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлгож авахыг эрэлхийл.*

Дараах нөхцөл байдлыг ангийнхандаа чанга уншиж өг.

Чуулгын эсвэл ангийн тань найз Мючел эсвэл Сүмийн ням гаргийн цуглаанаа тасалж эхлэв. Та энэ талаар түүнтэй ярилцахаар шийдсэн. Найз тань “Би яагаад тодорхой нэг сүмд явах хэрэгтэй гэдгээ ойлгохгүй байна. Зөвхөн манай сүмд ч биш өөр ямар ч сүмд явдаггүй олон сайн хүн дэлхий дээр байна шүү дээ. Хэрэв тэд сайн амьдарч, бусдад сайхан хандаж л байвал тэнгэрт орох боломжтой гэж би боддог” гэж хариулав.

- Бошиглогчид ба илчлэлтийн талаарх ямар сургаалын ойлголт найзад тань Сүмийн цуглаандаа итгэлтэй оролцохын ач холбогдлыг ойлгоход туслах вэ?
- Та найздаа Сүмийн цуглаануудад оролцохын ач холбогдлыг илүү сайн ойлгож, итгэлээр үйлдэх, утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэхэд нь туслахын тулд юу хийж болох вэ?

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдад энэ хичээлийн жил үзсэн төгс эзэмших сургаалын хэсгүүдээ эргэн харах цөөн минутын хугацаа олго. Нэг суралцагчийг судраа аван, самбарын өмнө гарч ирэхэд урь. Бусдадаа харуулалгүйгээр нэг төгс эзэмших сургаалын хэсгийг гаргахыг түүнээс хүс. Суралцагчаар төгс эзэмших сургаалын хэсгээс нэг үгийг самбарт бичүүл. (Суралцагчаас *ба, болон* гэдгээс өөр, уг хэсгийн түлхүүр үгийг сонгож бичихийг хүс.)

Бусад суралцагчийг судраасаа энэ үг орсон байж болох төгс эзэмших сургаалын хэсгийг олоход урь. Самбарт бичсэн нэг үгийг ашиглан хэн ч зөв хэсгийг олж чадахгүй бол суралцагчаас төгс эзэмших сургаалын хэсгээс дахиад өөр нэг үгийг нэмж бичихийг хүс. Суралцагчдаас ядаж нэг нь зөв хэсгийг олох хүртэл ийнхүү үргэлжлүүлэн хий. Бусад суралцагчаас уг хэсгийг нээж, хамтдаа чанга уншихыг хүс. Дараа нь энэ үйл ажиллагааг өөр нэг суралцагчтай, өөр төгс эзэмших сургаалын хэсэг дээр давтан хий.

Санваар ба санваарын түлхүүрүүд

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (20 минут)

1-р хэсэг (7 минут)

Нэг түлхүүр барьж эсвэл самбар дээр түлхүүр зураад, юунд ашигладаг болохыг суралцагчдаас асуу. Их Эзэн Өөрийн санваар, ажлыг дэлхий дээр хэрхэн удирдаж, чиглүүлдгийг ойлгоход бидэнд туслахын тулд түлхүүртэй адилтган тайлбарладаг гэдгийг тайлбарла.

Цөөн суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Санваар ба санваарын түлхүүрүүд” гэсэн сургаалын 6 дахь сэдвийг ээлжлэн чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, санваарын түлхүүр гэж юу болох мөн тэдгээр нь санваарын хүчтэй хэрхэн холбогддогийг ойлгоход туслах сургаалын мэдэгдлүүдийн доогуур зурахыг хүс.

- Санваарыг хэрхэн тодорхойлсон байна вэ?
- Санваарын түлхүүр гэж юу болохыг тодорхойлдог ямар сургаалын мэдэгдлийг та олж тогтоосон бэ? (Суралцагчдаас уншсан зүйлээсээ сургаалын хэд хэдэн мэдэгдлийг ярилцахыг хүсэж болно. Тэднийг хариулсны дараа гурав дахь догол мөрөнд байх **Санваарын түлхүүр нь ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх мэдэл буюу дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдан, чиглүүлэхийн тулд Бурханы хүмүүнд өгсөн хүч юм** гэсэн сургаалыг тэмдэглэхэд урь.)

Суралцагчдад энэ сургаалыг илүү сайн ойлгоход туслахын тулд тэднийг дараах асуултыг ярилцаж байхдаа энэ сургаалын сэдэв дээр тэмдэглэсэн зүйлээ ашиглахад урь.

- Та нар санваарын түлхүүр, ёслолуудын хооронд ямар холбоо байгааг харж байна вэ?
- Зохих санваарын түлхүүртэй хүмүүс санваарын ямар ёслолыг батлах ёстой вэ?

Авралын ёслолыг гүйцэтгэхэд (баптисм, гишүүний баталгаа, Мелкизедек санваарын томилот [эрэгтэйчүүдэд], ариун сүмийн хишиг, лацдан холболт гэх мэт) зохих санваарын түлхүүрийг атгадаг эсвэл уг түлхүүрийг атгадаг хүний удирдлага доор ажилладаг санваарын удирдагчийн зөвшөөрөл хэрэгтэй гэдгийг ойлгоход суралцагчдад тусал (мөн *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Ёслолууд ба гэрээнүүд” гэх сургаалын 7 дахь сэдвийг үзнэ үү). Түүнчлэн хүүхдэд нэр өгч адислах, нутаглуулах газрыг онцгойлон адислах, патриархын адислал өгөх, ариун ёслолыг бэлтгэх, адислах, түгээх зэрэгт ийм зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Харин Мелкизедек санваартнууд

санваарын удирдагчаас зөвшөөрөл авалгүйгээр тосыг ариулан адисалж, өвчтэй хүмүүсийг адислан, эцгийн болон тайтгаруулах адислал, зөвлөгөө өгч болно.


- Сүм дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дуудлага, санваарын түлхүүрийн үүрэг хариуцлага хоёр хоорондоо ямар холбоотой вэ?

2-р хэсэг (7 минут)

Суралцагчидтай хамт дараах сургаалыг авч үз. Санваарын түлхүүр нь ерөнхийлөгчийн зөвлөлийн эрх мэдэл буюу дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдан, чиглүүлэхийн тулд Бурханы хүмүүнд өгсөн хүч юм. Суралцагчдад энэ үнэний талаарх ойлголтоо гүнзгийрүүлэхэд нь туслахын тулд түлхүүрээр асдаг ч түлхүүрийг нь өгөөгүй нэгэн тээврийн хэрэгсэл байгаагаар төсөөлөхөд тэднийг урь.

- Хэрэв танд тээврийн хэрэгсэл ашиглах эрхийг аль хэдийн өгсөн юм бол яагаад түлхүүр хэрэг болно гэж? (Хэдийгээр тэдэнд машин ашиглах эрх байж болох ч машиныг асааж, ажиллуулахад түлхүүр хэрэгтэй.)
- Энэ зүйрлэл нь дэлхий дээрх санваарын ажил, Бурханы хаант улсыг удирдан чиглүүлэхэд санваарын түлхүүр хэрэгтэй гэдэгтэй хэрхэн холбоотой байж болох вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлсэн дараах тайлбарыг үзүүлж эсвэл хувилж өг. Нэг суралцагчийг ерөнхийлөгч Нэлсоний тайлбарыг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, ерөнхийлөгч Нэлсон санваарын түлхүүрийг хэрхэн дүрсэлсэн болохыг олж мэдэхийг хүс.



“Түлхүүрүүд бол чухал, үнэ цэнтэй зүйлс юм. Бидний ихэнх нь хаа явсан газраа халаасандаа юм уу түрүүвчиндээ түлхүүр авч явдаг. Зарим түлхүүр чухал, үнэ цэнтэй байхаас гадна нандин, хүчтэй, далд байдаг. Тэдгээр нь мөнхийн ач холбогдолтой. Мөн тэдгээр нь санваарын түлхүүрүүд юм. ...

Санваар бол хүмүүст авралыг тохинуулахын тулд хүмүүнд олгосон Бурханы эрх мэдэл билээ. ‘Эдгээр ажлыг удирдах хүч нь санваарын түлхүүрүүдэд үндэслэгдсэн байдаг’ (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 141). Бид санваартан байх, санваарын түлхүүрийг атгах хоёрыг хооронд нь ялгаж салгадаг. Хүнд түлхүүрийг өгөх үед тэр санваарыг дээрээс нь нэмж авдаггүй. Түүнд байгаа зүйл нь санваарын ажлыг удирдах эрх юм” (“Keys of the Priesthood,” *Ensign*, 2005 оны 10-р сар, 40).

- Та нар санваарын түлхүүрийг илүү сайн ойлгоход тусалсан ямар зүйлийг ерөнхийлөгч Нэлсоний тайлбараас мэдэж авсан бэ?

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Санваар ба санваарын түлхүүрүүд” гэх сургаалын 6 дахь сэдвийн дөрөв дэх догол мөрийг дотроо уншихад урь. Тэднээс санваарын түлхүүр атгадаг хүмүүсийн зарим үлгэр жишээг хайж олохыг хүс. Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь.

- Таны амьдрал хэзээ санваарын түлхүүрээ ашигладаг хэн нэгнээр адислагдаж байсан бэ?

3-р хэсэг (6 минут)

Самбарт *Матай 16:15–19* гэж бичээд, энэ нь санваарын түлхүүрийн талаар бидэнд заадаг төгс эзэмших сургаалын хэсэг гэдгийг тайлбарла. Суралцагчдыг энэ хэсгийг төгс эзэмших сургаалын хэсэг хэмээн онцлон тэмдэглэхэд урь. Тэднийг санваарын түлхүүрийн талаар энэ судрын хэсэгт заасан сургаалыг санахад туслах түлхүүр үгсийг судрынхаа захад бичихэд урамшуулан дэмж.

Аврагч нэг удаа төлөөлөгчдөөсөө Өөрийг нь тэд хэн гэж боддог талаар асуусан гэдгийг тайлбарла. Петр хариуд нь Есүс бол Бурханы Хүү гэдгийг мэддэг болохоо гэрчилсэн юм. Дараа нь Есүс Петрт Өөрийн хаант улсын түлхүүрийг өгнө хэмээн тунхагласан байдаг. Цөөн суралцагчийг Матай 16:15–19-ийг ээлжлэн чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, Есүс Петрт санваарын түлхүүрийн тухай юу гэж хэлснийг олж мэдэхийг хүс.

- 19-р шүлэгт цэдэглэснээр Петр хаант улсын түлхүүр буюу санваарын түлхүүрийг хүлээн авсныхаа дараа юу хийх хүчтэй болно гэж Аврагч хэлсэн бэ? (Дэлхий дээр болон тэнгэрт холбож, таслах хүчтэй болно гэж хэлсэн. Энэ нь эдгээр санваарын түлхүүрээр гүйцэтгэдэг ёслолууд болох ариун сүмд гэр бүлүүдийг холбох эсвэл лацдан холбох гэх мэт үйл ажиллагаанууд нь мөнх бус амьдралд болон үүрд мөнхөд хүчин төгөлдөр байна гэсэн үг юм.)
- Та энэ төгс эзэмших сургаалын хэсгийг өнөө үед бошиглогч, төлөөлөгчдийн Бурханы ажлыг удирдахын тулд атгаж буй эрх мэдлийн ач холбогдлыг ойлгоход нь хэн нэгэнд туслахад хэрхэн ашиглаж болох вэ?

Тэмдэглэл: Та төгс эзэмших сургаалын хэсгүүдийг чээжилж мөн ашиглах боломжийг суралцагчдадаа олгохын тулд тэдгээрийг дараагийн өдрүүдэд давтах хэрэгтэй. Үүнийг болон хичээлийн жилийн турш сурсан бусад төгс эзэмших сургаалын хэсгийг давтах боломжийг эрэлхийл.

Дасгал ажил (25–30 минут)

Суралцагчдад *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Санваар ба санваарын түлхүүрүүд” гэх сургаалын 6 дахь сэдвийг авч үзэх үед Сүнслэг мэдлэг олж авах нь хэсгийн гурван зарчмыг хэрэгжүүлэхэд тусал. (Та эдгээр зарчмыг дасгал ажлыг хийж эхлэхээс өмнө самбарт бичиж болно.)

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санааг болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл.*



Ангийг гурван бүлэг болгон хуваа. Мөн бүлгийн дугаартай нь таарах тарааж өгөх материалыг бүлэг тус бүрд тарааж өг. Бүлэг бүрд тарааж өгөх материал дээрх үйл явдал, асуултыг ярилцах 8–10 минут өг. Бүлгээрээ ярилцсаны дараа бүх суралцагчид даалгасан асуултад хариулах дадлагыг нөгөө хоёр бүлгийнхээ суралцагчидтай хийх боломж олдоно гэдгийг тайлбарла.

1-р бүлэг

Бүлгээрээ дараах үйл явдлыг ярилц.

Та номлогчоор үйлчилж байгаа бөгөөд хамтрагчтайгаа хамт баптисмын ач холбогдлын талаар сонирхогчдоо зааж байна. Сонирхогчоо баптисм хүртэхэд урихад тэр “Би яагаад дахин баптисм хүртэх хэрэгтэй юм бэ? Би сүмдээ аль хэдийн баптисм хүртсэн шүү дээ” гэж танаас асуув.

Доорх зарчим, асуултыг ашиглан хэрхэн сонирхогчдоо тусалж болох талаар ярилц.

Итгэлээр үйлд. Үүнд:

- Сонирхогч тань санваарын эрх мэдлээр мөн санваарын түлхүүрийг атгадаг хүний удирдлагаар яагаад баптисм хүртэх ёстой болохоо ойлгохыг эрэлхийлж байхдаа итгэлээр үйлдэхийн тулд юу хийж болох вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

- Санваар, санваарын түлхүүрийн тухай ойлголт нь сонирхогчийнхоо асуултад хэрхэн өөр өнцгөөс хариулахад туслах вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл.

- Матай 16:15–19 дээр заасан энэ сургаал асуултынхаа хариултыг олоход сонирхогчид тань хэрхэн туслах вэ?
- Зохих эрх мэдлээр баптисм хүртэх ёстой шалтгааныг ойлгоход сонирхогчид тань туслах судрын өөр хэсгүүд байдаг уу?

2-р бүлэг

Бүлгээрээ дараах үйл явдлыг ярилц.

Найз тань ариун явдлын хуультай холбоотой ноцтой нүгэл үйлдсэнээ мөн наманчлахаар хичээж байгаагаа танд хэлэв. Та судруудыг судалж байхдаа Сүмийн тойрог, салбар бүрийн бишоп, салбарын ерөнхийлөгч “наманчлалын сайн мэдээний” (С ба Г 13:1) түлхүүр бүхий Аароны санваарын түлхүүрүүдийг атгадаг гэдгийг мэдэж авсан.

Та найздаа бишоптойгоо уулзах нь зүйтэй хэмээн хэлсэн ч тэр “Би яагаад бишоптой уулзах ёстойгоо мэдэхгүй байна. Би нүглээ наманчлах хэрэгтэй гэдгээ мэдэж байгаа ч Их Эзэнд хандан аль хэдийн наманчилчихсан шүү дээ. Би өршөөл хүсэн залбирч, биеэ өөр байдлаар авч явах болсон. Би ариун ёслолоос хүртэж байгаа. Би Их Эзэнээр өршөөгдөхийн тулд яагаад бишоптойгоо уулзах хэрэгтэй юм бэ? Энэ чинь Их Эзэн бид хоёрын л хоорондын асуудал юм биш үү?” гэж хариулав.

Та доорх зарчим, асуултуудыг ашиглан найздаа хэрхэн хариулж болохоо ярилц.

Итгэлээр үйлд. Үүнд:

- Таны найз Аврагчид болон Түүний эрх мэдэл олгосон үйлчлэгчдэдээ хүртээсэн санваарын түлхүүрүүдэд итгэх итгэлээ хөгжүүлж, хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

- Бишопын атгадаг санваарын түлхүүрийн тухай ойлгох нь найзын тань асуултыг хэрхэн тодорхой болгож өгөх вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл.

- Матай 16:19 дээрх Аврагчийн үгс найзад тань бишопын атгадаг санваарын түлхүүрүүд нь нүглийн өршөөл гэх мэт түүний хүртэх боломжтой мөнхийн адислалтай хэрхэн холбоотой болохыг ойлгоход хэрхэн туслах вэ?
- Найз тань илүү гүн ойлголт олж авахын тулд тэнгэрээс томилогдсон өөр ямар эх сурвалж руу хандаж болох вэ?

3-р бүлэг

Бүлгээрээ дараах үйл явдлыг ярилц.

Танай гэр бүл хамаатнуудтайгаа долоо хоногийн турш амралтад явж байхдаа ням гарагт очих салбар, тойргийн талаар ярилцав. Аароны санваарын прист үеэл тань та нар руу хараад, “Бид яагаад өөрсдөө ариун ёслолын цуглаан хийж болохгүй гэж? Би прист бас ариун ёслол адислан түгээж, харин та мөн гэр бүлийн бусад гишүүн маань залбирч, үг хэлж болно шүү дээ” гэв.

Та нар доорх зарчим, асуултуудыг ашиглан үеэлдээ хэрхэн хариулж болох талаар ярилц.

Итгэлээр үйлд. Үүнд:

- Таны гэр бүл амралтынхаа үеэр ариун ёслолоос хэрхэн хүртэхээ төлөвлөж байхдаа санваарын ажлыг удирдах санваарын түлхүүрийг атгадаг хүмүүсийн эрх мэдэлд итгэлээ хэрхэн харуулж болох вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

- Санваарын түлхүүртэй холбоотой сургаалыг ойлгох нь санваартан ариун ёслол түгээх гэх мэт ёслолыг хэзээ гүйцэтгэдэг болохыг тодорхой болгоход хэрхэн туслах вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийл.

- Та санваартан хэзээ санваарын ёслол гүйцэтгэх эрх мэдэлтэй болох тухай илүү сайн ойлгуулахын тулд тэнгэрээс томилогдсон ямар эх сурвалж руу хандаж болох вэ?

Суралцагчдад даалгасан үйл явдал дээрх асуулттай нь холбоотой тэнгэрээс томилогдсон эх сурвалжийг олж тогтооход тусламж хэрэгтэй бол дараах эх сурвалжуудыг судлахад тэднийг урь.

1-р бүлэг: Сургаал ба Гэрээ 22:2–4.

2-р бүлэг: Мозая 26:12–15, 29–31; ахлагч К.Скотт Грөү, “Би яагаад гэм буруугаа бишоптоо хүлээх хэрэгтэй юм бэ? Үүний тулд би юу хийх хэрэгтэй вэ?” *New Era*, 2013 оны 10-р сар, 28–30; эсвэл *Лиахона*, 2013 оны 10-р сар, 58–60.

3-р бүлэг: “Санваарын ёслолууд ба адислалууд,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.1, LDS.org; ахлагч Даллин Х.Өүкс, “Санваарын түлхүүрүүд ба эрх мэдэл,” *Ensign*, 2014 оны 5-р сар, 49–52 эсвэл *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 68.

Бүлэг бүрийг оногдсон үйл явдлаа мөн хэрхэн хариулахаа ярилцсаны дараа суралцагчдыг 1, 2, 3-р бүлэг тус бүрээс нэг нэг суралцагч оролцсон бүлгүүдэд хуваа. Суралцагч бүрийг өөрт оногдсон үйл явдлыг бүлгийнхээ суралцагчдад уншиж өгч, дараа нь тухайн асуултад хэрхэн хариулж болохыг жүжиглэн үзүүлэхэд урь.

Хангалттай цаг гаргаж өгсний дараа цөөн суралцагчийг санваарын түлхүүр атгадаг хүмүүсээр удирдуулснаар ирэх адислалын тухай бодол санаа, гэрчлэлээ хуваалцахад урь.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдыг хичээлийн туршид сурсан төгс эзэмших сургаалуудынхаа байрлалыг санахад нь туслахын тулд суралцагч бүрээр 4x4 хүснэгтийг цаасан дээр зуруул. Тэднээс мөр бүрийг дээрээс нь доош тоогоор дугаарлаж, баганын дээд талд А, Б, В болон Г үсэг бичихийг хүс.

	А	Б	В	Г
1				
2				
3				
4				

Өнөөдрийн байдлаар суралцагчдын суралцсан төгс эзэмших сургаалын хэсгийг дахин авч үз. Дараа нь тэднээс төгс эзэмших сургаалын 16 эшлэлийг хүснэгтэд бичихийг хүс. (Хэрэв суралцагчид 16-аас цөөн хэсгийг чээжилсэн бол зарим хэсгийг нэгээс олон удаа бичиж болно. Хэрэв тэд 16-аас олон хэсгийг чээжилсэн бол та шаардлагатай мөр, баганыг тэднээр нэмүүлж болно.

Төгс эзэмших сургаалын хэсгээс уншиж байхад суралцагч бүрээс тухайн хэсэгтэй таарч байна гэж бодсон хүснэгтэн дэх эшлэл дээр хуруугаараа дарахыг хүс. Та уншиж дууссаныхаа дараа тэдний хариултыг шалгахын тулд эшлэлийг чанга хэл. Хэрэв тэд зөв эшлэл зааж байвал үүнийг Х-ээр тэмдэглүүл.

Суралцагч аль чиглэл нь хамаагүй 4 дөрвөлжинг тэмдэглэсэн тохиолдолд “Төгс эзэмших сургаал” гэж чанга хэлэх ёстой. Та хүн нэг бүрийг дөрвөн мөр дараалан тэмдэглэх хүртэл эсвэл суралцагчид бүх дөрвөлжингөө тэмдэглэж дуустал үргэлжлүүлж болно.

Ёслолууд ба гэрээнүүд

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (20 минут)

1-р хэсэг (10 минут)

Ёслолууд ба гэрээнүүд гэсэн үгсийг самбарт бич. Суралцагчдыг эдгээр үгийг сайн мэдэхгүй хэн нэгэнд хэрхэн тодорхойлох байснаа тайлбарлахад урь.

Цөөн суралцагчийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Ёслолууд ба гэрээнүүд” гэсэн сургаалын 7 дахь сэдвийн доор байх догол мөрүүдийг ээлжлэн чанга уншихад урь. Дагаж уншаад, ёслолууд ба гэрээнүүд гэж юу болохыг илүү сайн ойлгоход туслах үг, хэллэгүүдийг тэмдэглэхийг суралцагчдаас хүс.

Хангалттай цаг гаргаж өгсний дараа цөөн суралцагчийг сурсан зүйлээ хуваалцахад урь. Дараах асуултуудыг тавь. Үүнд:

- Авралын ёслол гэж юу вэ?
- Та сайн мэдээний ямар аврах ёслолуудыг хүлээн авсан бэ?
- Энэ сургаалын сэдэв баптисм яагаад чухал болох талаар юу зааж байна вэ? (Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материалууд* дээр байгаа **Баптисм нь хувь хүний хувьд Есүс Христийн Сүмийн гишүүн болж, селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй чухал ёслол мөн** гэсэн үгнэийг тэмдэглэж авахад урь.)
- Яагаад баптисм Есүс Христийн Сүмийн гишүүн болж, селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй гэж та нар бодож байна вэ?

Баптисм хүртэж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлагдаж байсан үеийнхээ талаар хэсэг хором дотроо бодохыг суралцагчдаас хүс. Цөөн суралцагчийг хаана баптисм хүртсэн, хэн хүртээсэн мөн уг үйл явдлын талаар төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээс хуваалцахад урь.

2-р хэсэг (10 минут)

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал дээрх “Ёслолууд ба гэрээнүүд” гэсэн сургаалын сэдэвт заасан дараах сургаалыг суралцагчидтайгаа хамт авч үз. Тухайлбал: Баптисм нь хувь хүний хувьд Есүс Христийн Сүмийн гишүүн болж, селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй чухал ёслол мөн.

- Энэ сургаалыг Шинэ Гэрээний ямар судрын хэсэг баталдаг вэ?

Суралцагчдыг Иохан 3:5-ыг гаргахад урь. Та тэдэнд энэ төгс эзэмших сургаалын хэсгийг хайж олоход хялбар байлгах үүднээс онцгойлон тэмдэглэхийг санал болгож болно. Иохан 3 бол сайн мэдээний талаар илүү ихийг мэдэхийг хүссэн фарисай үндэстэн Никодем гэгч хүнд Аврагчийн заасан сургаалыг агуулсан байдгийг тайлбарла.

Нэг суралцагчаас Иохан 3:5-ыг чанга уншихыг хүс. Ангийнхныг дагаж уншаад, Аврагч Бурханы хаант улсад ороход юу шаардлагатай гэж хэлснийг олж мэдэхэд урь.

- Аврагч Бурханы хаант улсад ороход юу шаардлагатай гэж хэлсэн бэ?
- “Уснаас төрөх” гэдэг нь ямар авралын ёслолын талаар өгүүлж байна вэ?
- “Сүнснээс төрөх” гэдэг нь ямар авралын ёслолын талаар өгүүлж байна вэ?
- Баптисм хүртсэн нь селестиел хаант улсад зохистойгоор орж, Тэнгэр дэх Эцэгтэйгээ дахин хамт амьдрах хичээл зүтгэлд тань хэрхэн тусалсан бэ?

Дасгал ажил (10 минут)

Суралцагчдад *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсэгт орсон гурван зарчмын талаар сануулж, тэдгээрийг самбарт бич.

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийл.*

Суралцагчдад “Ёслолууд ба гэрээнүүд” сэдэвтэй холбоотой асуулт бүхий эдгээр зарчмыг ашиглан холбох дадлага хийхэд нь туслахын тулд дараах үйл явдлыг чанга унш.

Найзуудын тань нэг нь Сүмийн талаар илүү ихийг мэдэх сонирхолтой байгаа бөгөөд номлогчдоос хичээл авч байгаа. Тэр Мормоны Номын хэсгээс уншиж, Сүмийн цуглаанд хэд хэдэн удаа ирж, сэргээгдсэн сайн мэдээнд итгэж байгаагаа илэрхийлсэн. Найз тань нэг өдөр номлогчдоос хичээл авсныхаа дараа гэр рүүгээ явж байх замдаа “Би номлогчдын зааж байгаа зүйлсэд итгэж байгаа ч тодорхой нэгэн сүмд баптисм хүртэлгүйгээр сайн хүн, сайн Христэд итгэгч байж болохгүй гэж үү?” гэв.

- Та ямар арга замаар найзыгаа баптисм хүртэхэд урих вэ гэж бодож үзэхийн зэрэгцээ итгэлтэйгээр үйлдэхэд урьж болох вэ?
- Та найздаа баптисмын талаарх асуултаа мөнхийн талаас нь авч үзэхэд хэрхэн тусалж чадах вэ? Та түүнд баптисмын ёслолын мөнхийн ач холбогдлыг ойлгоход нь туслахын тулд Авралын төлөвлөгөө, Есүс Христийн сайн мэдээний ямар үнэнийг хуваалцаж болох вэ?
- Та тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлгож авахаар эрэлхийлэхэд нь түүнд туслахын тулд юу хийж болох вэ?
- Та найздаа туслахын тулд Иохан 3:5-ыг хэрхэн ашиглаж болох вэ?

Суралцагчдад судруудын удирдамжаас (lds.org/topics) “Баптисм” гэдэг үгийг оруулан, найзын тань асуулгад тусалж болох нэмэлт мэдээлэл эсвэл судрын

хэсгийг олж мэдэх цөөн минут өг. Хангалттай цаг гаргаж өгсний дараа суралцагчдыг хос болгон эсвэл жижиг бүлгүүд болгон хувааж, олсон зүйлээ бие биетэйгээ хуваалцахад урь. Та бүлэг бүртэй хэсэг хугацааг өнгөрүүлэн, тэдний ярилцлагыг сонсож, шаардлагатай үед туслах талаар бодож үз.

Та ёслол, гэрээнүүдийн ач холбогдлыг, ялангуяа Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх баптисмын ёслолын тухай гэрчлэлээ хуваалцахад нэг ба түүнээс олон суралцагчийг урин, хичээлээ дуусгаж болно.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдаас төгс эзэмших судрын хэсгүүдийг хэрхэн чээжилснийг нь шалгах шалгалт авах тухай бодож үз. Асуултад хэсгүүдэд заасан үнэнийг харуулах түлхүүр үгс эсвэл судрын заалт, хэсгүүдээс авсан эшлэл юм уу үйл явдал зэрэг сэжүүр орж болно. Эдгээр шалгалтыг асуултыг унших эсвэл самбарт бичих байдлаар авч болно. Суралцагчдыг шалгалтаа өгч дууссаны дараа өндөр үнэлгээ авсан суралцагчдыг бага үнэлгээ авсан суралцагчидтай хос болгохыг бодоорой. Өндөр үнэлгээ авсан суралцагч бага үнэлгээ авсан суралцагчид төгс эзэмших сургаалын хэсгийг үр дүнтэй судалж мөн сайжруулах арга замыг ойлгоход нь тусалж болно. Энэ хүчин чармайлтын нэг хэсэг болгон хосууд дараагийн шалгалтад илүү өндөр нийлбэр дүн авах зорилго тавьж болно. Суралцагчдын зорилго, өсөлт хөгжлийг харуулах хүснэгт юм уу мэдээллийн самбар хийх талаар бодож үз.

Гэрлэлт ба гэр бүл

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (25–30 минут)

1-р хэсэг (10 минут)

Самбарт 1 Коринт 11:11-ийг бич. Энэ нь төгс эзэмших сургаалын хэсэг гэдгийг онцолж хэлээд, суралцагчдыг энэ хэсгийг судар дээрээсээ олж, хайж олоход хялбар байлгах үүднээс онцгойлон тэмдэглэхэд урь. Энэ хэсэг нь Гэрлэлт ба гэр бүл гэсэн сургаалын сэдвийг ойлгоход бидэнд тусалдаг гэдгийг тайлбарла.

Төлөөлөгч Паул Коринтын (одоогийн Грек) Сүмийн гишүүдэд бичсэн захидалдаа гэрлэлтийн тухай заасан гэдгийг тайлбарла. Нэг суралцагчийг 1 Коринт 11:11-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, эхнэр, нөхрийн харилцааны талаар Паул юу гэж заасныг олж мэдэхийг хүс.

“Эзэн дотор” гэдэг үг нь мөнх амьдралыг хүлээн авч, Түүнтэй адил болох боломж олгодог Тэнгэрлэг Эцэгийн сайн мэдээний төлөвлөгөөг хэлж байгаа гэдгийг тайлбарла.

- Энэ шүлэг эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт ямар хэрэгтэй болох талаар юу зааж байна вэ?

Суралцагчдаас *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Гэрлэлт ба гэр бүл” гэх 8 дахь сэдвийг уншаад, бидэнд Бурханы төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт ямар хэрэгтэй болохыг ойлгоход туслах мэдэгдлийг олж мэдэхийг хүс.

Суралцагчдыг олж мэдсэн зүйлээ хуваалцахад урь. Дараа нь энэ сэдвээс **Эрэгтэй, эмэгтэй хүн зөвхөн селестиел гэрлэлтийн гэрээнд орж, гэрээгээ тууштай сахиснаар бурханлаг хийгээд мөнхийн чадавхаа гүйцэлдүүлж чадна** гэсэн үнэнийг онцлон тэмдэглэ. Та суралцагчдад энэ зарчмыг 1 Коринт 11:11-ийн хажууд, судар дээрээ бичихийг санал болгож болно.

2-р хэсэг (5–10 минут)

Эрэгтэй, эмэгтэй хүн зөвхөн селестиел гэрлэлтийн гэрээнд орж, гэрээгээ тууштай сахиснаар бурханлаг хийгээд мөнхийн чадавхаа гүйцэлдүүлж чадна гэсэн сургаалыг самбарт бич. Энэ сургаалыг заадаг Шинэ Гэрээн дээрх төгс эзэмших сургаалын хэсгийг олохыг суралцагчдаас хүс. Суралцагчид 1 Коринт 11:11-ийг нээсэн бол нэг суралцагчийг чанга уншихад урь.


Нэг суралцагчийг самбарын өмнө гарч ирэхэд урь. Дараа нь уг суралцагчаас хоёр гараа сунгахыг хүс.

- Хоёр гар тань адилхан байна уу?
- Хоорондоо ямар ялгаатай байна вэ?

Суралцагчаас нэг гараа ардаа авахыг хүс. Дараа нь ангийнханд дараах асуултуудыг тавь.

- Зөвхөн нэг гараараа хийхэд хэцүү байж болох ямар үйл ажиллагаанууд байдаг вэ?
- Хоёр гар хамтдаа ажилласнаар биднийг илүү хүчирхэг болгодог ямар жишээ байдаг вэ?
- Гарын жишээг бид эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлтийн талаарх сургаалын энэ үнэнтэй хэрхэн холбож болох вэ?

Зарим хүнд энэ амьдралдаа селестиел гэрлэлтийн гэрээнд орох боломж олдохгүй гэдгийг онцлон хэл. Нэг суралцагчийг ерөнхийлөгч Ховард В.Хантэрын хэлсэн дараах үгийг чанга уншихад урь.



“Ямар ч зохистой хүнд, ялангуяа мөнхийн гэрлэлтийн болоод мөнхийн гэр бүлийн адислал өгөгдөхгүй байх нь үгүй билээ. Зарим хүнд уг адислалыг хүлээн авахад илүү урт, удаан хугацаа хэрэгтэй байж болох ба магадгүй мөнх бус амьдралын дараах амьдралд очиход хэрэгтэй байж болох ч адислал тэдэнд өгөгдөхгүй байх нь үгүй” (“The Church Is for All People,” *Ensign*, 1989 оны 6-р сар, 76).

- Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд бүх зохистой хүн эцсийн эцэст селестиел гэрлэлтийн гэрээнд орж, мөнхийн гэр бүлтэй болох боломжтой байна гэдгийг ойлгох нь яагаад чухал гэж та нар бодож байна вэ?

3-р хэсэг (10 минут)

Суралцагчдад Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднанийн хэлсэн дараах үгийг үзүүл эсвэл тарааж өг. Нэг суралцагчийг үүнийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлтийн талаар судалж байгаа сургаалын ойлголтуудыг олж мэдэхийг хүс.



“Дэлхий бүтээгдсэний дараа Адамыг Едений цэцэрлэгт байрлуулсан. Гэсэн хэдий ч Бурханы “хүн ганцаар байх нь сайн биш” (Мосе 3:18; Эхлэл 2:18-ыг үзнэ үү) хэмээн хэлсэн нь чухал бөгөөд Ева Адамын эхнэр бөгөөд туслагч нь болжээ. Эрэгтэй, эмэгтэй хүний сүнсний болон бие махбод, оюун ухаан, сэтгэл санааны өвөрмөц нэгдэл нь аз жаргалын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хэрэгтэй байсан. ... Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биеэсээ суралцах, хүчирхэгжүүлэх, адислах, тусалж дэмжих мөн нэг нэгнээ төгс болгохын тулд бүтээгджээ” (“Бид ариун явдалд итгэдэг,” *Ensign*, 2013 оны 5-р сар, 41-42 эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 50).

- Ахлагч Бэднанийн заасан зүйлс 1 Коринт 11:11 дээр заасан үнэнтэй хэрхэн холбогдож байна вэ?

Суралцагчдыг дараах асуултын нэгнийх нь хариуг судлах тэмдэглэлдээ бичихэд урь.

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог шинж, үүрэг хариуцлагууд ямар арга замаар гэрлэлт, гэр бүл дотор бие биенээ харилцан нөхдөг вэ?
- Эхнэр, нөхөр хоёр Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болоход туслах ямар зан чанарыг гэрээт гэрлэлтээр дамжуулан хөгжүүлж чадах вэ?

Цөөн суралцагчийг хариултаа ангийнхантайгаа хуваалцахад урь.

Дасгал ажил (45–55 минут)

Дараах үйл ажиллагаанууд нь суралцагчдад хичээлийн жилийн эхэнд, сүнслэг мэдлэг олж авах нь гэсэн суралцах туршлагаасаа мэдэж авсан зарчмуудаа хэрэгжүүлэхэд тусална. Суралцагчдад эдгээр зарчмыг эргэн санахад туслахын тулд тэдгээрийг самбарт бичих нь тустай байж болох юм. Үүнд:

- *Итгэлээр үйлд.*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийл.*

Та эдгээр үйл ажиллагааг хуваариасаа болон суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагаас хамааран нэг эсвэл өөр өөр өдөр зааж болно.

1-р дасгал (20–25 минут)

Тэмдэглэл: Шаардлагатай бол дараах үйл явдлыг суралцагчдынхаа амьдралын туршлагад тааруулан өөрчилж болно.

Нэг суралцагчийг дараах үйл явдлыг чанга уншихад урь.

Та номлолынхоо дараа сургуульд сурч байхдаа Есүс Христийн талаар хүчтэй гэрчлэлтэй, чамайг хүндэлдэг, хамгийн сайнаараа байж өсөж хөгжихөд тань тусалдаг нэгэн хүнтэй танилцаж, болзож эхлэв. Цаг хугацаа өнгөрөх тусам та хоёрын хайр улам бүр өсөн нэмэгдэж, гэрлэх тухай ярилцдаг болов. Гэхдээ та гэрлэх талаар ярьж эхлэхэд, сургуульд суран, ажиллаж, шинэ ажлаа эхлэхийн зэрэгцээ гэрлэж, гэр бүлтэй болсноор ирэх дарамт, сорилт бэрхшээлээс айж байлаа. Та дотроо “Ер нь сургуулиа төгсөж, сайн цалинтай ажил олж, хангалттай мөнгө хуримтлуултлаа гэрлэж, гэр бүлтэй болохоо азнаж, хойшлуулах нь биед илүү амар, сайн юм биш үү” гэж боддог.

- Энэ нөхцөлд гэрлэлтээ хойшлуулах юм уу гэрлэхээс зайлсхийх нь яагаад уруу татагдаж болзошгүй зүйл байж болох вэ?
- Та энэ асуултын талаар бодож, ирээдүйн төлөвлөгөөгөө гаргахдаа итгэлээр үйлдэхийн тулд юу хийж болох вэ?
- Тэнгэрлэг удирдамж эрэлхийлэх нь танд боловсрол, ажил мэргэжлийн төлөвлөлт, гэрлэлт, гэр бүлийн тал дээр ухаалаг сонголт хийхэд тань хэрхэн туслах вэ?

Суралцагчдыг авралын төлөвлөгөөн дэх гэрлэлт, гэр бүлийн үүрэг хариуцлагын тухай мэддэг зүйлээ бодож үзэхэд урь.

- Бидний 1 Коринт 11:11-ээс сурсан сургаал энэ нөхцөл байдалтай хэрхэн холбогдож байна вэ?
- Та энэ асуудлыг мөнхийн талаас нь авч үзэхийн тулд хэрхэн өөр өнцгөөс, өөр байдлаар авч үзэж болох вэ? (Боломжтой жишээнүүд: Би гэрлэхээ хойшлуулбал юуг орхигдуулах вэ? Гэрлэлт, гэр бүлийг эн тэргүүнд тавивал энэ амьдралд болон мөнх амьдралд ямар ач тус, адислал хүртэж болох вэ?

Ангийг гурваас таван суралцагч бүхий бүлгүүдэд хувааж, гэрлэлт, гэр бүлтэй холбоотой үйлдэл, шийдвэрээ удирдахад туслах нэмэлт ойлголтыг хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы үгс, Сүмийн эх сурвалжаас судлах 5–10 минутыг гаргаж өг. Жишээ өгөхийн тулд та нэг суралцагчийг ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн дараах үгийг чанга уншихад урь.



“Хэрэв та эхнэрээ болон гэр бүлээ санхүүгийн хувьд хэрхэн хангах талаар санаа зовж байвал хосууд хамтдаа хөдөлмөрлөж, арвигч хямгац амьдрахад зовох зүйл байхгүй гэдгийг би амлая. Иймэрхүү хүнд үеүдэд золиослол, хэцүү сонголтуудыг хийж сурснаар та хоёр бие биетэйгээ илүү ойр дотно болно” (“Санваарын хүч,” *Ensign*, 2011 оны 5-р сар, 67 эсвэл 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 74).

Нэмэлт ойлголтыг ямар судар эсвэл эх сурвалжаас мэдэж авснаа ангийнхантайгаа хуваалцахад суралцагчдыг урь.

- Яагаад гэрлэлт, гэр бүлийг амьдралдаа эн тэргүүнд тавих нь чухал гэж та нар бодож байна вэ?
- Та мөнхийн гэрлэлт, гэр бүлийг бий болгоход өөрийгөө бэлтгэхийн тулд одоо юу хийж болох вэ?

2-р хэсэг (25–30 минут)

Дараах үйл явдлыг чанга унш.

Та нэг орой ахтайгаа ярилцаж байтал тэр ижил хүйстний гэрлэлтийн талаар Сүмийн сургаалыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байгаагаа танд итгэж, хэлэв. Тэр “Сүм яагаад ижил хүйстний гэрлэлтийг буруу гэж заасаар байгааг ойлгох нь надад хэцүү байна. Яагаад ижил хүйстний хоорондын үнэнч харилцаанаас хүмүүст ирдэг аз жаргалыг үгүйсгэдэг юм бол?” гэлээ.

Суралцагчдаас энэ нөхцөл байдалд хэрхэн хариулах байснаа тунгаан бодохыг хүс.

- Та ахынхаа асуултад хариулах гэж хичээж байхдаа итгэлээр үйлдэхийн тулд юу хийж болох вэ?
- Танд ахыгаа итгэлээр үйлдэхэд нь ямар арга замаар тусалж болох вэ?
- Бид 1 Коринт 11:11-ийг судлах явцдаа ижил хүйстний гэрлэлтийн асуудлыг Их Эзэний зүгээс ойлгоход туслах ямар сургаалыг мэдэж авсан бэ?

- Өөр ямар сургаалын үнэн бидэнд ижил хүйстний гэрлэлтийн асуудлыг мөнхийн талаас харахад туслах вэ?



Суралцагчдыг илүү сайн ойлголттой болгохын тулд бошиглогчдын сургаалыг судлахад урамшуулан дэмжихээр энэ суралцах туршлагын төгсгөлд байх “Яагаад гэрлэлт чухал байдаг вэ?” тараах материалыг тарааж өг. Үүнийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднарийн “Marriage Is Essential to His Eternal Plan” (“Гэрлэлт бол Түүний мөнхийн төлөвлөгөөнд нэн чухал”) хэлсэн үгнээс авсан болно. Суралцагчдыг ангийнхаа нэг суралцагчтай хамт үүнийг уншаад, ижил хүйстний гэрлэлтийн асуудалд хандахад тэдэнд туслах гэрлэлт, гэр бүлийн талаарх үнэнийг олж мэдэхэд урь.

- Та ахдаа ижил хүйстний гэрлэлтийн асуудлыг авралын төлөвлөгөө, Есүс Христийн сайн мэдээний талаас нь авч үзэхэд туслахын тулд ахлагч Бэднарийн сургаалуудыг хэрхэн ашиглаж болох вэ?

Тэмдэглэл: Та тарааж өгөх материалын оронд Сүмийн удирдагчийн өөр нэг үгийг эсвэл сүүлийн үеийн үгийг ашиглах талаар бодож үз.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдад энэ хичээлийн жилийн турш мэдэж авсан төгс эзэмших сургаалын хэсгээ санаж мөн тэдгээрийг хэрхэн хайж олохоо мэдэж авахад нь туслахын тулд судрууд дээрх хэсгийг хурдан олоход туслах сэжүүрийг ашигла. Түлхүүр үг, хам сэдвийн талаарх мэдэгдэл, сургаал, зарчим, хэрэгжүүлэх санаа зэрэг нь орж болно.

Төгс эзэмших сургаалын хэсгүүдийн байрлалыг олж тогтоох судраар хөөх үйл ажиллагаанууд нь тэдэнд тухайн хэсгийг идэвхтэй судлахад тусална. Судраар хөөх үйл ажиллагаанууд нь хэзээ ч сэтгэл эмзэглүүлж, Сүнснийг сэвтээхэд хүргэх ёсгүй. Суралцагчдад судартаа хүндэтгэлгүй хандах эсвэл хэт улайрахаас зайлсхийхэд тусал. Суралцагчдыг өөр хооронд нь биш, харин тодорхой шалгуурт хүрэхийн тулд өрсөлдүүлэх тухай бодоорой. Жишээлбэл, суралцагчид багштайгаа уралдаж болно эсвэл ангийн хэдэн хувь нь тогтоосон хугацаанд олж чадаж байгаа эсэхийг мэдэхийн тулд өөр хоорондоо уралдаж болно.

Суралцагчдыг судраар хөөх үйл ажиллагаанд оролцоход бэлтгэхийн тулд үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө төгс эзэмших сургаалын хэсгийн эшлэл болон түлхүүр үгсийг давтах хэдэн минут өгөх талаар бод. Тэд үүнийг хамтрагчтайгаа хийж болно эсвэл та нар энэ хэсгийг ангиараа давтаж болно.

Яагаад гэрлэлт чухал вэ?

Ахлагч Дэвид А.Бэднар

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч

“Marriage Is Essential to His Eternal Plan” үгээс эш татав, *Ensign*, 2006 оны 6-р сар, 82–87; эсвэл *Лиакхона*, 2006 оны 6-р сар, 50–55.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-т Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн “эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр

бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна” хэмээн тунхагласан байдаг [“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Чуулганы үгс*, 2010 оны 10-р сар, 129]. Тунхгийн энэ түлхүүр өгүүлбэр нь гэрлэлтийн сургаалын ач холбогдлын тухай олон зүйл заадаг бөгөөд Эцэгийн төлөвлөгөөн дэх гэрлэлт, гэр бүлд нэн шаардлагатай болох зүйлсийг онцолдог. Зөв шударга гэрлэлт нь зарлиг бөгөөд булшнаас цааш үргэлжлэх хайраар дүүрэн гэр бүлийн харилцааг үүсгэх үйл явцын нэгэн чухал алхам юм.

Бидэнд яагаад мөнхийн гэрлэлт нь Эцэгийн төлөвлөгөөнд чухал болохыг ойлгоход тусалдаг хоёр хөдөлшгүй шалтгаан бий.

1-р шалтгаан: *Эрэгтэй, эмэгтэй сүнсний мөн чанар нь бие биенээ гүйцээн, төгс болгодог учраас эрэгтэй, эмэгтэй хүмүүс өргөмжлөл өөд хамтдаа дэвших хувьтай.*

Гэрлэлтийн мөнхийн мөн чанар, ач холбогдлыг зөвхөн Эцэгийн хүүхдүүдээ зориулсан төлөвлөгөөний хамгийн чухал хам сэдвийн хүрээнд авч үзвэл бүрэн ойлгох боломжтой. “Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрлэг Эцэг Эхийн хайртай сүнслэг охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм” [“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”]. Аз жаргалын агуу төлөвлөгөө нь Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн охид, хөвгүүдэд бие махбодтой болон, дэлхийн туршлага олж авч, төгс байдал руу өсөж хөгжиж болох боломжийг олгодог.

“Хүйс бол мөнх бус байдлын өмнөх болон мөнх бус, тэрчлэн мөнхийн хувь хүний болон түүний зорилгын нэн чухал шинж чанар мөн” [“Гэр бүл: Дэлхий даяар өргөх тунхаг”] бөгөөд бидний хэн гэдгийг мөн яагаад дэлхий дээр байгаа болон юу хийх, хэн болох гэж байгааг илүү өргөн хүрээнд тодорхойлдог. Тэнгэрлэг зорилгоор эрэгтэй, эмэгтэй сүнснүүд өөр хоорондоо ялгаатай, өвөрмөц хийгээд харилцан бие биенээ нөхөж байдаг.

Дэлхий бүтээгдсэний дараа Адамыг Едений цэцэрлэгт байрлуулсан. Гэхдээ хамгийн чухал нь, Бурхан ‘хүн ганцаар байх нь сайн биш’ (Эхлэл 2:18; Мосе 3:18) хэмээн хэлсэн бөгөөд Ева Адамын хамтрагч мөн туслагч болсон билээ. Аз жаргалын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь сүнслэг, бие махбод, оюун санаа, сэтгэл санааны чадамжийн өвөрмөц нэгдэл хэрэгтэй байсан. Эрэгтэй, эмэгтэй хүний аль аль нь цор ганц бүтээгдсэн зорилгоо гүйцэлдүүлж чадахгүй байх байсан.

Тэнгэрлэг загварын дагуу эрэгтэй, эмэгтэй хүмүүс төгс төгөлдөр, алдар суугийн бүрэн байдал руу хамтдаа тэмүүлэн, өсөж хөгжих жамтай. Өөр өөрийн гэсэн зан араншин, чадавхынхаа ачаар эрэгтэй, эмэгтэй аль аль нь гэрлэлтийн харилцаандаа өөрийн онцлог үзэл бодол, туршлагыг авчирдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс энэ нэгдэлд өөр өөр байдлаар, адил тэгш эрхтэйгээр хувь нэмэр оруулдаг бөгөөд нэгдмэл байдлыг үүнээс өөр байдлаар бий болгох боломжгүй юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биенээсээ суралцаж мөн бие биенээ хүчирхэгжүүлж, адисалснаар эрэгтэй хүн эмэгтэй хүнийг гүйцээж, төгс болгон мөн эмэгтэй хүн эрэгтэй хүнийг гүйцээж, төгс болгодог. *‘Их Эзэн дотор* эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм’ (1 Коринт 11:11; налуу бичилт нэмэгдсэн).

2-р шалтгаан: *Тэнгэрийн загвараар, мөнх бус амьдралд үр хүүхдүүдийг авчирч, тэднийг өсгөж, хүмүүжүүлэх хамгийн сайн орчныг үүсгэхэд эрэгтэй, эмэгтэй хүн хоёул хэрэгтэй.*

Эрт үед Адам, Ева хоёрт өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэж хэмээн өгсөн зарлиг өнөө үед ч хүчин төгөлдөр. “Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр, нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна. ... Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг” [“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”]. Тиймээс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь мөнх бус байдлын өмнөх сүнснүүд мөнх бус байдалд дамжин ирдэг суваг юм. Гэрлэхээс өмнө бэлгийн харилцаанд огт орохгүй байж, гэрлэснээсээ хойш эхнэр, нөхөртөө туйлын үнэнч байх нь энэ нандин сургийн ариун байдлыг хамгаалдаг.

Хайраар дүүрэн, үнэнч нөхөр болон эхнэртэй гэр орон нь хүүхдүүд хайр, зөв шударга байдалд өсөж чадах мөн хүүхдүүдийн сүнслэг, бие махбодын хэрэгцээнд тохирох эрхэм дээд орчин юм. Эрэгтэй, эмэгтэй хүний аль алиных нь онцлог зан чанар гэрлэлтийн харьцааны бүрэн байдалд хувь нэмрээ оруулдагтай адил эдгээр зан чанар нь хүүхдүүдээ өсгөж, хүмүүжүүлж, заахад амин чухал. "Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй" ["Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"].

Зарлигууд

Тэмдэглэл: Дараах төгс эзэмших сургаалын үйл ажиллагаануудыг нэг эсвэл хэд хэдэн хичээл дээр хийж болно.

Сургаалыг ойлгох нь (25 минут)

1-р хэсэг (10 минут)

Дараах асуултуудыг самбар дээр бич.

- Яагаад Бурхан бидэнд зарлигуудыг өгдөг вэ?
- Бид яагаад тэдгээрийг дуулгавартай дагах ёстой вэ?

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Зарлигууд” гэсэн сургаалын 9 дэх сэдвийн эхний догол мөрийг дотроо уншаад, самбарт жагсаасан асуултын хариултыг олж мэдэхийг хүс.

- Яагаад Бурхан бидэнд зарлигуудыг өгдөг вэ? (Бидэнд өсөж хөгжин, Өөртэй нь адил болоход туслахын тулд зарлигуудыг өгдөг. Зарлигууд нь Бурханы биднийг хайрлах хайрын илрэл юм.)
- Яагаад Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах нь бидэнд чухал вэ? (Зарлигуудыг дуулгавартай дагах нь Их Эзэнийг хайрладгаа харуулах боломжийг бидэнд олгож, аз жаргал, адислал авчрах болно.)

Суралцагчдаас Иохан 14:15-ыг гаргаад, үүнийг төгс эзэмших сургаалын хэсэг болгон онцгойлон тэмдэглэхийг хүсэж болно. Есүс цовдлогдохоосоо өмнө төлөөлөгчидтэйгөө сүүлийн зоог барьсны дараа тэдэнд зарлигуудыг сахих талаар ямар бодолтой байх ёстой тухай нэг чухал ойлголтыг заасан.

Суралцагчдад энэ судрын байрлал, бичвэрийг чээжлэхэд туслахын тулд цөөн минут зарцуулаад, дараа нь асуу.

- Энэ шүлгийн дагуу бид зарлигуудыг дагаснаар Аврагчид юуг харуулдаг вэ? (Суралцагчдыг хариулсны дараа та самбарт **Бид Аврагчийн зарлигуудыг дагаснаар Түүнийг хайрладаг гэдгээ харуулдаг** гэсэн үгнэнийг бичих талаар бодож үз.)
- Яагаад зарлигуудыг сахих нь Аврагчийг хайрлах бидний хайрыг харуулдаг гэж та нар бодож байна вэ?

2-р хэсэг (5 минут)

Суралцагчдыг Матай 22:36–39-ийг Иохан 14:15-ын хажууд, судрынхаа захад солбицсон эшлэл болгон бичихэд урь. Дараа нь тэднийг Матай 22:36–39-ийг гаргаж, үүнийг төгс эзэмших сургаал болгон тэмдэглэхэд урь.

Суралцагчдад энэ хэсгийн агуулгыг ойлгоход туслахын тулд тэднээс Матай 22:34–36-г дотроо уншаад, Аврагчийн тавьсан асуултыг олж мэдэхийг хүс.

- Хуульч Аврагчаас юу гэж асуусан бэ?

Нэг суралцагчийг Матай 22:37–39-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, Аврагчийн хариултыг олж мэдэхийг хүс.

- Аврагч ямар хоёр агуу тушаал байдаг гэж хэлсэн бэ? (Суралцагчид **Хамгийн чухал хоёр тушаал бол бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа Бурхан Эзэнээ хайрла, мөн хөршөө өөрийн адил хайрла** гэсэн сургаалыг олж тогтоох ёстой.)

Нэг суралцагчаас *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Зарлигууд” гэсэн сургаалын 9 дэх сэдвийн хоёр дахь догол мөрийг чанга уншихыг хүс. Ангийнхнаас дагаж уншаад, Бурханыг болон бусдыг хайрлах хоёрын хоорондын харилцаа холбоог олж мэдэхийг хүс.

- Бурханыг болон бусдыг хайрлах хоёр хоорондоо ямар харилцаа холбоотой вэ?
- Яагаад энэ хоёрыг хамгийн агуу тушаал гэж та нар бодож байна вэ?

Суралцагчдыг Бурханд болон эргэн тойрныхоо хүмүүст хайраа харуулахын тулд юу хийж байгаагаа тунгаан бодоход урамшуулан дэмж.

3-р хэсэг (5 минут)

Суралцагчдаас Есүс Христ ямар хоёр агуу тушаал байдаг гэж заасныг мөн энэ үнэнийг заадаг төгс эзэмших сургаалын хэсгийг олж тогтоохыг хүс.

Суралцагчдад Матай 22:36–39-ийг болон хоёр агуу тушаал нь бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа Бурхан Эзэнээ хайрлах мөн хөршөө өөрийн адил хайрлах явдал гэсэн сургаалыг илүү сайн ойлгоход нь тулахын тулд нэг суралцагчийг Матай 22:40-ийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, Есүс Христ энэ хоёр агуу тушаалын талаар юу гэж хэлснийг олж мэдэхийг хүс.

- Есүс энэ тушаалуудын талаар юу гэж хэлсэн бэ? (Хууль, бошиглогчдын заасан бүх зарлиг нь тухайн үеийн судрын хоёр үндсэн хэсэг болох энэ хоёр агуу тушаал дээр суурилдаг эсвэл үндэслэгддэг байв.)

Та Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн дараах үгийг үзүүлж эсвэл тарааж өгч болно. Нэг суралцагчийг уг үгийг чанга уншихад урь. Ангийнхнаас дагаж уншаад, бусад бүх зарлиг хэрхэн энэ хоёр агуу тушаал дээр суурилдаг болохыг олж мэдэхийг хүс.



“Бүх зарлиг хайрын зарчим дээр үндэслэгддэгийг Аврагч тод томруун тодорхойлсон байдаг. Хэрэв бид эдгээр агуу хуулиудыг үл тоомсорлохоо болих юм бол буюу Тэнгэрлэг Эцэгээ болон бусдыг бүх зүрх, сэтгэл, оюун ухаанаараа хайрлаж сурах юм бол бусад бүх юм жам ёсоороо байх болно” (“Бурханы хайр,” *Ensign*, 2009 оны 11-р сар, 24 эсвэл *2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 25).

- Бүх зарлиг хэрхэн энэ хоёр агуу зарлиг дээр үндэслэгддэг вэ?

Суралцагчдад хариулах хангалттай цаг гаргаж өгсний дараа тэднийг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Зарлигууд” гэсэн сургаалын 9 дэх сэдвийн сүүлийн гурван догол мөрийг уншихад урь. Тэднийг тэнд

бичигдсэн бусад зарлигийн зарим нэгийг тэмдэглэж аваад, эдгээр зарлигт дуулгавартай байх нь хэрхэн Бурханыг болон бусдыг хайрлах биднийг хайрыг харуулдаг талаар бодож үзэхэд урамшуул.

4-р хэсэг (5 минут)

Суралцагчдад Матай 5:14–16-г Матай 22:36–39-ийн хажууд, судрынхаа захад солбилцсон эшлэл болгон бичихийг санал болго. Аврагч Уулан дээрх номлолоороо бид Бурханыг болон бусдыг хэрхэн хайрлаж чадах талаар заасан гэдгийг тайлбарла. Суралцагчдыг Матай 5:14–16-г гаргаж, үүнийг төгс эзэмших сургаалын хэсэг болгон тэмдэглэхэд урь. Энэ шүлгүүдэд Аврагч эргэн тойрныхоо хүмүүсийг болон Бурханыг хайрлаж байгаагаа харуулах хамгийн чухал арга зам болох нэг зарлигийг шавь нартаа өгсөн гэдгийг тайлбарла.

Суралцагчдыг Матай 5:14–16-г дотроо уншаад, Аврагч шавь нартаа юу гэж заасныг олж мэдэхийг хүс.

- “Та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Матай 5:16) гэдэг нь юу гэсэн утгатай гэж та нар бодож байна вэ?
- Энэ төгс эзэмших сургаалын хэсэг нь хэрхэн бидэнд эргэн тойрныхоо хүмүүст сайн мэдээг хуваалцаж болох нэг арга замыг ойлгоход тусалдаг вэ? (Бид зарлигуудыг дагаж, зөв шударга үлгэр жишээ үзүүлэх юм бол эргэн тойрны хүмүүс маань бидний сонголт болон үүний үр дүнд ирэх адислалыг маань харж, сайн мэдээг хүлээн авахад илүү нээлттэй болж болно.)

Суралцагчдыг Матай 5:14–16-ийн хажууд **бид өөрсдийн сайн үлгэр жишээгээр дамжуулан бусдад сайн мэдээг зааж чадна** хэмээх зарчмыг бичихэд урь.

Суралцагчдаас тэд зарлигуудыг дагах сонголт хийсэн найз эсвэл гэр бүлийн гишүүнийхээ үлгэр жишээнээс сурч эсвэл хүчирхэгжиж байсан эсэхийг асуу. Хүсвэл цөөн суралцагчийг туршлагаасаа хуваалцахад урь.

Суралцагчдыг Иохан 14:15-ыг Матай 5:14–16-ийн хажууд, судруудынхаа захад солбицсон эшлэл болгон бичихэд урих талаар бод. Хичээлийн дундуур цаг гарвал энэ төгс эзэмших сургаалын үйл ажиллагааны нэгэн хэсэг болгон, бичиж авсан шүлгүүдээ олоход нь суралцагчдад тусалж, судрын эдгээр шүлгийг чээжлэх цагийг гаргаж өг.

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал дээрх “Зарлигууд” гэсэн сургаалын сэдэвт авч үзсэн зарчмуудын талаар гэрчлэлээ хуваалцаж, энэ хэсгийг дуусга.

Дасгал ажил (20 минут)

Дараах үйл ажиллагаа нь *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгээс мэдэж авсан гурван зарчмынхаа дагуу үйлдэхэд суралцагчдад тусална. Эдгээр зарчмыг суралцагчдад сануулахын тулд самбарт бичих нь тустай байж болох юм.

- *Итгэлээр үйлд*
- *Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.*
- *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийл.*

Суралцагчдыг *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал* дээрх “Зарлигууд” гэсэн сургаалын 9 дэх сэдвийг эргэн харахад уриад, дараа нь өсвөр насныханд өөрсдийн зорилгын талаар тодорхой ойлголтгүй бол дуулгавартай дагахад хэцүү байж болох ямар зарлиг байж болох талаар асуу. Тэдний хариултыг самбарт жагсаан бич.



Суралцагчдыг хос хосоороо ажиллаж, самбар дээрх зарлигийн жагсаалтаас нэгийг сонгоход урь. Хос бүрд дараах тарааж өгөх материалын нэг хувийг өгөөд, үүнийг уншиж, асуултынхаа хариултыг ярилцахыг хүс.

Итгэлээр үйлд.

- Бурхан яагаад бидэнд энэ тодорхой зарлигийг өгсөн болохыг ойлгохгүй байгаа хэн нэгийг итгэлээр үйлдэхэд урамшуулан дэмжихийн тулд та юу хийж болох вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

Иохан 14:15; Матай 5:14–16 ба Матай 22:36–39 дээр заасан сургаалыг дахин давт.

- Энэ хэсгүүд дээр заасан сургаал нь таны сонгосон зарлигийг илүү сайн ойлгоход хэн нэгэнд хэрхэн туслах вэ?
- Өөр ямар үнэн таны сонгосон зарлигуудын талаар дэлхийн гэхээс илүүтэй мөнхийн ойлголтыг өгөхөд туслах вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийл.

- Их Эзэний бошиглогчид таны сонгосон зарлигийг дуулгавартай дагахын ач холбогдлыг ойлгоход хэн нэгэнд тус болох юуг саяхан заасан бэ? (Та LDS.org болон Сүмийн сэтгүүлээс олж болох Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн хэлсэн үгийг дурдаж болно.)

Суралцагчдад энэ асуултуудыг ярилцах хангалттай цаг гаргаж өгсний дараа тэднийг жүжигчлэн тоглоход урь. Хос болгоноос нэг суралцагч гарч ирээд, Их Эзэн яагаад тэр хосын сонгосон зарлигийн дагуу амьдрахыг хүсдэг болохыг ойлгохгүй байгаа хувь хүний дүрд тоглоход урь. Нөгөө суралцагчийг итгэлээр үйлдэж чадахгүй байгаа хүнд зарлигийг мөнхийн талаас нь шинжлэн судлаад, зарлигийн талаар тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголт олж авахаар эрэлхийлэхэд нь туслахад урь. Суралцагчдад нөхцөл байдлаа жүжигчлэн үзүүлэх 10 минут гаргаж өг.

Суралцагчдад жүжигчлэн тоглох хангалттай цаг гаргаж өгсний дараа дараах асуултуудыг ангиараа ярилцах талаар бодож үз.

- Бид зарим зарлигийг ойлгохгүй юм уу дагахад хэцүү байгаа үед итгэлээр үйлдэхийг сонгож болох ямар арга замууд байгаа вэ?
- Та найзынхаа тодорхой зарлигийн талаарх асуулт эсвэл санаа зовж буй зүйлийг мөнхийн талаас шинжлэн судлахад нь хэрхэн тусалсан бэ?
- Та асуудалтай найзынхаа асуултад хариулахдаа эсвэл түүний илүү сайн ойлголтыг урамшуулан дэмжихийн тулд тэнгэрээс томилогдсон ямар эх сурвалжийг ашигласан бэ?

Тэднийг энэ үйл ажиллагаанд оролцсоноор олж авсан ойлголтоо хуваалцахад урьж, хичээлээ дуусга.

Төгс эзэмших сургаалын тойм

Суралцагчдыг Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын хэсгүүдийг уншаад, гэрчлэл бүхий сургаал, зарчим орсон нэг хэсгийг сонгоход урь. Тэднийг энэ сургаал эсвэл зарчмын талаар гэрчилж, тэдэнд үүний талаар гэрчлэлтэй болоход нь тусалсан туршлагаасаа хуваалцахад урь. Суралцагчдыг гэрчлэлээ хуваалцаж байхад гэрчилж байгаа сургаал, зарчмуудынх нь үнэнийг Ариун Сүнс батлах болно. Тэдний гэрчлэл итгэлтэй үйлдэхэд бусдыг сүнсээр өдөөж болно.



ШАШНЫ ИНСТИТУТ
БА СЕМИНАР

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN

